

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

---



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

---

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

---

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

## НЭГДСЭН ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Баасан гараг

|                                                                                                                                                                                                                                         |                |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>                                                                                                                                                                                                  | <b>1</b>       |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>                                                                                                                                                                                                       | <b>2 – 12</b>  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>                                                                                                                                                                                                | <b>13 – 98</b> |
| 1. <b>Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</b> | <b>14 – 17</b> |
| 2. <b>Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</b>                     | <b>17 – 19</b> |
| 3. <b>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/</b>                                                                                                    | <b>19 – 56</b> |
| 4. <b>Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>                                                                        | <b>56 – 64</b> |
| 5. <b>Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                                                | <b>64 – 98</b> |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
05 дугаар сарын 02-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.*

*Томилолттой: Х.Баасанжаргал, Д.Батлут, Б.Батцэцэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Т.Доржханд, Ц.Мөнхбат, Ч.Номин, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Б.Хэрлэн;*

*Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир;*

*Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, Ж.Баясгалан, Х.Болормаа, Ц.Даваасүрэн, П.Наранбаяр;*

*Тасалсан: Ж.Батсуурь, Ж.Баярмаа, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Л.Гантөмөр, Ч.Лодойсамбуу, Ц.Туваан, Х.Тэмүүжин, Р.Эрдэнэбүрэн;*

*Хоцорсон: М.Бадамсүрэн – 17 минут, Б.Батбаатар – 52 минут, Н.Батсүмбэрэл – 18 минут, Х.Булгантуяа – 13 минут, Б.Жавхлан – 22 минут, Д.Жаргалсайхан – 01 цаг 20 минут, Ж.Золжаргал – 05 минут, П.Мөнхтулга – 01 минут, Ц.Мөнхтуяа – 01 минут, З.Мэндсайхан – 02 минут, Б.Найдалаа – 02 минут, Д.Пүрэвдаваа – 21 минут, А.Ундраа – 01 минут, Н.Учрал – 07 минут, Г.Уянгахишиг – 02 минут, Д.Цогтбаатар – 04 минут, Ж.Энхбаяр – 01 минут.*

***Нэг.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны дарга М.Баттулга, Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундрага нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Л.Батмөнх, А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв.

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН  
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 40

Бүгд: 87

54.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Галбадрах, Х.Ганхуяг, М.Мандхай, З.Мэндсайхан, С.Замира, Ж.Чинбүрэн, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар, Н.Номтойбаяр, Г.Уянгахишиг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.**Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 31

Бүгд: 87

64.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас заасан зарчмыг баримтлан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл

бүхий хуулийн этгээд тогтооно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 53

Бүгд: 87

39.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 53

Бүгд: 87

39.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл, шаардлагыг Монголбанк батална. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадвар зэрэглэл тогтооход ашиглана.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 35

Бүгд: 87

60.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

## **“ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

### **Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл, шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-нд тус тус даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54  
Татгалзсан: 34  
Бүгд: 88  
61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 38  
Бүгд: 88  
56.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч О.Мандах, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга Н.Лхагвасайхан, мөн албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн ахлах байцаагч Б.Бодьгэрэл, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Ажиллагааны хэлтсийн дарга С.Лхагвадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн

байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв.

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 36  
Бүгд: 88  
59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 37  
Бүгд: 89  
58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 38  
Бүгд: 89  
57.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 40  
Бүгд: 90  
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 40  
Бүгд: 90  
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56  
Татгалзсан: 34  
Бүгд: 90  
62.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигч Б.Рагчаа, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий удирдлагын газрын дарга С.Золбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ж.Чинбүрэн, А.Ариунзаяа, У.Отгонбаяр, С.Зулпхар, Ц.Сандаг-Очир, Д.Ганмаа, Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа, М.Бадамсүрэн, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн



даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигч Б.Рагчаа нар хариулж, тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар С.Эрдэнэбатыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54  
Татгалзсан: 40  
Бүгд: 94  
57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Баяраагийн Рагчааг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56  
Татгалзсан: 38  
Бүгд: 94  
59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /11:47/

*Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**  
*/Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, мөн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Батмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө

аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, А.Ундраа нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг хариулж, тайлбар хийв.

*Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 45  
Татгалзсан: 49  
Бүгд: 94  
47.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 45  
Бүгд: 94  
52.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Төслийн 1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 42  
Бүгд: 94  
55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан: 2.**Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53  
Татгалзсан: 41  
Бүгд: 94  
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Д.Энхтүвшин, Т.Аубакир, М.Ганхүлэг, З.Мэндсайхан, Х.Булгантуяа, М.Бадамсүрэн, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

### **ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

#### **Нэг.Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “04 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “05 дугаар сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 46  
Бүгд: 95  
51.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

#### **Хоёр.Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээллийн 6 сарын дунджаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын үнэ өссөн тохиолдолд гурилын импортын албан татварыг чөлөөлөх хуулийн төслийг нэн даруй өргөн мэдүүлэх болон малын тэжээлийг импортын барааны гаалийн албан татвараас 5 хувь чөлөөлсөн харилцааг хэвээр үлдээх асуудлыг тусгасан Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 56

Бүгд: 95

41.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 3 цаг 35 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 95 гишүүн ирж, 75.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 35 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим  
10 цаг 00 минут

### ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая.

73 гишүүн ирцэд бүртгэгдэж, ирц 57.9 хувьтай болсон байна.

2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 5 асуудалтай. Шууд санал хураалт явахаар байгаа шүү. Гишүүд суудалдаа сууя.

Нэг.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёр.Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

---

**Нэг.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

---

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нэг өдрийн завсарлага авсан. Нэг өдрийн завсарлага авсан байгаа. Завсарлагын хугацаа 10 цаг 08 минутаар дуусна.

Одоо 10 цаг 01 минут болж байна. 7 минут хүлээх шаардлага гарч байна. Ардчилсан намаас төлөөлж орж ирж хугацаа дууссан талаар мэдэгдэл өгвөл сайн байна. Чуулганы хуралдаан үргэлжлэхэд хэрэгтэй байгаа.

10 цаг 08 минут болсон байна. Завсарлалын хугацаа дууссан. /алх цохив/

Завсарлага сунгах талаар асуудал дахиж яригдаагүй. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 8 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Гишүүд анхаарлаа хандуулаарай.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж.

Э.Батшугар гишүүний микрофоныг өгье.

**Э.Батшугар:** Эрхэм гишүүдэд өглөөний мэндийг хүргэе.

Дарга аа, үүнийг гүйцээн боловсруулах чиглэл авсан юм. Яагаад гэвэл Монголбанканд захиргааны хэм хэмжээний актыг нь баталгаажуулахын тулд Монголбанкнаас тогтоосон гэснийг нь баталсан гэж өөрчлөх ёстой байгаа л юм. Зүгээр найруулгын санал байгаа юм.

Тэгээд эцсийн хэлэлцүүлгээ дэмжээд явчихъя.

**Д.Амарбаясгалан:** Гүйцээн боловсруулах чиглэл авах эрх бүхий субъект нь санал гаргасан гишүүн эсвэл Эдийн засгийн байнгын хороо. Дэгээрээ. Тийм байх аа? Тамгын газраас. Ч.Дондогмаа дарга нэг тайлбар хийгээдхээч.

Санал хураалт. /алх цохив/

54 хувиар санал дэмжигдлээ.

З.Мэндсайхан, Ч.Анар, М.Мандхай, Ж.Галбадрах, Х.Ганхуяг, С.Замира, Ж.Чинбүрэн, Б.Дэлгэрсайхан, Дамдины Цогтбаатар, Н.Номтойбаяр, Г.Уянгахишиг гэсэн гишүүдийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

2.Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд. Санал хураалт. /алх цохив/

64.4 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй. Одоо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас заасан зарчмыг баримтлан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд тогтооно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. /алх цохив/



39.1 хувиар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа.

Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

39.1 хувиар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл, шаардлагыг Монголбанк батална. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадвар зэрэглэл тогтооход ашиглана.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

О.Батнайрамдал гишүүнд микрофон өгье.

**О.Батнайрамдал:** Даргаас саналаа татчихъя. Санал хураахгүй татаж байна.

**Д.Амарбаясгалан:** Санал татаж авлаа.

4.Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж.

Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл, шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороон /Т.Жамбаажамц/-д тус тус даалгасугай.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

61.4 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Түрүүн хуулийн төсөл дээр энэ саналыг дэмжээд явчихсан байгаа. Санал хураалт.

56.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

---

**Хоёр.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль**  
**/Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн**  
**хуулийн төслүүд**  
**/Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн,**  
**хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/**

---

Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

---

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 5 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг ажлын нэг өдрийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна. /алх цохив/

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргаас үг хэлэх хүсэлт ирээгүй байна. Ингээд хугацаа дууслаа.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. /алх цохив/

59.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

58.4 хувиар санал дэмжигдлээ.

3.Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

57.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Цагдаагийн албан албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

62.2 хувиар санал дэмжигдлээ.

Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

---

**Гурав.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн  
даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал  
/үргэлжилнэ/**

---

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нэг өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. /алх цохив/

Ардчилсан намын бүлгээ бүлгийн дарга О.Цогтгэрэлээс үг хэлэх хүсэлт ирээгүй тул дуусгавар болголоо. /алх цохив/

Нэр дэвшигчийн талаар гаргасан Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна.

Индэрт урьж байна.

**Д.Үүрийнтуяа:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 04 сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

---

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1.3</sup> дахь хэсгийг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монгол үйлдвэрчний эвлэлийн холбооноос Монгол үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд ерөнхийлөгч Баяраагийн Рагчааг Улсын Их Хуралд санал болгосон.

Байнгын хороо Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1.3</sup> дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйлүүдийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Лхагвасүрэнгийн Хоролсүрэнг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар томилсон. Хараат бус шинжээч нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг, ганцаарчилсан ярилцлага хийсний үр дүнд нэр дэвшигч Баяраагийн Рагчааг мэргэжлийн хувьд шалгуур хангахгүй ч мэдлэг, туршлага, ур чадвар, ёс зүйн шаардлага хангаж байгаа талаарх дүгнэлтээ сонсголд танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор хуралдаан оролцсон гишүүд хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар нэр дэвшигч Б.Рагчааг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан хэмээн үзсэн болно.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулан, Улсын Их Хурлын нийт гишүүд болон нэр дэвшигч, түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын уялдаа холбоог хэрхэн хангах талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Б.Бейсен нар Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний үүргээ биелүүлэх, эмнэлгийн эмнэлгүүдэд тулгамдаж буй асуудлуудад санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар анхаарч ажиллах талаар Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Эрүүл мэндийн даатгалаар санхүүжиж буй сувилал, уламжлалт эмнэлэг, сэргээн засах төвийн тусламж, үйлчилгээний үнэлгээг ялгах, уялдаа холбоог сайжруулах, Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл

мэндийн хөтөлбөртэй уялдуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн групп тогтоолгох болон сунгахдаа өгдөг эрүүл мэндийн мэдээллийг ашиглан тэдгээр хүмүүст ямар тусламж, үйлчилгээг үзүүлэх нь оновчтой талаар анхаарч ажиллах Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат шийдвэр гаргахаас өмнө тухайн нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт зардлаа дийлэхгүй байгаа талаар хамгийн оновчтой зардлын хуваарилалтыг хийх, хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн хүнд өвчтэй иргэнд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах, даатгалын мөнгөөр эмнэлгүүдэд засвар үйлчилгээ хийж байгааг анхаарах зэрэг асуудлаар тус тус үг хэллээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монгол үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн Баяраагийн Рагчааг томилох, Үндэсний зөвлөлийн гишүүнээс Сүхбаатарын Эрдэнэбатыг чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшсэн нэр дэвшигчийн танилцуулга, хараат бус шинжээчийн дүгнэлт сонсголын тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн, хуралдаан даргалагч Х.Болормаа гэсэн байна.

**Д.Амарбаясгалан:** Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Баяраагийн Рагчаа хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя.

Сундуйн Золбаяр Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий удирдлагын газрын дарга.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Нийт 11 гишүүн нэр өглөө. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

**Н.Наранбаатар:** Гишүүдэд өглөөний мэнд хүргэе.

Саяхан сонгогдсон тойрогтоо ажиллаад говийн бүсийн аймаг, сумдуудаар ажилласан. Ялангуяа аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдээр ажиллаад явж байхад бүгд бараг 100 хувь шахуу даатгалын санхүүжилттэй холбоотой асуудлыг ярьж байна. Тухайлах юм бол Дундговь аймгийн Сайнцагаан сумын Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн ажил байдалтай очиж танилцсан.

Тэгэхээр энэ оны санхүүжилт нь эхний 10 сарын байдлаар санхүүжүүлэлт нь хийгдээд тэгээд сүүлийн хоёр сардаа санхүүжилт байхгүй. Өнгөрсөн жил мөн ялгаа байхгүй. Тэгээд үүнээсээ болоод иргэдээс төлбөр, хураамж авдаг. Иргэдэд бухимдал үүсдэг, хүндрэл чирэгдэл үүсдэг ийм асуудлууд үүсээд байх юм. Тэгээд энэ ганц аймагт биш нэлэнхүйдээ даатгалын санхүүжилттэй холбоотой хязгаар тавьсан гэдэг асуудал ярьж байгаа. Хязгаартай холбоотой асуудал түгээмэл байгаа юм.

Тийм учраас Та бүхэн энэ дээр хариулт хэлээч. Даатгал нь энэ жил яаж батлагдсан юм бэ? Үнэхээр дутуу. Нийт эмнэлгийнхээ санхүүжилт хүрэхээргүй дутуу батлагдчихсан юм уу? Энэ санхүүжилт нь юунаас болоод тасраад байгаа юм бэ? Тэгээд үүнийг шийдвэрлэх талаар ямар ажил хийж байгаа юм бэ? Энэ талаар тодорхой мэдээлэл өгвөл сайн байна.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Л.Энх-Амгалан сайд Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Тийм. Т.Мөнхсайхан сайд. Уучлаарай. Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Эрүүл мэндийн даатгалын сан ер нь ковидын дараа нэлээн хүнд нөхцөл байдалд орсон. Ковидын үед санхүүжилт нэлээн ихээр гарсан.

Ингээд Эрүүл мэндийн даатгалын сан эмнэлгүүдэд 300 гаруй тэрбум төгрөгийн өглөгтэй байсан. Энэ өглөгийг энэ жил өгч барагдуулж дууссан. Энэ дээр сумын эрүүл мэндийн төвийн удирдлагуудад маань нэг жоохон буруу ойлголт байгаад байгаа.

Бид сумын эрүүл мэндийн төв дээр шаардлагагүй хэвтэлтүүдийг багасгаад илүү их нэг иргэн талд нь санхүүжилтийг нь нэмээд өгсөн юм. Одоо бараг улсын хэмжээнд бүх сумын эмнэлгүүдийн энэ оны санхүүжилт нэмэгдсэн. Гэхдээ 4 төрлийн гүйцэтгэлээр олгодог санхүүжилт нь багассан. Тэр багассан санхүүжилтийг нэмэгдүүлээд нэг иргэн талд нь нэмээд өгсөн.

Энэ нь юу гэсэн үг гэхээр эмнэлэгт хэвтэх шаардлагагүй хүмүүсийг сумын эрүүл мэндийн төв дээр дуудаж ирээд хэвтүүлж эмчлүүлээд ингээд Эрүүл мэндийн даатгалын сангаас мөнгө авахаар тэр хүнийг эмчилсэн хоол эм тариа гээд зардал их гараад шаардлагагүй хэвтэлтүүд их болоод байсан. Тэгэхээр бид



нар энэ шаардлагагүй хэвтэлтүүдээ бууруулах зорилгоор нэг иргэн талд нь санхүүжилтийг нь нэмээд тэндээсээ эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө, урамшууллаа өгөх боломжийг нь бүрдүүлээд өгчихсөн. Нөгөө талдаа хэвтэлтээ багасгаад нэн шаардлагатай хэвтэлтүүдээ хэвтүүлээд тусламж, үйлчилгээгээ үзүүлээд явах юм бол эмнэлэгт нь эмнэлэгт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчид илүү их өгөөжтэй байх энэ зохицуулалтыг хийж өгсөн юм.

Тэгэхгүй болохоор манайх чинь Эрүүл мэндийн даатгалын санг шаардлагагүй хэвтэлтүүдэд их зарцуулж байна. Одоо хавар болохоор ядардаг, бид нар эмнэлэгт хэвтэх ёстой гээд эмнэлэгт хэвтээд дусал тариа хийлгэдэг. Энд Эрүүл мэндийн даатгалын сангийн ихэнх мөнгө нь зарцуулагдаад нэн шаардлагатай тархи, зүрхний шигдээс харвалтын үед өгөх санхүүжилт нь оны төгсгөл рүү байхгүй болчихоод байгаа энэ зүйлийг бид засаж залруулах ажлаа хийсэн.

Түүнээс биш Эрүүл мэндийн даатгалын сан ямар нэгэн байдлаар хоосорсон юм уу, дампуурах гэж байгаа юм уу. Тийм зүйл огтоосоо байхгүй. Энэ онд Эрүүл мэндийн даатгалын сан 2.3 их наядын санхүүжилт олгогдсон. Үүнээсээ эхний улирлуудад 700 орчим тэрбум төгрөг нь олгогдчихсон. Одоо Эрүүл мэндийн даатгалын санд 1.6 орчим их наяд төгрөгийн санхүүжилт байна.

Үүнийгээ бид бүх улсын, хувийн өрхийн сумын нэгдсэн лавлагаа шатлалын бүх эмнэлгүүддээ ямар хэмжээний тусламж, үйлчилгээ үзүүлэх вэ гэдэг зохицуулалтаар нь хуваарилаад сар болгон зохицуулалтаа, хамгийн гол нь санхүүжилтийг хянаж явж байгаа.

Бид санхүүжилтийнхээ өгөөжийг сайжруулаад, хяналтаа сайжруулаад санхүүгийн сахилга батаа дээшлүүлж байгаа гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

**Ж.Чинбүрэн:** Бид бас энэ Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонсдог болсноороо бас нэг том дэвшил гарч байна.

Би нэр нь дэвшиж байгаа, нээлттэй сонсголд орж байгаа хүнд зориуд анхааруулж хэлэх гэж байгаа зүйл байна. Тухайлах юм бол, Т.Мөнхсайхан сайдын хөнгөлөлттэй эм баахан дураараа худалдаад авчихсан тухай ярих гэж байна.

Хуулийн процессоо зөрчсөн. Тэгээд дээрээс нь одоо бүр Сангийн яам, Эдийн засгийн яамтай үнийн дээд хязгаараа хамтарсан гурван яамныхаас гурван сайдын журам, тогтоол нь ч гараагүй. Тэгээд л нэг компанитай очоод л гэрээ хийчхээд л тэрийгээ зөвтгөөд л.

Энэ чинь Монголд хууль засагладаг юм шүү. Тэгэхээр нэр дэвшиж байгаа улсууд Та бүхэн анхаараарай. Одоо жишээлбэл Эрүүл мэндийн даатгалын



үндэсний зөвлөлийн тогтоол гээд энэ нэг юм байж байна. Энэ 2022 оны 07 сарын 04-ний тогтоол. Үүнийг нөгөө С.Энхболд сайд байхдаа гаргасан тогтоол.

Энэ тогтоол дээрээ Захиргааны ерөнхий хуулийн 59.2-т зааснаар ЭМДҮЗ өөрийн эрхээ бусдад шилжүүлсэн. Энэ чинь одоо бүр замбараагаа алдаж байна шүү дээ. Энэ чинь. Хуулиар олгогдохоос бусад тохиолдолд эрхээ шилжүүлэхийг нь хүртэл хориглосон байгаа шүү дээ. Тэгээд Т.Мөнхсайхан сайд 2025 оны 03 сарын 17-нд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх гээд өөрөө тогтоолд өөрчлөлт оруулах тухай гаргачхаад, тэгээд тэрийгээ гарч амжаагүй байхад л нөгөө эмийг нь хөнгөлөөд л. Солонгосын нөгөө 5 компаниас авсан 23 эмээ хөнгөлөөд яваад байгаа шүү дээ. Энэ чинь хуулийн процессоо зөрчөөд байна.

Тийм учраас Үндэсний зөвлөлийн гишүүд Та бүхэн хэрвээ сонгогдоод ажиллавал энэ хуулиа анхаарч хардаг бай. Энэ хууль бус юмыг шаарддаг дарга нарын үгэнд битгий ороо. Хуулиа биелүүлдэг бай.

Энэ чинь ямар дураараа тэгээд л хэдхэн компанитай ярьчихаад л, тэгээд л одоо даатгалын хөнгөлөлтөөр олгож байгаа эмийг бид одоо аль болохоор л их болгож, ард иргэдээ архаг өвчнөөсөө эмнэлэгт хэвтэхгүй байх боломжийг нь олгох гээд л хөнгөлөлтүүд 170 тэрбум болтол нь босгоод өгсөн байгаа шүү дээ. Одоо.

Тэгэхэд би багахан худалдан авалт хийсэн гээд л Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийнх нь дарга нь яриад сууж байх юм. Энэ чинь бүх юм журам процессоороо яв л даа. Энэ дээр ЭМДҮЗ бүр онцгой анхаарч байх ёстой шүү дээ.

Та эрхээ шилжүүлэх эрхгүй. ЭМДҮЗ-ийн хамтарсан шийдвэрээрээ энэ үнийн дээд хязгаар, жагсаалтаа бүгдийг нь шинэчилж батлах ёстой шүү. 2022 оноос хойш одоо хүртэл батлагдаагүй явж байгаа шүү. Үүнийг анхаараарай.

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Үгүй одоо энэ та ажлын хэсгийг нь ахлаад ингээд шинэчлэн, найруулагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль дээр заасан тэр зүйл, заалтын дагуу л бүх үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Тэгээд хэрвээ ямар нэгэн хууль зөрчсөн процесс байгаа бол та үүнийгээ тэр хууль хяналтынх нь байгууллагад өгөөд сайхан шалгуулчих л даа. Тэгэхгүй та манай эрүүл мэндийн салбарын хүн. Тэгээд эрүүл мэндийн салбараа болж

бүтэхгүй байгаа юм шиг юмыг байнга яриад сошиалаар ажлаа хийгээд явуулаад байхаар чинь салбарын нэр хүнд унаад байна шүү дээ.

Та үнэхээр тийм процессын алдаа гаргасан зүйл байгаа бол сайхан хууль хяналтынх нь байгууллагад өгүүлээд шалгуулчих л даа. Танаас үүнийг хүсэх байна.

Бид нарын оруулж ирсэн юм. Би одоо нэг эмнэлэгтээ Солонгос руу очиж юутай эрүүл мэндийн үйлдвэртэй надад гэрээ хийсэн тийм зурсан зүйл огтоосоо байхгүй гэдгийг би танд хэлээд байгаа шүү дээ.

Бид гадаадын Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн улсуудад очиж үйлдвэрүүдэд шинэчлэгдсэн эмийнхээ хууль, бодлогыг танилцуулах ёстой. Үүнийг танилцуулсны үндсэн дээр гаднын үйлдвэрлэгч чанартай эмийг үйлдвэрлэгч улсууд манай улсад хямд үнээр эмээ өгөх боломж бүрдэж байгаа. Үүний үр дүнд иргэдэд үр дүн нь хүрээд иргэд энд маш их сайшаалтай байгаад байна шүү дээ.

Одоо сахарын эм гэхэд ахмадууд нэг сар авч уугаад дараа сард нь тэтгэврийнх нь мөнгө нь хүрэхгүй авч ууж чаддаггүй байсан бол энэ карманаас нь 60 мянган төгрөг гардаг байсныг 6600 боллоо. Өмнөх эмээсээ үйлчилгээ нь сайжирлаа. Цус шингэлэх эмийг зүрхний стент тавиулсан хүмүүс сар болгон уудаг 170 мянган төгрөг карманаасаа төлдөг байсан бол 17 мянган төгрөг төлөөд үүнийгээ авдаг, уудаг боллоо. Иргэд, эмч нар бүгдээрээ сэтгэл ханамжаа илэрхийлээд байна.

Энэ чинь ингээд зогсох юм биш. Манай улсад чанаргүй байгаа, үнэтэй байгаа эмүүд цааш нь бүгдийг нь үргэлжлүүлээд 2026 оны төгсгөл гэхэд бид чанаргүй байгаа эмүүдийг зах зээлээс гаргах, боломжийн хямд чанартай бүтээгдэхүүнүүдээр хангах бодлого маань маш амжилттай үргэлжлээд явж байна. Тэгээд ард иргэдэд таашаалтай энэ бодлого маань хүрээд байгаа нь танд яагаад таалагдахгүй байгааг би ойлгохгүй байна.

Үнэхээр хууль зөрчсөн тиймэрхүү зүйл байгаа бол та үүнийгээ хууль хяналтынх нь байгууллагаар сайхан шалгуулаарай гэж хэлье.

**Д.Амарбаясгалан:** Ж.Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

**Ж.Чинбүрэн:** Би өчигдөр Монгол Улсын ерөнхий прокурорт өгчихсөн. Тийм.  
Тийм учраас санаа зоволтгүй өгчихсөн байгаа.

Хоёрт, зөвхөн дангаараа өгдөг Дапаглифлозин /Dapagliflozin/ 6 мянган төгрөг болсон болохоос Форсига /Forxiga/ хосолмол найрлагатай эм 6 мянга болоогүй шүү дээ.

Тийм учраас үүнийг бас тодорхой яриарай.

Хоёрт, энэ “эрх шилжүүлэх тухай” гэдэг нь Захиргааны ерөнхий хуулийн 59.2-ыг яриад байгаа шүү. Захиргааны хуулийн 59.2. Би өөрт чинь уншаад өгчихье.

Хуулиар тусгайлсан эрх олгочихсон захиргааны байгууллага хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Тэгэхээр би өөртэй чинь бол нөгөө хувь хүний асуудал биш энэ. 3.5 сая иргэнд хууль үйлчилж, зөв эмүүдээ зөв үнийн дээд хязгаараа тавь гэж яриад байна шүү дээ. Ойлгож байна уу? Үнийн дээд хязгаар Сангийн яамтайгаа, Эдийн засгийн яамтайгаа батлах ёстой шүү дээ. Та өөрөө очоод батлаад байх чинь буруу байна гэж хэлээд байна шүү дээ. Алдаагаа ойлгохгүй байх чинь яасан харамсалтай юм бэ.

**Д.Амарбаясгалан:** Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

**А.Ариунзаяа:** Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох асуудал маш чухал юм. Яагаад гэвэл эдгээр зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын сангаас юунд санхүүжилт олгогдох вэ, шимтгэл хураамж нь ямар байх вэ, зөв зохистой явагдаж байна уу, үгүй юу гэдэг дээр хяналт тавьдаг ийм зөвлөл юм.

Тэгээд энэ асуудал бас дахиад л Ардчилсан намын гишүүд маань өчигдөр ч хүний эрхийн асуудлаар дуугарч чадсангүй. Өнөөдөр ч бүх нийтийн эрүүл мэндийн асуудал бас дуугарч чадахгүй байгаа. Нэг хүнээс болж бусад гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаад энэ гишүүдийн өмнөөс бас харамсаж байгаагаа хэлье.

Б.Бейсен гишүүнээс авхуулаад Нийгмийн бодлогын байнгын хороон дээр үнэхээр энэ асуудалд санаа зовж, эрүүл мэндийн салбарын цаашдын алдаа дутагдлыг засаж залруулах, хөгжилд нь анхаарсан маш олон Ардчилсан намын гишүүд байгаа гэдгийг энд хэлэх нь зүйтэй байх.

Б.Рагчаагийн хувьд хараат бус шинжээч ганцаарчилсан ярилцлага хийгээд мэргэжлийн хувьд шалгуур хангахгүй ч гэсэн мэдлэг туршлага, ур чадвар, ёс зүйн хувьд шалгуур хангана гэж үзсэн. Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд энэ саналтай санал нэгдэж 100 хувийн саналаар чуулганд оруулж байгаа.

Тэгээд үндсэндээ гол санаа нь юу юм бэ гэхээр Үйлдвэрчний эвлэлийг буюу одоо ажилтныг төлөөлж орж ирж байгаа дуу хоолой гэдгээр нь бас дэмжиж байгаа юм. Үйлдвэрчний эвлэлийн дэд ерөнхийлөгчөөр 2021 оноос хойш

ажиллаж байгаа энэ том масс ажилтны дуу хоолойг хүргэх нь маш чухал. Яагаад гэвэл бид бас энэ сангаас үйлчилгээ хүртэж байгаа учраас.

Ер нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдэд тавигддаг шалгуур хэн хэн байх вэ гэдгийг эргэж дахиад хуулиараа зохицуулалтыг хийхгүй бол албан тушаалаараа орж байгаа хүмүүсийг албан тушаалаар нь заамаар байна. Түүнээс биш дахиад сонгон шалгаруулалт оруулж ирүүлээд л, юу гэдэг юм үйлдвэрчний эвлэлээс нэг л хүнийг санал болгож оруулж ирлээ шүү дээ. Энэ дээр бид ямар ч шалгуур хийж чадсангүй. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр бас нэг хүнийг оруулж ирсэн. Энэ дээр бас болохгүй байна гээд өөрөө мэдрээд өөрөө одоо нэрээ эргүүлэн татсан байгаа.

Тэгэхээр цаашлаад Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүдийн тавигдах шалгуурыг нь дахиад өөрчилж арай өөр шинэ түвшинд гаргахгүй бол үнэхээрийн болохгүй байна гэдгийг Т.Мөнхсайхан сайдад бас далимд нь хэлчихье. Энэ маш чухал асуудал. Үүнийг өөрчлөх хэрэгтэй.

Нөгөө талдаа Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал, байнга сүүлийн ковидоос хойш 4 жилийн хугацаанд дандаа хасахтай гарч байгаа асуудал нь зөвхөн Эрүүл мэндийн яамны ч асуудал биш. Энд бас Сангийн яам анхаараасай гэж хүсэж байна.

Яагаад гэхээр бид ер нь аливаа нийгмийн даатгал ч байна уу, Эрүүл мэндийн даатгал ч байна уу, татвар ч юм шиг, халамж ч юм шиг ийм буруу ойлголттой байгаад ердөөсөө энэ бодлогын алдаа яваад байна. Энэ уг нь шимтгэл төлж байгаа иргэд эргүүлээд нийгмийн хамгааллын үйлчилгээ авч байгаа асуудал байхгүй юу.

Тэгэхээр ямар нэгэн байдлаар төр өөрөө даах ёстой урсгал зардал байдаг санж уу, цалингийн нэмэгдэл урамшуулал байдаг санж уу өөрсдөө төрийн албан хаагчдыг ажиллуулж байгаа бол тэдгээрийн нэмэгдлийг төсвөөсөө даа. Яагаад шимтгэл төлөгчдийн төлж байгаа шимтгэлээс, энэ сангаас тухайн урсгал зардлыг гаргаад байгаа юм? Яагаад ковидын үед. Тухайн үед яах вэ, нөхцөл байдал хэцүү байсан байж болно. Тоног төхөөрөмж авсан шүү дээ. Тэр авсан тоног төхөөрөмжийнхөө зардлыг нийгмийн даатгалын сан байдаг юм уу, Эрүүл мэндийн даатгалын санд буцааж төвлөрүүлэх ёстой. Төсвөөсөө энэ мөнгийг буцааж өг. Энэ бол шимтгэл төлөгчдийн мөнгө болохоос биш төсвийн өөрөө дур мэдэн улс төрчдийн зарцуулдаг асуудал огтоос биш. Энэ дээр анхаарах шаардлагатай байгаа.

Төр өөрөө хийж чадахгүй байсан ажлыгаа 13-ын “А” маягт. Бүртгэлээ хийж чадахгүй, цахимжуулалтаа хийж чадахгүй асуудал үүссэн чинь ерөөсөө больё гээд хүчингүй болгосон. Үүнээсээ болж маш их асуудал үүсэж байгаа. Үүнийгээ хуучин цаасан уламжлалаараа ч бай хамаагүй эргээж сэргээх шаардлагатай байна. Сэргээх шаардлагатай байна. Энэ бодлогын алдаанууд ерөөсөө эндээсээ яваад байна. Энэ дээр бодлого байна уу?

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** 13-ын “А” маягт байхгүй болсноор анхан шат, дүүргийн эмнэлгүүдэд ачаалал тэнцүү хуваарилагддаг байсан зүйл маань улам хүнд байдалд орсон.

Бүх хүмүүс лавлагаа шатлалын төв эмнэлгүүд, 1, 2, 3 дугаар эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв гээд төв эмнэлгүүдэд шууд өөрсдөө очиж үзүүлдэг. Гэтэл тэр нь сум, өрхийн эмнэлэг, дүүрэг, аймгийн эмнэлэгт үзүүлээд эмчлүүлчих боломжтой зүйлүүд маань хэт төвлөрлийг дахин бий болгох ийм асуудал үүссэн.

Гэхдээ энэ 13-ын “А”-г бид цаасан хэлбэрээр явуулах нь иргэдэд их түвэг чирэгдэлтэй байгаа.

Тэгэхээр эрүүл мэндийн салбарын цахимжилт ер нь нэг суурь том өөрчлөлтийг хийж байгаа. Иргэд ер нь төрсөн цагаасаа авхуулаад нас барах хүртэлх бүх мэдээ мэдээлэл нь хадгалагдаж байдаг. Үүнийг шаардлагатай бол эмч нь харах боломжийг бүрдүүлж байгаа.

Тэгээд энэ хүрээнд 13-ыг “А”-г бид бүрэн утгаар нь цахим болгож байгаа. Одоо ингээд 6 сарын 01-нээс бид ер нь туршилтын хугацаа дуусаад үүнийгээ нэвтрүүлээд ирнэ.

Ингэхээрээ өрх, сумын эмнэлэгт очиж үзүүлсэн хүмүүс дараагийн шатлалын эмнэлэгт очиход хэн гэдэг эмчид хаана, хэдэн цагт очиж үзүүлэх вэ гэдэг цагийг нь анхан шатны эмнэлгүүд нь өөрсдөө авч өгөөд явуулдаг, эзэнтэйгээр явуулдаг болгох.

Тэгэхгүй бол өнөөдөр сум, өрхөөс, ингээд та улсын 1 дүгээр төв эмнэлэгт очиж үзүүлэх юм байна гээд л явуулдаг. Нөгөөдүүл нь орон нутгаас ирээд цагаа авах гэж долоо хонодог. Цагаа аваад үзүүлээд долоо хонодог. Дахиад шинжилгээгээ өгөх гэж долоо хонодог. Ингээд нэгээс хоёр сарыг Улаанбаатар хотод өнгөрүүлээд, энэ хүний санхүү, эдийн засаг, мөнгөний хувьд асар их хүндрэл чирэгдэл учирч байгаа юм.

Тэгэхээр үүнийг шийдэх шийдлийг бид гаргасан. Энэ маань 6 сарын 01-нээс хэрэгжээд эхэлнэ. Бүрэн гүйцэд биеллээ олоод ард иргэдэд 100 хувь хүртэл, ирэх оны дунд гэхэд энэ маань 100 хувь биеллээ олно гэж тооцоолж төлөвлөж ажиллаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

**А.Ариунзаяа:** 13-ын “А” маягтыг сэргээж байгаа гэдгийг сонсоод миний хувьд баяртай байна.

Улс төр гэдэг юм уу, иргэдийн эсэргүүцлээс битгий няцаж эргэж ухраарай. Төр гаргасан шийдвэрийг гаргахаасаа өмнө маш сайн судалж, гаргасныхаа дараа тэр шийдвэр дээрээ бат зогсдог байх хэрэгтэй байгаа шүү.

Т.Мөнхсайхан сайд аа, би бас нэг юм хэлээд байгаа. Ер нь ёс зүйн хувьд тэр өөрөө санаачилгаараа энэ хяналтын чиг үүргээ өөрөө зөвшөөрлийг нь өгдөг бол өөрөө эргээд хянадаг, өөрөө эргээд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийг тэргүүлдэг. Эргээд өөрийн өөртөө чиглэл өгдөг энэ байдал чинь хоорондоо зөрчилдөөд байдаг учраас цаашид эмийн хяналт дээр би бас хэлж байсан. Тийм ээ. Эмийн хяналтын асуудлаа тусад нь гаргаж эм хүнсний хяналт гэж хяналтын асуудлаа тусад нь гаргахгүй бол таныг хянаж буруу байсан ч гэсэн таны доор байгаа агентлаг, удирдлага доор байгаа хүмүүс хэзээ ч зөв алдаа дутагдлыг нь гаргаж хэлж чадахгүй учраас энэ хяналтын чиг үүргээ тусад нь өөрөөсөө холдуулж салбараасаа гаргах хэрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийг өөрөө тэргүүлээд, эргээд өөрийн өөртөө чиглэл өгөөд, өөрөө хэрэглэгчид нь байж эрүүл мэндийн салбарынхан өөрсдөө дахиад нөгөө нэг карманаасаа нөгөө карман руу гэдэг шиг ийм ашиг сонирхлын зөрчил үүсээд байгааг бас анхаараасай.

Цаашид Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн чиг үүргийг илүү баталгаажуулж, илүү мэргэжлийн түвшинд байлгаж, өөрийнхөө ашиг сонирхлыг хардалтад өртөхгүй байх үүднээс зөв голдиролд нь оруулах тал дээр нь манлайлж ажиллаарай гэж хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууя.

**У.Отгонбаяр:** Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа Баяраагийн Рагчааг дэмжиж байгаа.

Их Хурлаар дэмжигдээд Үндэсний зөвлөлийн гишүүн болбол энэ бүтцийн чиглэлээр, тэр дундаа энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн хяналтын чиглэл рүү ямар ажил санаачилж хийх вэ гэж би танаас бүр маш тодорхой асуулт асуумаар байна. Яагаад гэвэл та даатгуулагчийг төлөөлж Үндэсний зөвлөлд гишүүнээр нэр дэвшиж байгаа.

Тийм учраас хяналтын механизм дээр даатгуулагчийг төлөөлж орж байгаа гишүүний хувьд цаашдаа ямар ажил хийж санаачилж явах вэ нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт танд Эрүүл мэндийн даатгалын сангийн бүрдүүлэлт дээр цаашдаа бас ямар ажил төлөвлөж бодож байгаа вэ? Энэ хоёр дээр та тодорхой өөрийнхөө бодож санаж байгаа зүйлийг даатгуулагчийг төлөөлж орж



байгаа нэр дэвшиж байгаа гишүүнийхээ хувьд нэг тодорхой мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

Би яагаад үүнийг бас тодруулж асууж байна гэвэл Улсын Их Хурлын даргын 113 дугаар захирамжаар Эрүүл мэндийн даатгалын сангийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санал боловсруулах, шаардлагатай бол хууль санаачлах ийм эрх бүхий ажлын хэсгийг миний бие ахалж байгаа.

Тийм учраас сүүлийн хэдэн сар ажлын хэсгийн хуралдааныг 8, 9 дэх удаа, сая хамгийн сүүлд 9 дэх удаагаа зохион байгуулсан. Тэгээд цаашдаа Эрүүл мэндийн даатгалын сан дээр нэлээдгүй зарчмын, бүтцийн болон сангийн бүрдүүлэлтийн чиглэлээр бас нэлээдгүй санал гарах байх.

Тийм учраас энэ дээр бас таны саналыг сонсмоор байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Нэр дэвшигч. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

**Б.Рагчаа:** У.Отгонбаяр гишүүний асуултад хариулъя.

Ер нь хяналтын тогтолцоог тавих нь даатгуулагчийн төлөөлж орж байгаа Үндэсний зөвлөлийн гишүүний нэг номерын үүрэг гэж ойлгож байгаа.

Тэгээд хяналтын тогтолцоог нэг номерт ямар байдлаар энэ хяналтын тогтолцоог тавих вэ гэх юм бол ер нь даатгуулагч иргэдийг шууд өөрсдөө хяналт тавих тэр тогтолцоог л бүрдүүлэх нь хамгийн чухал гэж харж байгаа юм. Наад зах нь эрүүл мэндийн байгууллагууд дээр хяналт тавих, санал хүсэлтээ өгөх тэр о цахим орчныг бүрдүүлэх шаардлага байна уу гэвэл байна гэж харж байгаа.

Өнөөдөр и-монголиа гээд цахим аппликэйшнүүд бий боллоо. Үүгээрээ бид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан зардалтай холбоотой, чанар хүртээмжтэй холбоотой саналыг авах тэр механизмыг бүрдүүлэх бүрэн боломжтой гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт, үйлдвэрчний эвлэлийн байгууллага буюу нийт даатгуулагчийг төлөөлж олонхыг төлөөлж байгаагийн хувьд эрүүл мэндийн байгууллагууд дээр бид өөрсдийнхөө хэмжээнд QR код ажиллуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтүүдийг манай Эрүүл мэндийн даатгалыг төлөөлж, даатгуулагчийн төлөөлөлд оролцож байгаа энэ хүмүүсээрээ дамжуулж бид бас санал хүсэлт болон чанар хүртээмжтэй холбоотой зүйл дээр бид санал авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад санал, хүсэлтийг уламжилж ажиллаж байх.

Хоёр дахь асуулт нь гэх юм бол ер нь төсвийг бүрдүүлэхэд олон талт арга хэмжээ авах хэрэгтэй юм байна.

Нэгдүгээрт, даатгалын тогтолцоог улс төрөөс ангид байх гэдэг зүйл дээр нэгдүгээрт голлон анхаарах хэрэгтэй. Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр бас мэргэжлийн хүмүүстэй зөвлөж мэргэжлийн хороо, баг бүрдүүлж ажиллах нь нэг талдаа зөв болов уу гэж.

Хоёрт, төрөөс эрүүл мэндийн баримтлах бодлогын баримт бичиг дээр дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүрэх ёстой гэж. Өнөөдөр Монгол улсад одоо 3 хүртэл байгаа.

Тэгэхээр улсын төсөв батлахад хүртэл бас Эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой холбоотой эрүүл мэндийн салбар луу чиглэсэн энэ асуудал дээр 5 хувьд хүрэх жишиг рүү ойртуулах шаардлага байна уу гэвэл байгаа гэж харж байгаа.

Гуравдугаарт нь, мөн ялгаа байхгүй Засгийн газрын зардал гэж байна. Нийт Засгийн газрын зардлын дунджаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг дээр 12 орчим хувь байх ёстой гээд заасан мөртлөө өнөөдөр 9 орчим хувь дээр байж байгаа юм.

Тэгэхээр төрөөс тодорхой хэмжээний зардал мөнгийг тодорхой хэмжээнд эрүүл мэндийнхээ даатгалыг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх тал дээр төрөөс тодорхой хэмжээний төсөв санхүү дээр нь оруулах ёстой гэж харж байгаа.

Хоёрдугаарт, ер нь иргэний өөрсдийнх нь хариуцлагын асуудлыг бас ярих ёстой гэж бодож байгаа. Магадгүй жишээ болгоод хэлэхэд өөрийн буруутай үйл ажиллагаанаас архидан согтуураад, шартаад ингээд хэвтчихсэн ийм хариуцлагагүй байдлаас болоод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд тэр хүн, иргэнээс бас гарах.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** У.Отгонбаяр гишүүн тодруулж асууя.

**У.Отгонбаяр:** Ер нь яг ний нуугүй хэлэхэд Б.Рагчаа мэдээ мэдээлэл ер нь жоохон хоцрогдмол маягтай байна шүү.

Тэгээд хэрвээ гишүүнээр сонгогдоод Үндэсний зөвлөлд орж ажиллавал цаашдаа бас нэг зүйл дээр анхаарч ажиллаарай гэдгийг би бас захиж хэлмээр байна.

Одоо Эрүүл мэндийн даатгалын сан дээр нэлээн том дата бааз бий болсон байгаа. Энэ дата баазыг энэ актуар тооцооллыг Эрүүл мэндийн даатгалын сан руу зайлшгүй нэн даруй нэвтрүүлэх шаардлага байгаа шүү. Энэ дээр Үндэсний зөвлөлийн гишүүн болоод орвол энэ дээр дуу хоолойгоо гаргаж ажиллаарай. Яагаад би үүнийг хэлж байна гэхээр та бол даатгуулагчийг төлөөлж байгаа байхгүй юу.



Тийм учраас Эрүүл мэндийн даатгалын сан дээр бий болсон энэ том дата баазыг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** У.Отгонбаяр гишүүний хэлж байгааг бас анхаараарай. Хоцрогдсон мэдээлэлтэй байна. Нөгөө талдаа өөрийн хариуцлагатай хариуцлагагүйгээс болж хүн өвдөнө гэдэг ойлголт байхгүй шүү дээ. Өвчин зовлон гэнэтийн л асуудал. Өвчтөн эмнэлэг дээр ирэхээр чи өөрөө хариуцлагагүйгээс болсон байна гээд сууж байдаг эрүүл мэндийн салбар гэж байж болохгүй. Тэр хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нь эрүүл мэндийн салбар төрийн маш чухал үүрэг гэдэг талаасаа харж хандана шүү.

Түүнээс өөрийн хариуцлагагүйгээс болж өвдсөн байна. Чи тэрийгээ өөрөө хариуц гэдэг үгийг эрүүл мэндийн салбар хэлэх ёсгүй.

Сархадын Зулпхар гишүүн асуулт асууж үг хэлье.

**С.Зулпхар:** Их Хурлын дарга, Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигч Б.Рагчааг дэмжиж байна гэдгээ юуны өмнө илэрхийлье.

Би тодорхой саналууд хэлье гэж бодож байна. Юуны өмнө Эрүүл мэндийн даатгалын сан иргэнд эрүүл мэндийн эрсдэл тулгамдсан үед тэр эрүүл мэндийн эрсдэлийг даван туулахад чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж, санхүүжилт үзүүлдэг ийм сан гэдгийг бид энэ бүх нийтээрээ бол ойлгох цаг болсон.

Аливаа сан, ялангуяа эрсдэлийн сангууд байгаа. Нийгмийн даатгалын сан ч бай тодорхой эрсдэлийг даван туулахад чиглэсэн, ийм зорилго руу чиглэсэн ийм л сан байдаг. Бид болохоор хүссэн зүйл болгоныг санхүүжүүлдэг юм шиг ийм бас өрөөсгөл ойлголттой. Түүнээсээ болоод заримдаа сангаасаа хэтийдсэн хүсэлтэй. Тэгээд тэр сан нь өөрөө тэр хүслийг биелүүлэх боломжгүй байдаг гэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг заавал ойлгох ёстой. Та үүнийг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүний хувьд байнга санаж байх ёстой байгаа юм.

Тэгэхээр энэ шаардлагатай үед хэзээ, ямар үйлчилгээг хэрхэн, яаж үзүүлэх вэ гэсэн ийм л тогтолцоонд тулгуурласан зарчмыг барьдаг юм гэдгийг заавал санаж байгаарай гэж байгаа юм.

Өнгөрсөн жилүүдэд үндсэндээ 2021 оноос бид Эрүүл мэндийн даатгалын хүрээнд эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлийн санхүүжилтийг хийж эхэлсэн. Энэ

бол тодорхой үр дүнгээ өгч байна. Үүнийг бид хэлэх ёстой. Сонголтыг бий болгож байна иргэдэд. Түүнээс гадна зарим эрүүл мэндийн үйлчилгээн дээр чанар сайжирч байна. Үүнийг заавал хэлэх ёстой. Олон улсын байгууллагын тайлан үүнийг бидэнд илэрхийлж байна шүү дээ.

Хөндлөнгийн тайлангуудыг харж байж л бид энэ тогтолцоо хэрхэн ажиллаж байгаа дээр бодитой дүгнэлт хийж чадна. Тэгэхгүй хоёр, гурван ямар нэгэн хүмүүсийн саналаар бүхэлдээ болохоо байсан юм шиг яриад байвал сүүлдээ бид ингээд ерөөсөө нэг юм болж байтал болохоо байлаа гэдэг юм руу л орж байгаа юм.

Гэхдээ асуудал бол байна. Асуудал өөрөө энэ шинэ тогтолцоог нэвтрүүлэх явцад л гарч байгаа л асуудал л даа. Сая Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан сайд ч гэсэн хэлж байна. Бид хэрэгцээгүй зүйл дээр маш их санхүүжилт хийснээсээ болоод, тийм шийдвэр гаргаснаасаа болоод.

Тэгэхээр энэ шийдвэрийг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл өөрөө гаргасан. Цаашдаа ийм шийдвэр гаргаж болохгүй гэсэн үг. Шаардлагатай зүйлд нь санхүүжилт хийх ёстой байтал.

Сая А.Ариунзаяа гишүүн ч гэсэн хэлж байна шүү дээ. Ковидын үед бид чинь уг нь тэр сангаас ямар нэгэн техник, тоног төхөөрөмж бол санхүүжүүлэх ёсгүй байтал санхүүжүүлсэн. Тэрийг буцааж өгөөрэй гэж байгаа байхгүй юу. Уг нь бол яг тийм. Тэр чинь үйлчилгээ рүү явах ёстой мөнгө байхгүй юу.

Тэгэхээр энэ талаас нь бодох ёстой байх гэж бодож байна.

Тэгэхээр ажиллаж байгаа, гэхдээ бас бэрхшээл байна. Орон нутагт очихоор зэрэг мэдээж хэрэг санхүүжилттэй холбоотой зарим механизм чинь ажиллахгүй байна гэж байгаа байхгүй юу. Сумын эмнэлэг дээр санхүүжилт нэг өөр байна. Мэдээж хэрэг Улаанбаатар хот дахь дараагийн шатлалын эмнэлгүүд дээр бол энэ дээр нэг өөр. Яах вэ дээ, ачаалал нь өөр. Ачаалал нь өөр байгаа учраас гүйцэтгэл нь өөр. Гүйцэтгэл нь өөр байгаагаас учраас санхүүжилт нь өөр байх учраас энэ дээр бид ялгаатай байдлаар зохих механизм ажиллах ёстой. Цаашдаа зарим газар хэт их ачааллаас болоод тэнд чинь чанар буцаад алдагдаж байгаа байхгүй юу. Хугацаа алдаж байна гэдэг ч юм уу.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн шийдвэр гаргах нь гэж байгаа юм. Эрсдэлийг даван туулахад чиглэсэн шийдвэрүүдийг Та бүхэн ойрын хугацаанд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл дээр хамтдаа гаргах ёстой гэдгийг онцгойлон Та бүхэнд захиж байна.

Хоёр дахь зүйл. Сая Ж.Чинбүрэн гишүүн ч гэсэн хэлж байна. Бид өнгөрсөн долоо хоногт ч гэсэн хэлэлцүүлэг хийлээ шүү дээ. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах үйл ажиллагаатай холбоотой. Үүнийг зохицуулсан манай хуулийн зохицуулалт, дагалдах журмын зохицуулалтууд дээр эргэж

харах зүйлүүд байна. Уг нь бид аль болох өргөн сонголттой зүйл рүү орно гэсэн чинь хууль дээрээ бид яасан гэхээр зэрэг тодорхой хязгаарлалт тавьсан. Тэр нь буцаад журмаараа зохицуулалт хийхээрээ эмийг бид өргөн сонголтоор сонгож худалдаж авах биш тодорхой хязгаарлагдмал зохицуулалтаар хийсэн ийм зүйлүүд байна. Бодит практик, бодит амьдрал байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр бид яах вэ?

**Д.Амарбаясгалан:** С.Зулпхар гишүүнд 1 минут нэмж өгье.

**С.Зулпхар:** Тэр эрүүл мэндийн даатгалын хүрээнд санхүүжигддэг зүйл шүү дээ. Жишээ нь, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль дээр урьд нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон “ICH” /The **International Council for Harmonisation of Technical Requirements for Pharmaceuticals for Human Use**/ гэдэг энэ хоёр стандартыг хоёуланг нь хэрэглэсэн байх түвшинд эмийг шуурхай бид тэнд нь бүртгээд, тэгээд тэрийг сонгон шалгаруулалтад оруулах боломжтой байсан.

Тэгсэн чинь одоо бол зөвхөн Дэлхийн банкны бүртгэлтэй гээд хязгаарлалт тавьсан. Гэтэл “ICH” гэдэг нь Дэлхийн банкнаасаа давсан өндөр түвшний шалгуур байдаг. Тэрийгээ хаагаад хаясан. Тэгсэн чинь бид хоёр, гурван улсаас авч болдог эмийг магадгүй нэг улсаас авдаг ийм хэлбэр лүү л орох гээд байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө цаанаа хардалт дагуулж байна. Цаашаа сонголтыг хязгаарлаж байна. Тэр битгий хэл энэ чинь өөрөө үнэд нөлөөлдөг. Үнэд нөлөөлж байгаа бол бид эм, эмнэлгийн хэрэгслийг иргэдэд, нэн ялангуяа тодорхой иргэдэд харьцангуй хөнгөлөлттэй хэлбэрээр хүргэх механизмыг хаана гэсэн үг./минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Яг минутдаа ер нь багтаж асуудаг болно шүү. Гишүүд маань. Олгогдсон үндсэн минут дуусна. Тэгээд албатай юм шиг нэг минут нэмж авъя гэж бараг бүх гишүүн хэлдэг болж эхэлж байгаа.

Тэгэхээр үндсэн минутдаа асуултаа асууна. Хариулт хангалтгүй бол тодруулж асуух дэгийн зохицуулалттай гэдгээ анхаараарай. Тэгэхгүй бол гишүүн болгон нэг минутаа нэмж авъя гэдэг ийм хэлбэр лүү шилжиж байгаа.

Хариулт өгөх үү? Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя. Үг хэлье.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн асуудал тэгээд холбогдох Нийгмийн бодлогын байнгын хороо өөрөө сонгон шалгаруулалтаа хийгээд оруулж ирж дэмжсэн болохоор асуугаад байх юм алга.

Нөгөө талаас өчигдөр, өнөөдрийн чуулганы хуралдаанд Ардчилсан намынхан маань үндсэндээ ажил хаяж төрийн ажилд чөдөр саад болж байгаагаа ойлгох хэрэгтэй.

Энэ тэгээд яг Ж.Баярмаа гишүүндээ байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Намынхаа дотоод асуудал болгож, үндсэндээ баялгийн санг дэмжих, дэмжихгүй асуудал, засагт цаашдаа байх байхгүй асуудал гээд намын дотоод асуудлынхаа л асуудал зөрчил нь л илэрч гарч харагдаж байна шүү дээ. Тэгээд үүнийгээ төрийн ажлын чөдөр тушаа болгож байгаа гэдгээ ойлгох хэрэгтэй.

Тийм учраас хуралдаа суух хэрэгтэй. Ард түмнээсээ ичих хэрэгтэй. Сонгуулийн үеэр төрийн ажлыг сайжруулна, урагшлуулна, хяналт тавина гэж орж ирчхээд өнөөдөр болохоор ажлыг гацааж байгаадаа ичих хэрэгтэй шүү дээ.

Тийм учраас би Ардчилсан намынхандаа хурал чуулгандаа суугаад, төрийн ажлаа урагшлуулаад, хэлэлцэх чухал асуудлууд олон байна. Ард түмний амьдрал сайнгүй байна, эдийн засаг амаргүй байна, бүтээн байгуулалтын ид улирал эхэлж байна. Өдөр хоногтоо уралдах, байгаль, цаг агаар амаргүй байна. Гал түймэртэй тэмцэх асуудал. Ингээд цаг үеийн олон асуудлууд байгаа учраас тэр нэг 18-тай хүүхдүүдийн үерхэл нөхөрлөлийн асуудал ярьж байгаа насан дээрээ байгаа хүүхдүүд шиг нэг нь гуйдаг, нэг нь гуйлгадаг гэдэг юм уу ингэж ярьдаг асуудал биш шүү дээ. Энэ Төрийн ордны чуулганы танхим чинь.

Монгол Улсын эрх ашгийн ажлаа эрэмбэлж, хувь хүнийхээ асуудлыг хойш тавих хэрэгтэй шүү дээ. Тэгээд улс орныхоо эрх ашгийг эрэмбэлж нэгд тавьж ингэж асуудалд хандаасай гэж бодож байна.

Хоёр дахь асуудал. Би Т.Мөнхсайхан сайдтай холбогдуулж асуух гэж байгаа юм. Яах вэ, ер нь эрүүл мэндийн салбар амаргүй байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ. Үүний цаана дандаа төсөв мөнгөний асуудал. Эрүүл мэндийн салбарт оногдож байгаа, батлагдаж байгаа 3 гаруй их наяд төгрөг. Энэ нь өнөөдрийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь.

Тэгэхээр ирэх жилийн 2026 оны төсөв, төлөвлөгөө боловсрогдож байгаа үе байна. Цаашдаа эрүүл мэндийн салбарын төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх асуудлаар, дотоодын нийт бүтээгдэхүүний. Сая нэр дэвшигч хэлж байна. 5 хувьд хүрэх асуудал байна. 6 хувьд хүргэвэл ер нь өнөөдрийн энэ тулгамдсан асуудлууд шийдэгдэх бололцоо боломж бүрдэнэ гэж тооцоо судалгаа гаргасан юм билээ.

Мэдээж шууд хоёр дахин нэмэгдүүлэх эдийн засгийн бололцоо боломж байхгүй. Үе шаттай нэмэгдүүлэх ёстой. Ирэх жилийн төсөв, төлөвлөгөө дээр саналаа яаж явуулж байна вэ, хүргүүлж байна вэ?

1 хувиар нэмэгдүүлэхэд л 1 их наяд төгрөг л нэмэгдэх ёстой шүү дээ.

Тийм учраас ирэх жил 2026 онд эрүүл мэндийн салбарын төсвийг 1 хувиар нэмэгдүүлэх, 1 их наядаар нэмэгдүүлэх тал дээр хэрхэн яаж санаачилга гаргаж ажиллаж байна вэ?

Ингэж байж бид эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлуудыг үе шаттай шийднэ үү гэхээс биш, зүгээр өнөөдөр ганц Эрүүл мэндийн сайдын асуудлаас болоод гэдэг юм уу, эсвэл эрүүл мэндийн байгууллагын даргаас болоод, удирдлага арга зүйгээс болоод эрүүл мэндийн салбарт тулгамдаж байгаа асуудлууд өнөөдөр үүссэн юм шиг яриад байж болохгүй.

Энэ чинь цаанаа өөрөө шууд төсөв хөрөнгөтэй холбоотой. Үүнээс үүдэлтэйгээр өнөөдөр хэмнэлтийн бодлого явж байна. Үүнээс үүдэлтэйгээр цаашдаа архаг хууч өвчтэй иргэдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээ бүрэн дүүрэн үзүүлж чадахгүй эмнэлгүүд хязгаарлалт тавьж байна.

Түүнтэй холбоотойгоор эрүүл мэндийн салбарт цаашдаа төсөв, хөрөнгийг нэмэгдүүл.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Манай эрүүл мэндийн салбар 2024 онд гэхэд нийт 2 сая 800 мянган иргэнд 26 сая тусламж, үйлчилгээг хүргэсэн байгаа.

Энэ нь 2020 оныхтой харьцуулах юм бол 10 сая тусламж, үйлчилгээгээр илүү тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Гэсэн хэдий боловч өнөөдөр манай эрүүл мэндийн салбарт төсөвлөгдөж тавигдаж байгаа санхүүжилт маань хаанаа ч хүрэхгүй байна. Энэ хаанаа ч хүрэхгүй байгаа мөнгийг бид яаж ч хүргэж хуваарилах гээд эргээд тусламж, үйлчилгээнд доголдол гарах эрсдэл байсаар байна.

Тэгэхээр олон улсынхаа тооцоо судалгаанууд нь угаасаа тодорхой гарсан байдаг. Дотоодын нийт бүтээгдэхүүний доор хаяж 6 хувьд хүрэх юм бол эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудал нь шийдэгддэг гэдэг судалгаанууд нь гарсан. Гэтэл манай улсын хувьд энэ жил 3 хувь буюу доод хэмжээний дөнгөж тал хувьд нь хүрч байгаа юм.

Тэгэхээр бидний тавьж байгаа гол зорилго бол нэг жилийн дотор шууд хоёр дахин нэмэгдүүлээд 6 хувьд хүргэх мэдээж боломжгүй.

Тийм учраас бид жилдээ дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 1 хувиар нэмэгдүүлээд явуулъя гэдэг ийм тооцоолол, төлөвлөгөөг гаргасан. Ингээд 2028 он гэхэд бид эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувьд хүргэж чадах юм бол бидний, одоо манай салбарт үүсээд байгаа асуудал маань шийдэгдэх нь.

Ингээд бид 2026 онд төсвийг тооцоолж, төсөөлж өгөхдөө дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувьд хүргэхээр ийм тооцоолол төлөвлөгөөг өгсөн байгаа.

Ингээд 2027 онд 5 хувьд, 2028 онд 6 хувьд хүргэе гэдэг тооцоололтойгоор ажиллаж байна.

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд аа, гүйцэтгэлийн санхүүжилтийн тооцоолол ер нь хэр зэрэг байдаг юм бэ? Эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой асуудлаас үүдэлтэйгээр санд сөрөг нөлөөлөл үзүүлдэг асуудал байна уу, үгүй юу?

Өнгөрсөн жил эрүүл мэндийн салбараас гарч ирсэн статистик баримтыг үзэж байхад жишээ нь төрөлттэй холбоотой асуудлаар **эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилт**-д шилжүүлсэнтэй холбогдуулаад **хийсвэр хагалгаа** хийдэг нь эрс нэмэгдсэн. Тийм ээ.

Хуучин нийт төрж байгаа эхэд **20 хувь** эзэлдэг байсан бол гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээр **40 гаруй хувь** болж нэмэгдсэн гэдэг ийм тоон мэдээлэл явж байсан шүү дээ.

Тэгэхээр гүйцэтгэлийн санхүүжилтийн чинь бодлого дотроо эмхэлж цэгцлэх асуудал бас байгаад байна уу? Үүнийгээ дотооддоо их сайн ярихгүйгээр одоо байгаа нөхцөл дээр нь санхүүжилтээ нэмнэ гэдэг байдлаар л асуудал хандаад байх чинь 100 хувь зөв биш шүү дээ. Тийм ээ. Энэ дээр нэг тайлбар хийгээч Т.Мөнхсайхан сайд.

**Т.Мөнхсайхан:** Энэ дээр бид гүйцэтгэлийн санхүүжилтээр засаж залруулах зүйл яалт ч үгүй байгаа. Тэрийгээ бид засаж залруулаад явж байгаа.

Ер нь санхүүжилтийн тогтолцоогоо өөрчлөөд “гүйцэтгэлийн санхүүжилт” рүү шилжсэн улсууд ер нь нэг 10-аас 15 жилийн дотор үндсэн голдирлоо олж яваад байгаа.

Тэгэхээр энэ рүү шилжих гээд шилжиж чадахгүй маш олон улс байгаа. Манай улсын хувьд энэ рүү шилжээд зөвхөн 4-хөн жил болж байгаа гэхэд харьцангуй маш сайн ололт амжилттай байгаа.

Бид 2020 онд манай улсад даатгуулагч нар маань 2 саяас дээш төгрөгийн тусламж, үйлчилгээ авах эрхгүй байсан шүү дээ. Гэтэл одоо бид тогтолцоогоо өөрчилсний үндсэн дээр 104 сая төгрөгийн өртөгтэй элэг шилжүүлэн суулгах мэс заслийг иргэн 5 сая төгрөг төлөөд бусдын даатгалаас санхүүжүүлээд ингээд авч болж байна.

Энэ төрөх тусламж, үйлчилгээг бол Эрүүл мэндийн даатгалын санг биш энэ бол төр даах тусламж, үйлчилгээ. Энэ кесарево<sup>[caesarean]</sup> хагалгаа нэмэгдсэн зөвхөн энэ тусламж, үйлчилгээний санхүүжилттэй холбоотой зүйл.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулья.

**Т.Мөнхсайхан:** Гэхдээ энэ санхүүжилтийн тогтолцооны асуудал 20 хувь орчимд нь нөлөөлсөн байна уу гэдэг тооцоололыг бид гаргасан.

Тэгээд энэ жил бид эхийг яг өөрийнхөө физиологийн дагуу төрж байгааг санхүүжилтийг нь 40 хувь нэмэгдүүлээд 1 сая төгрөг болгосон. Кесарево мэс заслаар төрж байгаа тохиолдлууд хуучин хэвээрээ 850 мянга гэдэг энэ хэвээрээ байгаа.

Тэгэхээр энэ дээр бид бодлогын зохицуулалтуудаа байнга хийж явж байх ёстой. Шинэчлээд бид явал ард иргэдэд зөв сонголт болох вэ гэдэг санхүүжилтийн өөрчлөлтийн шинэчлэлтийг тасралтгүй бид угаасаа хийж хэрэгжүүлж явж байж бид зөв голдирлоо олно.

Тэгэхээр одоо даатгалын сангийн ЭМДҮЗ-ийн хамгийн гол анхаарал хандуулж байгаа зүйл бол энэ. Яг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээгээ бид санхүүжүүлье. Иргэд эргээд эрүүл мэндийн боловсролоо нэмэгдүүлэх чиглэл рүү бид чиглэсэн энэ ажлууд дээрээ бас анхаарлаа хандуулъя гэдэг ийм бодлогыг түлхүү анхаарал хандуулж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя. Үг хэлье.

**Д.Ганмаа:** Бид Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн томилох талаар ярилцаж байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд маань Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл хэр зэрэг ач холбогдолтой, их чухал, гол шийдвэрүүдийг гаргадаг зөвлөл вэ гэдэг дээр сайн ойлголттой болох хэрэгтэй.

Тэгээд түүнд бид хяналтаа яг тавьж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай учраас энэ чухал. Гэтэл өнөөдөр одоо бараг ихэнх гишүүд нь буцаад гараад явж байна. Маш харамсалтай санагдаж байна. Надад.

Эрүүл мэндийн салбарыг тоож, ярьж, сонсож байгаа хүн хүмүүс байна уу? Эрүүл мэндийн асуудал, нөхцөл байдал одоо ямар байгаа юм бэ? Энэ тогтолцоон дээр нь яагаад ажиллахгүй байгаа юм бэ? Яагаад анхаарал хандахгүй байгаа юм бэ? Тэгээд зөвхөн мөнгө яриад байгаа юм бэ?

Иргэдийг, өвчтөнийг, чанарыг. Үүнийг хэн ярих юм бэ? Хэзээнээс ярьж эхлэх юм бэ?

Тэгээд ярихаар зөвхөн мөнгө яриад байдаг. Энэ нь дутагдалтай санагдаад байна. Хэд хэдэн асуудал байна. Эхлээд сайд, дараа нь Б.Рагчаа хариулаад өгөхийг бодоорой. Тэгэхдээ хийсэн, гүйцэтгэсэн гэсэн утгаар



хариулаарай. Ирээдүй цаг дээр аль болохоор хариулахгүй байхыг бодоорой гэж хүсье.

Нэгдүгээрт, яг энэ сангийн тэнцэл алдагдаад байгаа, сангаа зөв зохистой удирдаж чадахгүй байгаа хариуцлагыг нь яг хэн хүлээх ёстой юм? Энэ дээр нэг асуулт нэг хариулт аваад үзмээр байна. Засгийн газраас.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой тогтоолыг батлаад шийдвэр гаргаад байгаа эдгээр хүмүүс, байгууллага яг ямар хариуцлага хүлээх юм? Тооцоо, судалгаа хийсэн хүмүүс нь хэн юм? Энэ тооцоо, судалгаа нь буруу гараад байгаа дээр бас хариуцлагыг яаж тооцож ажилласан юм? Тэнцэл алдагдаад байгаа нь нүдэн дээр ил байгаа бодитой юмыг би асуугаад байна шүү дээ.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөс ямар нэгэн санал, дүгнэлт энэ дээр гаргасан юм уу? Гаргасан бол ямар дүгнэлт гаргасан юм? Яаж засна гэж ярьж байгаа юм?

Энэ дээр даргын хувьд сайд. Дараа нь одоо энэ шинээр орж ирж байгаа хүн маань бас ямар санал бодолтой байгаа юм гэдгээ яах вэ, ирээдүй цаг дээр хариулж болох байх. Өөрөө орж ирж байгаа учраас.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сан ер нь удирдах чадавх нь байгаа юм уу? Анх энэ агентлагийг чинь 2021 онд байгуулаад, хүчин чадлыг нь хоёр дахин нэмэгдүүлээд төр дэмжсэн. Гэтэл нөхцөл байдал нь ийм болоод байгаа нь яаж, хэнд хариуцлагыг нь тооцох юм бэ? Дотоод шийдвэр гаргадгийг нь ЭМДҮЗ нь хүлээх юм уу, зөвлөхүүд нь хүлээх юм уу, гадаадын шийдвэр гаргаж тооцоо гаргасан эдгээрүүд нь хүлээх юм уу гэдэг асуудлууд их чухал санагдаад байна. Надад.

Хоёр дахь асуулт. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл нь ер нь хүн амын өвчлөлийн нөхцөл байдал, сангийн эх үүсвэртэй хэрхэн уялдаж байгаа, бодлогын түвшинд сангийн чадавхыг нэмэгдүүлэх, үр ашигтай байх талаар яг ямар бодлого барьж ажиллаад байгаа юм? Энэ нь одоо яг мэргэжлийн түвшинд байгаа юу? Шинжлэх ухаанчаар хандаж чадаж байна уу? Тэгээд ийм чадвартай, ашиг сонирхолгүй хүмүүсээр багаа бүрдүүлж ажиллаж чадаж байгаа юу?

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Бид ерөнхийдөө 2021 оноос гүйцэтгэлийн санхүүжилт буюу нэг эх үүсвэрийн санхүүжилт рүү орсон.

Энэ дээр Эрүүл мэндийн даатгалын санд шимтгэлээ төлөгч иргэд, ингээд төсвөөс орж ирж байгаа мөнгө маань нэг санд очиж төвлөрч байгаа. Ингээд тусламж, үйлчилгээгээ гүйцэтгэлээр нь санхүүжээд явуулж байгаа.



Тэгэхээр сангийн тэнцэл хаана яагаад алдагдав гэдэг зүйл ерөнхийдөө 2021 оноос эхлэлтэй. Ковидын үеийн тусламж, үйлчилгээнд маш их санхүүжилтийг зарцуулсан. Жишээ нь, 2021 онд даатгалын санд нийт төвлөрсөн хэмжээнээс 2021 онд гэхэд 250 орчим тэрбум төгрөгийн илүү санхүүжилт гарсан.

Дийлэнх нь ковидын тусламж, үйлчилгээнд явсан. Тэгээд 2022 ондоо эргээд ковидын тусламж, үйлчилгээ рүү явсан санхүүжилтээ санд эргүүлж төвлөрүүлээгүй. 2022 онд дахиад энэ нөхцөл байдал үргэлжилсэн. Дахин алдагдалд нэмэгдсэн. Ковидын тусламж, үйлчилгээг дахин Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн.

Уг нь халдварт өвчний дэгдэлтийн үед улсын төсвөөс санхүүжүүлэх ёстой. Гэтэл үүнийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэнтэй холбоотой энэ зүйл маань 2023 онд дахин засагдалгүйгээр үргэлжилсэн.

Ингээд өнгөрсөн оны эцэс хүртэл Эрүүл мэндийн даатгалын сан эрүүл мэндийн байгууллагуудтай өглөгтэйгөөр, өртэйгөөр ажилласан гэсэн үг. Тэгээд үүнийг 100 хувь шийдэж, энэ оны төсвийг бид 320 орчим тэрбумаар нэмэгдүүлсэн. Ингээд эрүүл мэндийн байгууллагуудад үүссэн байсан өрийг бид өнгөрсөн жил 320 тэрбум болтол нь буулгасан.

Ингэхдээ бид сайдын багцаас 35 төгрөгийн хэмнэлт хийгээд, манай улсад зээлээр өгсөн байсан гаднын санхүүжилтийг тусламж болгоод 70 тэрбумыг дахиад Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээд. Ингээд бид шаардлагагүй тусламж, үйлчилгээндээ хязгаарлалт хийгээд ингэсний хүчинд бид эмнэлгийн байгууллагуудад өгөх ёстой өрийг 320 тэрбум руу буулгаж чадсан.

Ингээд энэ оны нэмэгдүүлсэн төсвөө энэ эрүүл мэндийн байгууллагууддаа хуваарилсан. Энэ ямар нэгэн байдлаар өр дарж байна гээд ямар нэгэн компани, байгууллагууд руу өгөөгүй. Эрүүл мэндийн салбар дотроо эрүүл мэндийн байгууллагууддаа хуваарилагдсан. Энэ алдааг бид дахин давтахгүйн тулд энэ жил сар болгоныхоо төсвийн хуваарилалтыг яг хийж гэрээ контрактаа бид эрүүл мэндийн байгууллагууддаа яг таг хийж байгаа.

Ингээд сар болгоноор нь гүйцэтгэлийг нь тулгаад явах юм бол бид оны төгсгөлд очоод санхүүжилт байхгүй, оны эхэн рүүгээ татаад хэрэглэдэг хүнд нөхцөл байдалд ордог энэ зүйл маань засрах юм.

Тэгэхээр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд гүйцээж хариулъя.

**Т.Мөнхсайхан:** Тэгэхээр энэ жил Эрүүл мэндийн даатгалын сангийн хувьд маш их чухал жил болоод байгаа юм. Энэ өнгөрсөн 3 жил явж ирсэн

сангийн тэнцэл алдагдсан зүйлээ засаж залруулах боломжийг бүрдүүлсэн жил болж байгаа учраас бид санхүүгийн маш өндөр сахилга баттай байх ёстой.

Тийм учраас санхүүгийн сахилга батыг сахиулаад, хуваарилалтаа зөв хийгээд, энэ дээрээ хяналт тавиад ирэхээр зарим нэг эрүүл мэндийн байгууллагууд маань, зарим нэг хүмүүс маань даатгалын сан дампуурсан юм шиг, мөнгөгүй болсон юм шиг ийм ойлголтуудыг ард иргэдэд төрүүлээд байгаа юм.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сан дампуураагүй. Санхүүгийнхээ хяналт, зохицуулалт, үйл ажиллагаагаа сайжруулж байгаа юм.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд энэ сангийн тэнцэл 700 орчим тэрбумаар алдагдсан энэ зүйлийг эргэж нөхөх юм бол зөв болно. Гэхдээ энэ шийдвэрүүдийг хэн гаргасан бэ. 2021, 2022 онд энэ ковидын тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

**Б.Рагчаа:** Гишүүний асуултад хариулъя.

Хариуцлага хэн хүлээх вэ гэж. Хариуцлагыг мэдээж шийдвэр гаргасан тэр субъект л хүлээх ёстой. Тэгэхдээ миний хувьд ойлгож байгаа нь бол энэ хяналтын тогтолцоог тусад нь биеэ даасан байдлаар бий болгож байж энэ хариуцлагыг хүлээх энэ тайлан тэнцлийг зөв болгох тал дээр голлон анхаарах хэрэгтэй болов уу гэж бодож байгаа юм.

Түрүүн А.Ариунзаяа гишүүн хэлсэн. Энэ хяналтын цогцогцоог биеэ даасан байдлаар бий болгох ёстой гэж. Энэ дээр би бас А.Ариунзаяа гишүүнтэй санал нэг байгаа. Тэгж байж ашиг алдагдал, тэнцлийг барих боломжтой гэж нэгдүгээрт харж байна.

Ер нь эрүүл мэндийн салбарын бодлого бол хүн амыг эрүүл байлгах гэдэг бодлого барих ёстой гэж харж байгаа. Тэгээд хүн амыг эрүүл байлгахын тулд өвчлөлийн хойноос хөөх биш өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч нийгмийн эрүүл мэндийн чанар хүртээмжийг нийт ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр илүү анхаарч ажиллах шаардлагатай болов уу гэсэн бодолтой байна.

**Д.Амарбаясгалан:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж асууя.

**Д.Ганмаа:** Сайдын тайлбарыг ойлгож байна. Ковидтой холбоотой маш их зардал гарсан. Одоо үүнээс хойш энэ дээр анхаарч сар болгон гэрээ контрактын дагуу үр ашигтай сайн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлнэ гэж ярьж байна. Тийм ээ.

Одоо яг үүсээд байгаа нөхцөл байдал дээр адилхан эмч, эмнэлгийн ажилчид ч гэсэн хүмүүс учраас өвддөг хавддаг, гэр орныхон ч гэсэн. Тийм ээ. Тэгээд маш яаралтай наад захын эмчилгээ, эм тасраад байгаа энэ гомдол, санал ерөөсөө тасрахгүй байгаа байхгүй юу. Одоо жишээлбэл надтай хамт нэг төгст хийсэн хүний хүүхэд маань ч гэсэн морфин дууссан. Одоо өвдөлтийн шокоор нас барах гээд эм нь огт бичигдэхгүй гээд. Түүн шиг маш олон тийм салбаруудын асуудал орж ирээд байгааг бид яаралтай зайлшгүй шаардагдах юмнууд дээр ажиллах ёстой байгаад байна.

Яах вэ, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хувьд, түрүүн У.Отгонбаяр гишүүн бас дурдсан. Тэгэхдээ энэ дүрэмдээ актуар тооцооллыг суурилж санг удирдах, сангийн тэнцэл хангаагүй тохиолдолд хариуцлага хүлээдэг энэ зохицуулалтыг дасгах.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя, үг хэлье.

**Г.Тэмүүлэн:** Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүн томилогдох гэж байгаатай холбогдуулаад Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлтэй холбоотой, даатгалын санхүүжилттэй холбоотой хэд хэдэн асуудлыг хөндөж ярихгүй бол болохгүй байна л гэж үзэх гээд байгаа юм.

Үндсэндээ уг нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл яг энэ даатгуулагчийнхаа эрх ашигт нийцсэн бие даасан бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Бодлогыг тодорхойлох ёстой. Даатгуулагчийнхаа хэрэгцээнд нийцсэн тэр бодлого болоод тусламж, үйлчилгээ, санхүүжилтийг шийдэх тэр хэмжээний бодлогыг гаргах ёстой гэж хараад байгаа юм.

Тэгээд бид бүхний хувьд Улсын Их Хурал өөрөө ард түмний төлөөлөл, иргэдтэй бид хаврын чуулган завсарласан үеэр уулзлаа. Эрүүл мэндийн төвийн байгууллагуудтай салбаруудаар орж танилцлаа.

Ингээд явахад ерөнхийдөө нийтлэг, сая энэ хоёр, гурван сард сумдаар яваад уулзахад нийт манай эрүүл мэндийн салбарынхан маань даатгалын сангийн энэ шинэ зохицуулалттай холбоотойгоор сэтгэл ханамж үнэхээр муу байна. Эргээд иргэдийн эрх ашиг болоод, иргэдийн сэтгэл ханамж, гомдол сэтгэгдэл нэлээн гарч ирэх ийм маягтай байна.

Одоохондоо иргэд дээр харьцангуй нөлөөлөл бага байгаа. Магадгүй сумдын эрүүл мэнд болоод аймаг орон нутгийнхны хэлж байгаагаар магадгүй жилийн хагасаас нөхцөл байдал яг иргэд дээр үүсэхээр, эргээд тусламж, үйлчилгээн дээр нэлээн хүндрэл учрахаар ийм нөхцөл байдал үүсэх нь гэдэг асуудлыг ярьж байгаа.

Би бодит жишээтэйгээр ярьж байна. Өнөөдөр Монгол Улсад 4500 орчим эрүүл мэндийн байгууллага байгаа. Энэ эрүүл мэндийн байгууллагууд бүгдээрээ гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоонд шилжсэн. Хөндөж ярьж байгаа асуудал бол өнөөдөр Эрүүл мэндийн даатгалын газар буюу ЭМДҮЗ, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл эмнэлгүүдийг “гүйцэтгэл бусаар санхүүжүүлж байна” гэдэг асуудлыг ярьж байгаа юм. Гүйцэтгэл бусаар.

Энэ асуудал яаж байна вэ гэхээр нэг талдаа санхүүжилтийг нь хааж хавчиж байгаа, үзүүлэх тусламж үйлчилгээ, оношийг нь үйлчлүүлэгчийн тоог хязгаарлаж байгаа асуудлыг гаргаад байна.

Бид нарт сая энэ он гараад санхүүжилтийн гэрээ байгуулахдаа ерөөсөө бид нарын саналыг авахгүйгээр тоог нь заагаад Эрүүл мэндийн төвийнхөн нэрийг нь бичээд тулган шаардах байдлаар байгуулж байна. Ямар ч үндэслэлгүйгээр мөнгөн дүнг зааж санхүүжүүлэх асуудлыг тулгаж байна.

Ингээд тухайн тусламж, үйлчилгээ дээр нь хязгаарлалт хийж байна гэдэг асуудлыг тавьж байгаа юм. Энэ дотор юу байна вэ гэхээр саяын таны хэлсэн

- ▶ Хэвтэлтийг багасгаж байгаа асуудлыг тавьж байна.
- ▶ Өдрийн эмчилгээний зардлыг бууруулж байна.
- ▶ Дуудлага буюу түргэн тусламж, яаралтай эмчилгээнүүдийг бууруулж байгаа зардлууд гарч ирж байгаа юм.

Анхан шат дээр очихоор яг ямар хэмжээтэйгээр зардлыг бууруулж байгаа юм бэ гээд аваад үзэхээр 2024 оных нь сумын Эрүүл мэндийн төвийнх нь зардлуудыг нь хэр хэмжээнд баталсан тэрийг нь 2025 онд хэр бууруулсан юм бэ гэхээр ойролцоогоор 40-өөс 50 хувиар бууруулж байна гэж байгаа юм. Нэг сумын Эрүүл мэндийн төв 160 орчим сая төгрөг авч байсан бол энэ жилийнх нь 445 болдог ч гэдэг юм уу. Ингээд үндсэндээ 50 орчим хувиар бууруулж байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол бага хэмжээний зардал бууралт биш асар том хэмжээний болж байгаа байх. Бараг хоёр дахь хэмжээний. Аймгийн Эрүүл мэндийн төв дээр очихоор 20-иос 40 хувиар бууруулж байна. 20-оос 30 хувиар бууруулж байна. Нийслэлд дүүргийнхөн бас ялгаа байхгүй дүүргийн Эрүүл мэндийн төвийнхөн бас ялгаа байхгүй 20-иос 30 хувиар бууруулчхаж байна гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол үндсэндээ цаашид хэвийн үйл ажиллагаагаа бид жилийн хагасаасаа явуулахад хүндрэл үүсэх нь. Зардлууд нь бодит бус учраас

- ▶ цалин, шимтгэл, татвараа төлж чадахгүй,
- ▶ эмийн өр төлбөрөө төлж чадахгүй,
- ▶ эм эмнэлгийн хэрэгслээ хангаж чадахгүй,

▶ хуримтлагдсан өр нэлээн үүсэх нөхцөл байдал үүсэх нь.

Одоо үүнийг бид яах вэ. Бид одоо үндсэндээ хуучин “ор дүүрэх” гэдэг асуудал үүсдэг байсан бол одоо

▶ онош дүүрсэн,  
▶ үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн тоо дүүрсэн,  
▶ яаралтай цочмог иргэдээ авах боломж байхгүй болж байгаа ч гэдэг юм уу ийм нөхцөл байдлыг хөндөж яриад байгаа.

Тэгэхээр энэ бол нэг талдаа яг иргэдийн эрх ашиг хөндөгдөх асуудал гарна шүү.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл даатгуулагчийнхаа хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх ёстой. Энэ дээрээ бодлогоо бие даасан байдлаар гаргах ёстой. Энэ санхүүжилтийг нь нэг талдаа шийдэх ёстой л гэдэг асуудал байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Тийм. Энэ тоо хязгаар тавиад ирэхээрээ энэ чинь бас “гүйцэтгэлийн санхүүжилт” нэг талаасаа биш болоод байх юм. Тэгээд яагаад тоо хязгаар тавиад байна гэхээр одоо байгаа мөнгөндөө л бид хуваарилалтаа хийнэ шүү дээ.

Тэгэхээр бид өнгөрсөн хугацаанд бүх тусламж, үйлчилгээн дээр нь хязгаарлалт байдаг байсан бол энэ жил бид үүнийгээ ангилсан байгаа юм. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээгээ бид ямар нэгэн хязгаарлалтгүй, архаг төлөвлөгөөтөөр хийж болох зүйлдээ хязгаарлалтууд тавьсан.

Тэгэхээр бид ямар нэгэн хязгаарлалтгүйгээр тусламж, үйлчилгээгээ зөвхөн хүргээд хяналтаа сайжруулсан энэ тогтолцоо руу оръё гэх юм бол өнөөдрийн байгаа санхүүжилтийг хоёр дахин нэмэгдүүлээд 6 хувь хүргэх юм бол “гүйцэтгэлийн санхүүжилт” маань утгаараа хэрэгжих ийм боломж бүрдэнэ.

Тэгэхээр энэ Өрхийн эрүүл мэндийн төв, зарим сумын Эрүүл мэндийн төвүүд дээр санхүүжилт яг нийлүүлээд аваад. Энэ чинь хоёр янзын санхүүжилт аваад байгаа шүү дээ. Сумын Эрүүл мэндийн төв.

- Нэг иргэний санхүүжилт,
- Гүйцэтгэлийн санхүүжилт

гээд хоёр талаасаа санхүүжилт аваад байгаа юм.

Гүйцэтгэлийн санхүүжилт рүү шилжсэн 2021 оноос хойш өнөөдрийн байдлаар сумын Эрүүл мэндийн төвийн санхүүжилт хамгийн багадаа хоёр дахин нэмэгдсэн. Ихдээ гурав дахин нэмэгдсэн байгаа.

Энэ жилийн хувьд нийт санхүүжилт нь тэгж 40, 50 хувиар хасагдсан сумын Эрүүл мэндийн төв огтоосоо байхгүй. Эд нар зөвхөн 4 төрлийн тусламж, үйлчилгээ гээд ярьж байгаа. Тэрнээс хасагдсан хасагдлыг нь нэг иргэн талд нь нэмээд өгсөн.

Энэ дээр харин Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс ерөнхийдөө

- анхан шатад ийм санхүүжилт,
- лавлагаа шатлалд ийм санхүүжилт,
- хувьд ийм санхүүжилтийг олгоно шүү гээд нийт төсвийг нь батлаад өгдөг.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр яг энэ эмнэлгүүдтэйгээ тулж гэрээ хийдэг. Энэ явцад Өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр энэ баталж өгсөн төсвөөс 15 тэрбум төгрөг дутуу баталсан, зарцуулсан ийм зүйл байгаа юм билээ.

Тэгэхээр зарим нэг сумууд дээр энэ зүйлийг маань эргээд хуваарилалтууд нь хийгдээд ирэхээр өшөө сайн санхүүжилт нь нэмэгдэнэ гэсэн үг.

Гэхдээ өнөөдрийн байдлаар хасагдсан сум огтоосоо байхгүй биш. Үүнийг жоохон ялгаж салгахгүй ойлгоод байгаа юм. Түрүүний хэлсэн шаардлагагүй хэвтэлтийг л бид багасгаад, илүү их эмч, эмнэлгийн ажилчдадаа санхүүжилт зарцуулах энэ боломжийг нь олгож өгч байгаа юм.

Тэр яаралтай тусламж, дуудлагыг бол бид хязгаарлахгүй. Тэр санхүүжилт дээр бид ямар нэгэн хязгаарлалт хийхгүй. Үүнийг шууд олгоод явна гэдэг ийм байр суурьтайгаар ерөнхийдөө санхүүжилтүүдийг олгож байгаа.

Тэгэхээр бид яалт ч үгүй нэг талын нэг өөрчлөлтийг хийж, энэ хэвшмэл ойлголт, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагагүй өвчлөлүүдээ бид хэвтэхгүйгээр эмчилгээгээ хийлгэдэг энэ тогтолцоо руугаа л бид орохгүй бол бид зөвхөн санхүүжилтээ нэмэгдүүлээд байдаг. Нөгөө талдаа бүх төрлийн тусламж, үйлчилгээг шаардлагатай, шаардлагагүй бүгдийг нь санхүүжүүлээд байвал энэ сангийн мөнгийг хэдэн хувьд ч хүргээд хүрэхгүй.

Тийм учраас.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** Энэ дээр та хэд маань анхаараарай даа.

Тэгээд энэ чинь явж явж эргээд л яг нөгөө даатгуулагч болоод иргэдийн эрх ашигтай л хамааралтай асуудал. Жилийн эцсээс тэгээд л одоо ерөөсөө эхнээсээ л энэ дүүргийн эмнэлгүүд дээр нэлээн хүндрэл үүссэн, иргэд бухимдаад эхэлсэн ийм нөхцөл байдал үүсээд байдаг.

Таны ярьж байгаа шиг зөвхөн наад хэвтэлтийг багасгаж байгаа асуудал биш өдрийн эмчилгээ, дуудлага, яаралтай түргэн тусламж гээд эд нар чинь бүгдээрээ л буурч байгаа асуудал байгаа.

Тэгээд энэ Эрүүл мэндийн даатгалын газрынхан энэ анхны шат болоод, хоёрдугаар шатлалынхаа эмнэлгүүдтэйгээ гэрээгээ байгуулахдаа ядаж саналыг нь авахгүй, хүчээр тулгаад, та нар энэ дээр тайлбар хэлэх эрх байхгүй. Зүгээр энэ дээрээ зураад нааш нь явуул гэдэг байдлаар хандаад байгаа байхгүй юу.

Гэтэл тэр зураад явуул гэж байгаа тэр тоо хэмжээ нь болохоор өмнөх жилийнхээ гүйцэтгэл, тооцоололд суурилахгүйгээр ерөөсөө ямар ч тооцоо, судалгаагүй чанартай үйлчилгээ үзүүлэх боломжгүй болгож байна л гэдэг асуудлыг тавьж байгаа юм.

Тэгэхээр энэ нэлээн асуудал дагуулахаар байна шүү. Эрүүл мэндийн салбарынхан нэлээн сэтгэл ханамж муутай л байна. Иргэд дээр энэ асуудал удахгүй ирэх.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

**Х.Булгантуяа:** Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл дээр Үйлдвэрчний эвлэлээс Б.Рагчааг нэр дэвшиж байгааг дэмжиж байгаа. Шимтгэл төлөгч иргэдийг төлөөлж орж байгаа.

Тэгэхдээ ер нь бид Үндэсний зөвлөлийнхөө гишүүдийг нэг харах ёстой гээд Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн даргаар ажиллаж байгаа Эрүүл мэндийн сайдад болон Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад би бас хэлж байсан юм.

Одоо албан тушаалаараа бол угаасаа 3 хүн ордог. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд.

Ингээд шимтгэл төлөгчдийг төлөөлөөд гээд тэгэхээр үйлдвэрчний эвлэлээс 2 төлөөлөлтэй.

Ингээд нэг нь Шинжлэх ухааны академийн харьяа Хэл, зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан гээд ийм 3 хүн.



Ажил олгогчийг төлөөлөөд гэдэг нь Эрүүл мэндийн даатгалын уг нь нөгөө хувийг нь ажил олгогчид өөрсдөө төлөөлж байгаа юм чинь гэсэн чинь эсрэгээрээ энэ сангаас мөнгө авдаг эмч нарын төлөөллүүд энд орсон.

Өөрөөр хэлбэл хэдэн төгрөгөөр санхүүжүүлэх вэ гэдэг шийдвэрүүдээ өөрсдөө тэнд гаргаад, тэр сангаасаа мөнгө авч байгаа иргэдийн төлөөлөл ороод байгаа юм.

Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, “Сонгдо” эмнэлгийн эмч, захирал, дээрээс нь нэмээд Төрийн албан хаагчдын эмнэлгийн захирлаар ажиллаж байгаа Н.Одонгуа гээд ийм 3 хүний төлөөлөл байгаа нь эхнээсээ л Үндэсний зөвлөл ашиг сонирхолтой хүмүүсээ нөгөө талдаа оруулаар эндээс гарч байгаа шийдвэрүүд нь угаасаа Улсын Их Хурлын гишүүд энд асууж, иргэд бухимдаж байгаа нь өөрийн эрхгүй асуудал бас гарч байна.

Тэгээд энэ зөвлөлийн бүрэлдэхүүнээс авхуулаад л ярих хэрэгтэй.

Нэг ийм асуудал үүсээд байна Т.Мөнхсайхан сайд аа.

Манай Баянзүрх дүүргийн иргэд өнөөдөр манай танхимын үйл ажиллагаатай танилцаж байна. Манай Баянзүрх дүүрэгт гуравдугаар шатлалын маш олон эмнэлгүүд байдаг.

Гуравдугаар шатлалын эмнэлгүүдийн хувьд Эрүүл мэндийн даатгалаас 100 хувь санхүүжилтээр санхүүжилтээ аваад явж байгаа. Санхүүжилтээ авч чадахгүй байна. Нэгдүгээрт. Түүгээрээ сүүлдээ санхүүжүүлэх ёстой нөгөө хүмүүсийн цалин, асуудлуудыг тавьж чадахгүй байна гэдэг асуудлууд маш их байна. Гуравдугаар шатлал дээр ийм асуудлууд хэр их байна вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, эрүүл мэндийн даатгал дээр нэг ийм очер, дараалал хүмүүс гуйж байж Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөр ордог. Эмнэлгүүд, хувийн эмнэлгүүд.

Нөгөөдөх нь арай гэж санхүүжилтээ авдаг энэ тогтолцоо чинь авлигыг энэ сан дээр бий болгоод байна. Одоо энэ сангийн хуучин даргаас авхуулаад энд ажиллаж байсан нэлээн олон хүмүүс шалгагдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор үүнийгээ цахимжуулах сайжруулах дээр та бүхэн маань ямар ажил хийж байгаа юм бэ? Хэрвээ тэгэхгүй бол энэ ингээд салахгүй. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 9 гишүүн.

Дээрээс нь, Үндэсний зөвлөлийн ажлын алба гэж бас хэчнээн хүн байна вэ? Төсөв, санхүүжилтийн хувьд яаж ажиллаж байна вэ? Энэ 9 хүн бүгдээрээ ороод хэдэн их наяд. 2025 онд Эрүүл мэндийн даатгалын төсөв 2 их наяд гаруй төгрөгийн төсөвтэй байгаа.

Тэгэхээр үүнийг 9 хүн сууж байгаад шийднэ гэдэг бол их хэцүү. Эндээс эрүүл мэндийн салбарын хүн гэвэл та. Нөгөө 3 эмч л байх шиг байна.

Тэгэхээр энэ бол компаниар ТУЗ юм. Үүний ард уг нь Үйлдвэрчний эвлэлийн 3 хүний цаана нь ажиллах ажил олгогчдыг төлөөлж ажиллах мэргэжлийн бүр энэ актуарчин, тооцоондлогч ийм мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах ёстой. Тийм хүмүүс байна уу, үгүй. Тэгэхгүй яг цагаа тухаар Б.Рагчаа гэдэг хувь хүн ч гэсэн энэ олон нэрийг нь унш мэдэхгүй олон өвчнүүдийн санхүүжилтийн тогтолцоог бид яг эрүүлээр хараад, нарийн тооцооллын хийж бас чадахгүй шүү дээ.

Тэгэхээр үүн дээр танайх Эрүүл мэндийн даатгалынхаа тогтолцоог сайжруулах дээр ямар ажил хийж байна вэ гэдэг ийм хэдэн асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Т.Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 9 гишүүнийг сонгох, чөлөөлөх бүрэн эрх нь Улсын Их Хуралд байгаа.

Тэгэхээр энэ дээр орж байгаа гишүүд ямар гишүүд орох вэ, ямар гишүүд нь гарах вэ гэдэг асуудлыг би хариуцахгүй. Би бол Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даргаар Эрүүл мэндийн сайд байна гэдэг ийм хуультай.

Тийм учраас энэ хуулийнхаа дагуу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даргыг хийж байгаа. Ингэхээр Эрүүл мэндийн даатгалын санг үндсэндээ Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл нь удирдаж байна. Үндэсний зөвлөлийн гишүүдийг Улсын Их Хурлаас сонгож томилж байна.

Тэгэхээр үндсэн эрх нь Улсын Их Хуралд байгаа гэсэн үг. Тэгээд гишүүд маань ерөнхийдөө Эрүүл мэндийн даатгалын цаашдын бодлого яаж явах юм, сангийн зарцуулалтыг яаж үр өгөөжтэй болгох юм, хэрхэн яаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын тулд төр, хувийн хэвшлийнхээ эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг хэрхэн яаж зөв хуваарилах юм бэ гэдэг энэ бодлого үйл ажиллагаагаа л хийдэг. Одоо Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл.

Цаашлаад энэ эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ контрактаа хийх, энэ эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтийг нь олгох, эргээд энэ дээрээ гарч байгаа санхүүжилт үнэн зөв байна уу, сангийн зарцуулалт зөв чиглэлд явж байна уу гэдэг энэ зүйлээ хянадаг байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар.

Тэгэхээр цаашдаа ерөнхийдөө түрүүний А.Ариунзаяа гишүүний ч хэлээд байгаа яг энэ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр сангийн зарцуулалт нь яваад байдаг. Эргээд хяналт нь бас энэ газар дээрээ байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ зүйл маань нэг газар төвлөрөөд байна. Энэ хяналтыг нь тусад нь гаргая гэдэг энэ зүйлтэй миний хувьд санал нэг байгаа.

Тэгээд бид түрүүн бас хэлсэн. Яг тусламж үйлчилгээ нь 22 сая тусламж үйлчилгээ. Эндээс бид яг одоо зөв санхүүжилтээ олгож байна уу, үгүй юу гэдэг энэ зүйлийг нэг бүрчлэн хүний оролцоотойгоор шалгана гэх юм бол маш их хэцүү. Бид энэ дээр маш сайн хяналт шалгалтаа тавих ёстой. Тэгэхийн тулд бид үүнийгээ цахимжуулах “Эй Ай”-г ашиглах энэ бодлого руугаа бид орсон. Энэ ажлууд маань хийгдээд явж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажлын алба маань өнөөдрийн байдлаар үйл ажиллагаагаа тасралтгүйгээр явуулж байна. Цаашлаад Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааг сайжруулах, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд маань өөрсдөө эрүүл мэндийн байгууллагуудаар явах, орон нутгаар явах, яг тулгамдаж байгаа асуудлуудыг газар дээр нь очиж сонсож, эргэж шийдвэрлэх тал дээр онцгой анхаарал хандуулж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийнхөн маань бараг 21 аймаг, ихэнх аймгаар нь явсан, дүүргүүдээр явсан. Ингээд бүх зүйлүүдийг сонсоод цааш.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууж, үг хэлье. 2 гишүүний дараа санал хураалттай.

**М.Бадамсүрэн:** Хүн төрөлхтний хувьд эрсдэлээс сэргийлэх хамгийн чухал арга нь мэдээж даатгал, вакцин.

Тэгэхээр энэ одоо тогтолцоог улам сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа. Тэгээд нэгдүгээрт нь төлөвлөлт, тооцооллыг маш сайн хийж, ялангуяа эдийн засаг, нийгмийн одоо үнэлгээтэйгээ уялдуулж тийм том хүрээнд авч үзэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь, засаглалын хувьд сая сайд тайлбарлаж байна. 9 гишүүн нь төр даатгуулагч одоо ажил олгогч гэж төлөөлж ордог юм байна. Тэгээд энэ одоо удирдах, гүйцэтгэх, хянах механизм нь ингээд нэг дороо төвлөрчхөөд байгаа юм уу даа л гэсэн. Ийм л одоо зүйл харагдаад байгаа юм тэгээд.

Тийм учраас энд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийг бол Эрүүл мэндийн сайд ахалдаг юм байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар буюу сангийн орлогоо бүрдүүлж байгаа, хуваарилж байгаа энэ газар нь Эрүүл мэндийн сайдын харьяанд байдаг юм байна.

Тэгэхээр энэ одоо ер нь болж байна уу? Энэ тогтолцоо ер нь бусад улс орнуудад ямар байдаг юм бэ? Өөр ер нь хувилбарууд ер нь байдаг уу гэдгийг би

асууж байгаа юм. Тэгээд энэ хүрээндээ Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл Улсын Их Хурлын дэргэд Улсын Их Хурлаас байгуулдаг нөгөө Санхүүгийн зохицуулах хороо шиг ийм бүтэцтэй ажиллаж болох уу? Үүнийг ер нь судалсан, тооцсон зүйл байна уу? Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал үүнийг баталдаг шүү дээ.

Тэгэхээр Улсын Их Хурал бол энэ дээрээ ямар өөрчлөлт хийх нь Улсын Их Хурлын хэлэлцэх асуудал байж болно гэдэг зүйлийг сая сонслоо. Тэгэхээр ийм байж болох уу?

Дараагийнх нь энэ зөвлөх болон хяналтын механизмыг иргэний нийгмийн байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох уу? Зөвхөн Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар өөрөө гүйцэтгээд явах уу? Ер нь энэ хувийн хэвшлээр гүйцэтгүүлдэг, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлдэг тогтолцоог нэвтрүүлбэл яасан юм бэ?

Үйлчилгээ талдаа бол ингээд хувийн хэвшлийн өрсөлдөөнийг цаашид бид дэмжих хэрэгтэй байх. Зүгээр зарим нь бол ингээд энэ гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой олон хувийн эмнэлэг байгуулагдаад байна гэсэн зүйл ярьж байгаа. Тэгэхдээ энэ хөгжлийн гол тулгуур чинь ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээний хувьд хувийн хэвшил шүү дээ.

Яагаад үүнийг би хэлж байна гэхээр жишээлбэл орон нутагт өрхийн эрүүл мэндийн төвүүд ажиллаж байна. Барилга, тоног төхөөрөмж, өмч нь төр орон нутгийн өмч. Зөвхөн менежментийг нь хувийн хэвшил буюу өрхийн эрүүл мэндийн төв, нөхөрлөл, аж ахуйн нэгжүүд хариуцаад хуулийн этгээд аваад явдаг л гэсэн үг. Тэд нар шууд том барилга бариад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй учраас энэ явж байгаа тогтолцоо нь хамгийн зөв юм уу гэж харагдаад байгаа.

Тийм учраас энэ дээр ер нь өргөн уудам нутагт, ялангуяа сумдад, багийн түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх талаар цаашид тэднийг чадавхжуулах, хөрөнгө оруулах талаар илүү анхаарах хэрэгтэй. Ялангуяа өрхийн эрүүл мэндийн төв шиг барилга байшин, тоног төхөөрөмжид төрөөс хөрөнгө оруулалт хийгээд, үүнийг бол менежментээр, хувийн хэвшилд аваад явах нь хамгийн чухал. Тэгэхгүй бол эмч нар чинь өөр төрлийн том барилга, уурхайн салбар шиг бизнес хийхгүй учраас энэ бол одоо аль аль талдаа харилцан ашигтай ийм үйл ажиллагаа болох юм.

Тэгээд дараагийнх нь энэ анхан шатыг чадавхжуулах чиглэлээр ер нь яаж ажиллах вэ? Жишээлбэл, “заставын ажил сайн бол отрядын ажил сайн” гэж нэг ахмад, хилийн хурандаа хэлж байсан. Түүн шиг ингээд анхан шатын чинь л тусламж үйлчилгээ сайн байх юм бол энэ төвлөрсөн, төрөлжсөн эмнэлгүүдэд ирэх ачаалал бол буурна.

Тэгэхээр анхан шат руугаа өгөх даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар ямар бодлого барьж байна аа? Өөрөөр хэлбэл үе шаттайгаар анхан шат руу өгч байгаа санхүүжилтийг нь нэмэгдүүлээд, илүү дээд шатлалын эмнэлэг рүү өгч байгаа санхүүжилтийг бууруулах ийм харилцан уялдаатай зүйлийг хэрэгжүүлж болох уу гэдгийг хэлье.

Тэгээд хамгийн эцэст нь дахин энэ засаглал дээр нь Их Хурлын дэргэд энэ даатгалын үндэсний зөвлөл Санхүүгийн зохицуулах хороо шиг байж болох уу? Ийм судалгаа байна уу, хувилбар байна уу гэдгийг асууя.

**Д.Амарбаясгалан:** Тогтмолын Мөнхсайхан сайд хариулт өгье.

**Т.Мөнхсайхан:** Энэ тогтолцоон дээр бид бусад улсуудыг судалсан.

Тэгээд ер нь тогтолцооны хувьд манай улс зөв явж байгаа. Хамгийн гол нь энэ хяналтыг нь тусад нь гаргах. Жишээ нь, Солонгост бол яг ийм тогтолцоогоор явдаг хэдий ч яг энэ даатгалын сангийн зарцуулалт дээр хяналт тавьдаг тусдаа агентлаг байдаг.

Хэрвээ бид энэ Эрүүл мэндийн даатгалынхаа сангийн зарцуулалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн удирдлагыг өөр тийш нь өгөх юм бол үндсэндээ цаашдаа эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа бодлого үйл ажиллагаа зөв үү, буруу юу, зөв голдирлоор явж байна уу, үгүй юу гэдэг энэ асуудлыг Эрүүл мэндийн сайдтай ярихааргүй болно гэсэн үг. Үүнийг хариуцаж байгаа ЭМДҮЗ-ийг толгойлж байгаа хүн нь энэ бодлого, үйл ажиллагаа зөв явж байгаа юу, үгүй юу гэдэг зүйлийг хариуцаж явна гэсэн үг. Тэгэхээр энэ зүйлийг л та бүхэн маань бодох ёстой.

Бид нарын гүйцэтгэлийн санхүүжилтийн ерөөсөө гол нэг зорилго бол анхан шатаа бэхжүүлэх. Тэгээд 2021 оноос хойш энэ санхүүжилтийн энэ зүйл маань өөрчлөгдөөд, манай санхүүжилт бол “лавлагаа шатлал” дээрээ 80, 90 хувийн санхүүжилт нь очоод анхан шат дээрээ дөнгөж 10, 20 хувийн санхүүжилт нь очдог байсан юм. 2021 онд. Одоо тэгвэл бид нарын яг бодсон анхан шатаа бэхжүүлэх бодлогоор явж байгаа.

Энэ хоёрын байр нь солигдох тал руугаа явж байгаа гэсэн үг.

2021 оноос хойш энэ 4 жилийн хугацаанд анхан шатны санхүүжилт 3 дахин нэмэгдчихсэн. Яг энэ бодит тоон үзүүлэлтээрээ. Энэ цаашдаа нэмэгдээд явах ийм бодлогыг барьж байгаа бид.

Одоо тэгээд анхан шатны санхүүжилтийг цогцоор нь өөрчилчихсөн юм шиг юм бас тийм ойлголт яваад байна. Бид 2020 онд анхан шат маань нэг иргэнээрээ санхүүжилтээ авдаг байсан Одоо тэр хэвээрээ. Нэг иргэнээрээ тухайн үед авдаг байсан санхүүжилтээ бүгдийг нь авч байгаа.

Дээрээс нь нэмээд анхан шатад хөгжүүлэх шаардлагатай 4 төрлийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээрээ нэмээд санхүүжилт авч байгаа. Үүнийг манай сум өрхийн эрүүл мэндийн төвийнхөн маань нутаг орноосоо сонгогдсон гишүүд, Улсын Их Хурлын гишүүддээ нэмэгдэж байгаа зүйлээ сайн ойлгуулж тайлбарлаж нэмэлтээр ингээд мөнгө өгдөг болсон гэдэг зүйлээ тайлбарлахгүй бол гүйцэтгэлийн санхүүжилт анхан шатад зогсох юм бол та хэд маань 2020 онд байсан санхүүжилт буюу одоогийн авч байгаа санхүүжилт нь 2-оос 3 дахин буурахаар ийм нөхцөл байдал руу орохоор байна шүү.

Тэгэхээр манай анхан шатын сум, өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагууд маань асуудлаа хэлж ярьж ойлгуулахдаа зөв хэлж ярьж ойлгуулахгүй бол гүйцэтгэлийн санхүүжилт болохгүй байгаа юм шиг зүйл ярьж болохгүй.

Анхан шатын санхүүжилт 2021 оноос хойш гүйцэтгэлийн санхүүжилт хийж хэрэгжиж эхэлснээс хойш 2-оос 3 дахин нэмэгдсэн. Сумын эрүүл мэндийн төвүүд ихэнх нь дансандаа мөнгөтэй байдаг болсон. Ойр зуурын асуудлуудаа өөрсдөө шийдэх хэмжээний санхүүжилт мөнгөтэй болсон. Маш их өөрчлөлт орсон.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

**С.Эрдэнэбат:** Энэ Эрүүл мэндийн даатгалын асуудал гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжээд бас багагүй хугацаа өнгөрч байгаа, шилжилтийн үедээ явж байгаа. Үүнийг зөв маш сайн хийхгүй бол бас эргээд буцаад ухрах эрсдэл бол бий.

Тэгээд миний хувьд жил гарны өмнө томилогдоод жил гаран ажилласан. Бас чадлынхаа хэрээр ажиллаж энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой анхан шат бүх шатлалын эмнэлгүүдээр л бас явж ажилласан.

Тийм учраас саяын гишүүдийн хэлж байгаа Эрүүл мэндийн даатгалынхаа тогтолцоог цааш нь хөгжүүлж боловсронгуй болгохын тулд санхүүжилтийн хувьд нь бид оновчтой төлөвлөлт хийх нь зайлшгүй шаардлагатай. Хуучин нийтэд нь өгөөд эмнэлгүүдэд төсөв хуваарилдаг байсан бол одоо гүйцэтгэл гэдэг 700 гаруй нэр төрлийн онош, эмчилгээтэй холбоотойгоор бид Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл болон яаманд маш их ачаалал ирж байгаа.

Тийм учраас цаашдаа яг энэ байдлаараа ингээд явах юм бол арифметик прогрессоороо зардал өснө, цаашид геометр прогрессоор өсөх ийм зүйл байгаа. Энэ бол нэг талдаа сайн. Хуучин бол 2 сая төгрөгөөр л дээд тал нь хүн эмчилгээ, тусламж үйлчилгээ авч байсан шүү дээ. Одоо бол дээд тал нь 200 сая хүртэл бол авдаг болсон. 100 хувь даатгалын хөнгөлөлтөөр.



Тэгэхээр энэ талынх нь сайн талууд бол бий. Тэгээд тэр эмийн асуудал, эмнэлгийн менежментийн асуудал, монопол компаниудын шахааны асуудал хүртэл байгаа. Энэ бол нуугаад байх зүйл бол биш. Бид үүнийг бол засах ёстой.

Тийм учраас засаглалын асуудал дээр бид бүхэн нэлээн анхаарах шаардлага бий. Эмнэлгээсээ авхуулаад. Сумын эмнэлгүүд дээр бид итгэлцүүр хийж өгсөн. Бүр. Өнөөдөр Улаанбаатар хотод тарьж байгаа нэг тариа, мянган километрийн цаана тээвэрлэж очоод тарьж байгаа тариа хоёр яг ижилхэн үнэтэй байсныг замын болон алслалтынх нь байдлаас нэмж өгсөн юм.

Тийм учраас Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн бие даасан, хараат бус байдал, мэргэжлийн байх энэ зүйл дээр нь Их Хурал, Их Хурлаас томилогддог байгууллага учраас бас нэлээн ач холбогдол өгч Та бүгдийгээ дэмжиж өгөөрэй.

Тэгээд миний хувьд жил гаруй хугацаанд ажилласан хүний хувьд цаашдаа салбарыг дэмжээд явна.

Ингээд бүгдэд нь Эрүүл мэндийн даатгалын хууль болон тогтолцооны асуудал удахгүй бас орж ирэх ёстой байгаа. Тэгээд энэ тал дээр манай нэр дэвшигчийн хувьд ч гэсэн Б.Рагчаа олон жил Үйлдвэрчний эвлэл, ажилчдын төлөө ажилласан. Ялангуяа тэр даатгуулагч нарын эрх ашигтай холбоотой асуудал дээр ямарваа нэгэн ашиг сонирхлын зөрчилд автахгүйгээр чин шударгаар ажиллаарай гэдгийг би хэлж захимаар байна.

Давхар давхар хариуцлага ногдоно. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл байх нь бол нэг тийм хүсээд байхаар ч бас ажил биш. Сэтгэлээ харж ажиллавал маш буянтай ажил. Зүгээр дагаад тэгсхийгээд яваад байвал яваад л байх л ёстой ажил.

Тийм учраас цаашдаа жилдээ нэг удаа Их Хуралд нэг тайлан тавиад өнгөрдөг байдлыг цаашаа үгүй хийнэ. Нээлттэй хуралддаг болно. Асуудлаа олон талаас нь харж шийддэг болно гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Сая Х.Булгантуяа гишүүний хөндсөн Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүд дотор сонирхлын зөрчилтэй гишүүд байна гэдэг асуудал хөндөгдсөн.

Тэгэхээр энэ асуудал ингэж хөндөгдөөд энд зүгээр орхигдоод явж болохгүй.

Тийм учраас Нийгмийн бодлогын байнгын хороо уг асуудлаар судалж, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах асуудлыг хэлэлцэж, шаардлагатай



бол Улсын Их Хуралд оруулж ирж асуудал шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд үүрэг өгье. /алх цохив/

Ер нь Т.Мөнхсайхан сайд бас байж байна. Гишүүдийн хэлж байгаа үгтэй холбоотой асуудал эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хот, хөдөө, хүн ам нягтарсан нягтаршил багатай гэдгээс үл хамаараад ижил түвшний үйлчилгээ авдаг болох шаардлага байна гэдгийг гишүүд маш бодитой хэлж байна.

Ялангуяа хүн ам сийрэг байгаа сум, хөдөө орон нутгийн зарим тосгонд үйлчилгээ маш сул болсон. Зарим төрлийн мэргэжлийн эмнэлгийн үзлэгийг бас явуулах боломж нөхцөл хумигдсан, хүртээмж багассан гэдэг асуудал их хөндөгдөж байна. Зарим төрлийн мэргэжлийн өвчнийг оношлох, эмчлэх асуудлаар зарим аймгийн эмнэлгүүдийн түвшинд хүртэл энэ асуудал доголдолд орсон гэдэг асуудал бас хөндөгдөж байна.

Мөн энэ Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой, энэ эмийн агентлагийн үйл ажиллагаатай холбоотой салбарт бас эрх ашгийн сонирхлын зөрчилтэй асуудлууд их байдаг талаар гишүүд хөндөж байна.

Эмийн чанартай холбоотой асуудал. Чанартай эмээр ард иргэд үйлчлүүлэх, эм нь олон төрлийн сонголттой байх тэр боломжийг бүрдүүлэх чиглэл дээр бас Улсын Их Хурлын гишүүд ярьж байна.

Тэгэхээр энэ дээр салбарын сайд, Эрүүл мэндийн үндэсний зөвлөл ажилдаа гол анхаарлаа тавьж тусгаж ажиллах шаардлагатай.

Улсын Их Хурал намрын чуулганаар эмийн сонголттой, чанартай эмээр үйлчлүүлэх тэр боломжийг бүрдүүлэх чиглэл дээр тогтоол гаргаж, Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн. Тэр тогтоолын хэрэгжилтийн талаар эргэж тайлан тавигдаагүй байна. Хэрэгжилт ямар түвшинд явж байгаа тал дээр бас Нийгмийн бодлогын байнгын хороо анхаарал хандуулж, Улсын Их Хуралд танилцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингээд Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх санал хураалтыг явуулна.

Сүхбаатарын Эрдэнэбатыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Нууц санал хураана. Санал хураалт. /алх цохив/

57.4 хувиар санал дэмжигдэж Сүхбаатарын Эрдэнэбатыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөллөө.

Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох санал хураалтыг явуулна.

Баяраагийн Рагчааг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураана. Санал хураалт. /алх цохив/

59.6 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх гишүүнээр томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоол уншиж танилцуулъя.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1</sup>.2.2 дахь заалт, 14<sup>1</sup>.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сүхбаатарын Эрдэнэбатыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Баяраагийн Рагчааг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилсугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

Үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдсон Б.Рагчаад ажлын амжилт хүсье.

Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн саналыг үйл ажиллагаагаа явуулахдаа байнга анхаарч хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож хэлж байна.

Дараагийн асуудалд оръё.

---

**Дөрөв.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**  
**/Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн**  
**мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

---

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 2 саналын томьёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёололыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

---

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цэцэгмаагийн Уртнасан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Даваасамбуугийн Батмөнх Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх. Энэ Д.Батмөнх орж ирсэн юм уу? Энэ одоо тэгээд ажлын хэсгийн гишүүн болчихоод орж ирэхгүй яагаад алга байна. Энэ ажлын хэсгийн гишүүнийг орж ир гэж хэлээрэй.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

4 гишүүнээс нэр ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

**Д.Рэгдэл:** Энэ амьтны тухай хуульд оруулах гэж байгаа нэмэлт, өөрчлөлт бол чухал зүйл гэдгийг юуны өмнө тэмдэглэн хэлье.

Ер нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчин хүн тэр малыг нь идэж амьдардаг чоно хоёрын хоорондын тэмцэл ер нь олон 100 жил үргэлжилсэн ийм тэмцэл. Энэ тэмцэл зарим үед хурцдаад хэний хэнийгээ барих вэ гэдэг асуудал гарч ирдэг. Одоо жишээлбэл хамгийн сүүлд өчигдөр Говь-Алтай аймгийн Дэлгэр суманд айлын хонь руу чоно дайраад эзэн нь бэртэж гэмтсэн ийм тохиолдол хүртэл гарсан байгаа юм.

Тэгэхээр чоныг агнах сонирхол, ер нь чоныг устгах сонирхол малчин хүний толгойд байнга явдаг. Тэрийг нь одоо үе үеийн Засгийн газар өөрийнхөө тогтоол шийдвэрээрээ зохицуулж ирсэн ийм түүх байгаа. Одоо социализмын үед Сайд нарын зөвлөлөөс 3, 4 тогтоол гаргаж чоно агнах асуудлыг зохицуулж явсан. Зарим тогтоолын нэрийг харахад ер нь нэлээн тийм харгис шинжтэй. Тэгсэн мөртлөө зорилго нь зөв ийм тогтоол. Жишээлбэл, 1958 оны Сайд нарын зөвлөлийн тогтоол бол чоно устгах арга хэмжээний тухай гэж бүр тогтоол гарсан. Тэгээд үүгээр жилд 5 өдөр чоныг орон даяар зохион байгуулалттайгаар агнахыг даалгасан байдаг.

Ингээд 1974 онд тогтоол жаахан өөрчилж зөөлөрсөн. Энэ нь “Чонын агналтыг хүчтэй болгох зарим арга хэмжээний тухай” гэж гараад жилд 2 өдрийг улс орон даяар чоно агнах өдөр болгож шийдвэрлэсэн. Ингээд дунджаар

харахад сүүлийн 60, 70 жилийн түүхэнд жилд дунджаар 10 мянга орчим чоныг агнаж ирсэн байгаа юм.

Чоно агнаад байхад ер нь устаж үгүй болдоггүй. Монгол орон даяар хамгийн их түгээмэл тархсан махчин амьтан хэвээрээ байгаад байгаа. Энэ нь нөгөө чонын амьдрах чадвар, үржлийн потенциал, дасан зохицох чадвар, идэш тэжээлээ олж барих энэ арга ов заль мэхтэй холбоотойгоор ингээд байгаад байдаг.

Тэгэхэд одоо чоныг яг малчны амь насанд аюул учруулах хэмжээнд хүрээд ирэхэд зохицуулах эрх зүйн зохицуулалт үнэхээр байхгүй юм байна. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд хүн бол нэгдүгээрт амьд явах эрхтэй гэдгийг заасан. Бас үүний дараагийн заалтад эд хөрөнгөө хамгаалах эрхтэй гэдэг ийм заалттай. Тэгээд энэ хоёр заалт бол яг чоно малчин хоёр халз тулахад энэ хоёр заалтыг хэрэгжүүлэх ямар ч боломжгүй, хуулийн зохицуулалтгүй болчихсон учраас энэ нэмэлт, өөрчлөлтийг оруулж хүний амь насанд эд хөрөнгөө хамгаалахад чоныг алах арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй гэж би итгэл үнэмшил дүүрэн байгаа.

Энэ тогтоолын нэмэлт, өөрчлөлтийн найруулгын хувьд жаахан алдаа байна гэж хардаг. Яагаад гэвэл энэ “саарал чоныг агнасан бол” гээд байгаа юм. Тэгэхээр зэрэг “чоно агнах” гэдгийг энэ Амьтны тухай хуульд заасан байгаа. “Ан агнуур” гэдэг бол “ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу амьтан агнахыг, барихыг чоно агнах” гэж ойлгоод байгаа юм.

Тэгэхээр энэ чоно хүн хоёр тулсан энэ тохиолдолд энэ бол “ан агнуур” биш байгаа юм. Тэгэх дээр зэрэг энэ “агнасан бол” гэдэг үгийг нэг бол “алсан” гэж солих ёстой. Алсан гэдэг үг жаахан муухай сонсогдоод байвал “устгасан бол” гэж оруулбал энэ их зохимжтой. Энэ бол ан агнуур биш гэдэг утгаараа. Тэгээд энэ заалтыг нэмэлт оруулахыг миний хувьд бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Ер нь энэ ямар юм болдог вэ гэдгийг бол.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

**Ц.Уранчимэг:** Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид бас яг энэ асуудлыг ярилцсан. Амьтны тухай хууль дээр одоо байгаа хуулийн заалтад шууд “агнасан” гэдгээр оруулахгүй бас конвенцын хуулиараа шууд “алсан” гэдэг ямар нэгэн заалт, үг хэллэгээр хэлэх бүрэн боломжгүй байгаа.

Тэгэхээр одоо байгаа хуулийн зохицуулалтаараа ийм томьёоллоор оруулсан байгаа.

**Д.Амарбаясгалан:** Д.Рэгдэл гишүүн тодруулж асууя.

**Д.Рэгдэл:** Тэгэхээр зэрэг энэ Амьтны тухай хуулийн “ан агнуур” гэдэг энэ тодорхойлолтоос харахад хот руу зайлсан чоныг алсан малчин хүний үйл ажиллагаа бол агуулгаараа тохирохгүй байгаа юм л даа. Түүнээс сайхан үг, муухай үг гэж бид бодох ёсгүй. Хамгийн оновчтой зөв үгийг л энд тавьж өгөх ёстой.

Тийм учраас “чоныг устгасан бол” гэж оруулж болно. Яагаад гэвэл урьд өмнө энэ чонотой холбоотой Сайд нарын Зөвлөлийн тогтоолууд бол “чоныг устгах” гэдэг үгээр дандаа оруулж байсан байгаа юм шүү. Тэгэхээр “чоныг устгасан бол” гэдэг утгыг оруулахгүй бол энэ “ан агнуур биш” гэдэг санаа ерөөсөө хэрэгжихгүй байгаа.

**Д.Амарбаясгалан:** Энэ Байнгын хорооны дарга хаачсан бэ? Б.Бейсен гишүүн. Асуудал орж байхад хариуцаж байгаа Байнгын хорооны дарга хуулиар үүрэг хүлээж суух үүрэгтэй юм байна шүү.

Тэгээд асуудлыг нь хэлэлцээд явж байхад хууль санаачлагч байхгүй. О.Амгаланбаатар гишүүн хаана байна? Байнгын хорооны дарга Б.Бейсен байхгүй.

Өөрөө байхгүй байсан тохиолдолд өөрийнхөө Байнгын хорооны хэн нэг аль нэг гишүүнээр орлуулах асуудлыг шийдвэрлэсэн байх ёстой. Энэ чинь төрийн ажил явж байгаа.

Тамгын газраас энд анхаараарай. Ажил тасалсан байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн асуулт асууя.

**А.Ундраа:** Та бүхний амгаланг айлтгая.

Манай Монгол орон бол дэлхийн дулааралд хамгийн их өртсөн, эмзэг байгаль, цаг ууртай. Тэгээд энэ нөлөөллийн улмаас бэлчээр доройтсон, ургамлын болон амьтны нөөцөд нэлээд өөрчлөлт орж байгаа ийм улс орны нэг байгаа.

Тэгэхээр одоо энэ цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор ургамлын аймаг бас нэлээд өөрчлөгдөж байгаа. Бас тэрнээс улбаалаад амьтны аймагт бол бас их өөрчлөлтүүд гарч зарим аймгуудын нөхцөлд нөгөө нэн ховор болон ховордсон, унаган ургамал бас амьтны тоонд нэлээд өөрчлөлтүүд гарч байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр мэдээж өнөөдөр бид энэ амьтны тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өнөөгийн нөхцөл байдал, малчдын нөхцөл байдалд тохирсон байдлаар шийдвэрлэх нь зүйтэй. Гэхдээ нөхцөл байдал аймаг болгонд ондоо байгаа. Бэлчээрийн даац бас ондоо байгаа. Малын тоо толгой өсөж байгаа. Тэрэнд

тэнцвэр хэр зэрэг хадгалагдаж байгаа юм. Бусад зэрлэг ан амьтан, ан агнуурт энэ хэрхэн нөлөөлж байгаа юм гэдэг энэ маш их эмзэг баланс явж байгаа гэж харж байгаа юм.

Тэгэхээр аймаг болгоноор ургамлын аймгийн тооллого, амьтны аймгийн тооллого ер нь хэр зэрэг сайн хийгдсэн байгаа вэ? Тэгээд энэ дээр төсөв санхүү бүрэн гүйцэд сууж байгаа юу, үгүй юу гэдгийг яамнаас тодруулж асуумаар байна.

**Д.Амарбаясгалан:** Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

**Ц.Уранчимэг:** А.Ундраа гишүүний асуултад хариулъя. Үнэхээр чухал асуудал байна.

Тэгэхээр яг амьтны аймгийн тооллого бүс нутгаараа ер нь Монгол Улсын хэмжээнд хийх асуудал ялангуяа чоно дээр Биологийн хүрээлэнгийн 1980 оны судалгаа байдаг.

Одоо амьтны тухай хуулиараа Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай байвал орон нутагт зарцуулахтай холбоотой бүх аймаг дээр агнуурын менежментийн төлөвлөгөөг 5 жилээр баталдаг. Менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа ялангуяа байгалийн нөөцөд түшиглэсэн биологийн нөөц, агнуурын нөөцөө аймаг болгон тэр агнуур зохион байгуулалтынхаа төлөвлөгөөний дагуу биологийн нөөц, агнуурын нөөцийнхөө тоо толгойны судалгааг хийгээд тэгээд тэрийгээ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд саналаа ирүүлээд сайдын тушаалаар баталдаг.

Өнөөдрийн байдлаар бол яг саарал чонын судалгааг хийсэн аймгуудын дүнгээр бол 2021-ээс 2025 онд Архангай, Булган, Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Дархан ингээд нийт 13 аймаг бол хийсэн байдаг.

Тэгээд өнөөдрийн байдлаар яг энэ чоно дээр асууж болж байгаа асуудал Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг буюу тал хээрийн бүсэд энэ саарал чонын асуудал яг тулгамдсан асуудал биш. Харьцангуй тоо толгой нь цөөрсөн асуудал байгаад байдаг. Бүс нутгийн онцлогоосоо шалтгаалаад Хангайн бүс дээр бас яах аргагүй энэ нь малчин, зэрлэг амьтан ганцхан чоно гэлтгүй бусад зэрлэг амьтны ч гэсэн энэ популяцын ареал бүс нутгийн тэмцлийн асуудал яах аргагүй ийм тулгамдсан асуудал болоод байгаа.

Тэгээд энэ зохицуулалтыг бол бас тухайлсан хуулиар нь буюу байгаль орчин, төрийн захиргааны төв байгууллагын эрхэлсэн асуудлын хүрээнд тухайн орон нутаг бас энэ зохицуулалтаа хийгээд явуулах боломжтой байгаа.

Ер нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр яг энэ ан амьтан, биологийн олон янз байдлын хамгааллын хөтөлбөрт зарцуулах



санхүүжилтийн асуудал байдаггүй. Яг аймаг бүр дээрээ Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиараа орсон орлогоо буцаагаад тухайн байгалийн нөөцөд нь зарцуулах ийм зохицуулалт байдаг. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Д.Жаргалсайхан гишүүн асуулт асууна. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Санал хураалт явагдана. Гишүүдийг танхимд урьж байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.”

Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо.

Санал хураалт явуулах гэж байна. Гишүүд танхимд ороод ир. Саналын томьёоллын уншиж танилцуулсантай холбогдуулаад С.Бямбацогт гишүүн үг хэлнэ.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Энэ бараг л ганцхан заалттай хууль юм.

Чоныг өнөөдөр алахдаа заавал сумын Засаг даргаас зөвшөөрөл авдаг. Дээрээс нь 250 орчим мянган төгрөг төлдөг. Зөвшөөрөл аваагүй, мөнгө төлөөгүй бол тэр малчин дээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Үүнийг л өөрчилъе. Чоныг мал сүргээ хамгаалах зорилгоор чөлөөтэй алахыг л нээж өгье гэсэн.

Тийм. Чөлөөтэй алья гэж байгаа юм. Тэгээд энэ заалт нь зайлшгүй хэрэгтэй байгаа юм. Зүүн бүсийнхэнд хэрэггүй. Яах вэ, зүүн бүс чоногүй болсон. Хурдан буутай машинтай хүмүүс алаад дууссан. Говийн бүс, хангайн бүс, төвийн бүс, хойд бүс, баруун бүс гээд бусад бүс нутагт үндсэндээ мал сүргийн гол дайсан чоно болж байгаа. Малчдын гол амьжиргааны эх үүсвэр болсон малыг идэж устгаж байгаа.

Одоо ингээд над руу хүртэл мессеж бичиж байгаа. Өмнөговьос 100 тэмээгээ идүүлчихлээ гэж. Өмнөговь аймгаас. Говьд 100 тэмээгээ.

Баруун бүсийнхэн, хангайн бүсийнхэн ерөөсөө төл авдаггүй. Бод мал. Тугал авдаггүй, унага авдаггүй ийм л болсон байгаа юм.

Гэтэл энэ анхны хэлэлцүүлэг дээр унасан. Одоо ингээд хоёр дахь хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хороонд босоод ороод ирж байна л даа. Дахиад бас уначих вий. Энэ Ардчилсан намын гишүүд ороод ирээсэй. Би бас одоо хууль санаач О.Амгаланбаатар ороод ирсэнд баярлаж байна. Б.Бейсен гишүүн Байгаль орчны байнгын хорооны дарга ороод ирсэнд баярлаж байна. Байгаль орчны сайд нь хаачив. Ардчилсан намын гишүүд орж ирээсэй. Тэгэхгүй одоо энэ хууль унах гээд байна шүү. Ерөөсөө. Одоо санал хураахад ерөнхийдөө унах байх.

Ингэхээр үндсэндээ дахиад мал сүргийн гол дайсан болсон чоныг зөвшөөрөлгүй устгах, алах энэ бололцоо боломж нь хаагдчих вий. Үүнийг анхааралдаа аваасай гэж байгаа юм. Тийм болохоор энд маш хариуцлагатай саналаа өгмөөр байна.

Хоёрдугаарт нь, дахиад хэлэхэд Байгаль орчны яамныхан энэ асуудлаа шийдсэнээр бүх юм дуусахгүй ээ. Тэр нөөц ашигласны төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөр дотор 250 мянган төгрөг төлөх байж байгаа шүү. Үүнийг өөрчлөх ёстой.

Үүнтэй адилхан тэр хулгана зурам алахад, үлийн цагаан оготно. Манай нутагт баруун бүс, Ховд, Хар ус нуурыг идэж дуусаж байгаа ондатр гээд заарт харх алахад 5 мянган төгрөг төлдөг. Байгаль эко байгаль орчны экологийн үнэлгээ гэж. Энэ хуулийнхаа сонин сонин заалтуудыг бас өөрчилмөөр байна шүү.

Гэрийн хулгана алхад мөнгө төлж алдаг, үлийн цагаан ус оготно устгахад мөнгө төлж зөвшөөрөл авдаг. Тэр байгаль орчин сүйтгээд байгаа, байгалийн тэнцвэрт байдал алдагдуулаад байгаа, Хар ус нуурыг идээд дуусах гэж байгаа тэр ондатр, заарт хархыг алахад 7 мянган төгрөг төлдөг. 17 мянга ч билүү. Ийм сонин юмнуудаа та нар нэг эргээд харчихмаар байгаа юм шүү. Бас.

Урьд өмнөх сайд нарт нь өчнөөн олон удаа хэлж байсан. Шийддэггүй байсан. Одоо та нар нэг анхааралдаа аваад үүнийг шийдчихээсэй.

Иймэрхүү байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулахад сөрөг нөлөөлж байгаа ан амьтныг бид бас чөлөөтэй устгадаг, агнадаг болмоор байна. Энэ үүднээс л үүнийг анхаарахгүй бол болохгүй байгаа. Ардчилсан намын гишүүд дэмжихгүй гээд унах нь байна шүү. Энэ одоо эсрэг гараад. О.Амгаланбаатар аа.

**Д.Амарбаясгалан:** С.Бямбацогт гишүүн дэмжиж үг хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн алга байна.

Гишүүд заалттай холбоотойгоор үг хэллээ.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

25.7 шинэчилж найруулснаар. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос оруулж ирсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

47.9 хувиар санал унаж байна.

Жигжидийн Батжаргал гишүүн горимын санал.

**Ж.Батжаргал:** Би дэмжиж санал өгсөн юм. Тэгсэн чинь энэ техник дээр алдаа гараад энэ санал орсонгүй.

Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.1 хувиар хүчингүй болгох санал дэмжигдлээ.

Үндсэн Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 25.7. Санал хураалт. /алх цохив/

55.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

Үдээс хойш хуралдаанаар хэлэлцэх асуудал цаг хэмнэгдсэн учраас шууд хэлэлцээд явчихъя.

---

**Тав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль  
хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл  
/Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
анхны хэлэлцүүлэг/**

---

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

**Дав.Цогтбаатар:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдийн нэгдсэн чуулганаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн.

Хамтарсан хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс хуулийн үйлчлэх хугацааг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс гэж өөрчлөх санал гаргасныг хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

---

Мөн Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасны дагуу “Хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлах нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёоллын олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсөв болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ажил ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна.

Хажекберийн Жангабыл гишүүн асуулт асууна.

**Х.Жангабыл:** Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би баруун бүс баруун аймгуудын талаар ярина. Эндээс нэг жилийн өмнө мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Улсын Их Хурал Мал, амьтны тэжээл улаан буудайн гурилын гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан байна.

Энэ нэг жилийн хугацаанд импортоор орж ирэх гурилын татвар гурав дахин нэмэгдсэн. Нэг жилийн дотор 64.2 мянган тонн улаан буудайн гурил импортолсон гээд танилцуулга дээр бичсэн байна.

Энэ 64.2 мянган тонн гурилын бараг 40-өөс 50 хувь нь баруун бүсийн боомтуудаар орсон байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Цагааннуурын боомтоор 14.1 мянган тонн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мянган тонн импортоор улаан буудайн гурил импортолсон байна.

Энэ юу хэлээд байна гэхээр нэгдүгээрт баруун бүст тариалалт хийх ямар ч боломж байхгүй. Баруун бүст ажиллаж байгаа нэг ч гурилын үйлдвэр байхгүй.

Тэгэхээр Оросын Холбооны Улсын Алтайн хязгаар улаан буудай их тариалдаг. Оросын Холбооны Улсын хэмжээнд их хэмжээгээр улаан буудай гаргадаг, бас том том үйлдвэртэй. Одоо Аляскийн үйлдвэр байдаг. Жишээлэхэд. Монгол Улсад ихээхэн хэмжээний бүтээгдэхүүнээ борлуулдаг. Энэ үйлдвэрүүдээс 600 километр алслагдсан газраас энэ 2 боомтоор бараг л Монгол Улсын импортын 40-өөс 50 хувийг импортолсон байна.

Одоо юу болж байна гэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ төсөл батлагдсанаар газар тариалангийн салбар, гурилын үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, стратегийн хүнсний нөөцийг дотоодын үйлдвэрлэлээр хангах нөхцөл бүрдэнэ. Ийм эерэг үр дагавар гарна гээд яриад байгаа юм, тайлбарлаад байгаа юм.

Бэлчээр томтой. Энэ бол зөв л дөө. Дэмжиж байна. Гэхдээ сайд аа, баруун бүсийн бүсэд амьдарч байгаа ард иргэдийн гар дээр очих гурилын зохицуулалтыг яаж хийхээр төлөвлөж байна аа? Одоо жишээлэхэд Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн сум, Ховд аймгийн Мөнххайрхан, Говь-Алтай аймгийн Цээл, Алтай, Бугат сумуудад Улаанбаатар хотоос 2 мянгаад километр бартаат замаар гурилыг тээвэрлэнэ.

Улаанбаатараас өөр авах газаргүй. Гаалийн татварыг 15 хувиар хайнгуутаа Оросын Холбооны Улсаас импортлох боломжгүй.

Тэгэхээр малчид ялангуяа ямар ч орлогогүй болсон. Арьс шир, ноос ноолуур үнэд хүрэхгүй, бараг ноолуурыг авч байгаа аж ахуйн нэгж ч байхгүй, хувь хүн ч байхгүй байна. Ямар ч орлого байхгүй. Барааны үнэ нэмэгдээд байдаг. Дээрээс нь бодлогоор гурилын үнэ нэмэгдэхээр байна. Ялангуяа энэ баруун аймагт Та ямар гурилыг хямд ард иргэдэд хүргэх боломж байна. Тэр талаар Ж.Энхбаяр сайдаас асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Гишүүний асуултад хариулъя.

Үнэхээр Монгол Улсын өргөн дэлгэр нутаг орон, газар зүйн алслалттай холбоотойгоор тээвэр, худалдааны өртөг их өндөр. Ялангуяа гурил дээр нөлөөлж байгаа.

Нөгөө талаар гурилын үйлдвэрүүд маань газар тариалангийнхаа гол бүс нутаг, төвийн бүсдээ байрлаж байгаа. Ингээд цаад зах нь 2 мянган километр хүргэх асуудал, ингээд үнэ гарч байгаа.

Өмнө нь яаж зохицуулдаг байсан бэ гэвэл Хүнсний тухай хууль гэж байгаа. Хүнсний тухай хуулиар Засгийн газар тухайн жилийн ургац, валютын ханшийн өөрчлөлт, хүнсний тогтвортой байдал, нийлүүлэлт, баталгаат байдлаа дүгнээд зохицуулалт хийгээд явах бололцоотой буюу зохицуулдаг. Жишээлбэл, Баян-Өлгий баруун тал дээрээ бол квот олгох зохицуулалтаар баруун талынхаа тогтвортой байдлыг хангадаг.

Нөгөө талаас баруун талаар импортолсон гурил 5 хувийн татвартаа ордог төвийн бүс бол 15 хувийн татвартаа ордог гэх мэтийн зохицуулалтуудыг хийгээд явж байсан.

Хууль гаргаад түгжсэн хэмжээнд болохоор нэгдсэн зохицуулалт хийх буюу Засгийн газар асуудалд түргэн шуурхай хандах чадвараа алдаж байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийг цуцалсны дараа хэрвээ Их Хурал ингээд шийдвэл Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд зохицуулалт хийгээд үнийн нэг бодлогыг бариад зохион байгуулах бүрэн бололцоотой.

Энэ жилийн 2024 оны ургац боломжийн байсан. Нөөц бол хангалттай байна. Улаан буудайн нөөц ч бэлэн байна. Бэлэн гурилын нөөц ч байна. Импортоор бас өнгөрсөн хугацаанд 2024 онд 64, он гараад 17, ингээд 80 мянга гаруй тонн бэлэн гурил Монголд орж ирсэн. Нөөц хангалттай тул 2025 оны ургац хураалт хүртэл ямар нэгэн үнийн өөрчлөлт гарахгүйгээр зохицуулах бүрэн бололцоо бүрдсэн байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Ноолуур дээр бодлого явж байна. Ингээд “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд Улсын Их Хурлын баталсан төсвийн хүрээнд яам бүх эх үүсвэрээ дайчлаад ноолуур худалдан авалтыг хийсэн.

Хэрвээ үндэсний үйлдвэрүүдээ бид бэхжүүлж самнах хүчин чадлаа бэхжүүлээгүй бол энэ жилийн ноолуурын үнэ 50-иас 70 мянган төгрөг дээр л тогтох ийм эрсдэл байсан.

Харин бид үйлдвэртэй тулдаа, үйлдвэрээ бэхжүүлж амжсан тулдаа ноолуурын үнэ зүүн бүсэд гэхэд 150-иас 165 мянгаар эхэлсэн. Одоо дунд хангайн бүсэд 120-иос 140 мянга дээр явж байна. Одоо ингээд Баруун бүсийн



ноолуур эд одоо эхлэх гэж байна. Үүний бэлтгэл ажил, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүднээс Засгийн газар шийдвэр гаргасан.

Монголбанканд одоо асуудал хандсан байгаа. Монголбанк энэ асуудлыг дэмжигдвэл 500 тэрбум төгрөгийн вексел буюу өрийн бичиг үйлдвэрүүд дээр бичигдэж ноолуурыг худалдан авах дээр санхүүжүүлэхээр бодлого бол тодорхой. Одоо Монголбанкны хариуг бид хүлээж байна. Монголбанк энэ асуудал дээрээ бодлогынхоо зохион байгуулалт, арга хэмжээгээ аваад эргэж мэдэгдье гэсэн ийм хүлээлтийн байдалтай байгаа.

**Д.Амарбаясгалан:** Х.Жангабыл гишүүн тодруулж асууя.

**Х.Жангабыл:** Баруун аймгуудын боомтуудаар гурилын татварыг тэглэх асуудлыг Засгийн газар шийдэх боломжгүй болсон байна. Хуулиар тэгж урьд өмнө нь зохицуулдаг байсан байна. Одоо боломжгүй гээд тийм хариулт авлаа. Сайд аа, зөв ойлгосон уу?

Тэгэхээр гурилын үнэ баруун аймгуудад замбараагүй нэмэгдэх юм байна. Одоо энэ асуудлыг яаж шийдэх юм бэ? Дахиад танаас асууя. Гарц байна даа. Ямар арга байж болох вэ? Нөөц хангалттай байгаа юм байна. Ойлголоо.

Баруун аймгуудад тээвэрлэж аваачсан алтаар бүрсэн гурилыг яаж ард иргэд худалдаж авах юм бэ. Энэ дээр тодорхой хариулт авмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** 2025 оны төсвийн жил буюу энэ жил гурил дээр ямар нэгэн үнийн өсөлтгүйгээр явах бүрэн бололцоо байна.

Бид юу оруулж ирэх вэ гэвэл 2026 оны төсөв дээр бодлого оруулж ирнэ. Стратегийн хүнс болсон улаан буудай, гурилын тогтворт байдлаа хангахын тулд нэгдүгээрт жил бүр 100-аас доошгүй мянган тонн улаан буудайг худалдан авч улсын нөөц бүрдүүлэх. Нөгөө талаар бүсчилсэн байдалтай холбоотойгоор алслагдсан бүс нутагт тээврийн зардлын хэт их өсөлттэй нөлөөтэйгөөр үнэ өсөж байгаа байдлыг тогтворжуулалтыг төсвийн бодлогоор шийдэх бид санал оруулна. Тэр хүрээнд гишүүд идэвхтэй оролцож дэмжиж өгөөрэй.

Энэ бодлогоо бид аваад явбал үнийнхээ зохицуулалтыг энэ төсвийн арга замаар шийдэх бололцоотой. Хамгийн гол нь одоо бол энэ хаврын тариалалт эхэлж байна. Тариалалтаа бид идэвхжүүлэх, улаан буудайгаа тарих нь онцгой чухал байна.

Хэрвээ улаан буудайн тарилтыг бид алдвал маш том алдаанд орох гээд л... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Уг нь яах вэ, Ж.Энхбаяр сайдаас нөгөө гишүүдийн асуугаад байгаа чинь улаан буудай тарихын тулд гурил үнэтэй байг гэдэг зүйлээр биш ээ. Гурил нь хямдхан байх дээр аль аль талыг нь эрсдэлгүй байлгах зохицуулалтыг яаж хийх юм бэ л гээд л дээрээс хойш л асуугаад байгаа юм.

Тэгээд энэ дээр уг нь боломж гарцыг нээсэн. Улсын Их Хурлын тогтоол батлагдсан. Ер нь ард иргэдийн яг үндсэн гол хэрэглээ болсон гурил өнөөдөр үнэ нь нэмэгдэх нөхцөл рүү орвол ард иргэдийн худалдан авах чадвар улам бүр дордож байгаа энэ цаг үе дээр зөв тусах юм л гэдэг талаас нь гишүүд яриад байх шиг байгаа юм.

Түүнээс энд би одоо бас дахиад хэлэхэд энэ үндэсний үйлдвэрлэлээ юм уу, үндэснийхээ тариаланчдыг муу байгаасай гэж бодож асуудалд хандаж байгаа нэг ч гишүүн байхгүй.

Одоо хөдөө орон нутагт ялангуяа одоо жишээлбэл энэ хүүхэд багачууд, сургууль, цэцэрлэг гээд л энэ хэрэглэж байгаа хоол хүнсний бүтээгдэхүүний чинь 50 орчим хувь нь л гурил байгаад байна шүү дээ.

Гурил болон гурилан бүтээгдэхүүн. Тэгээд л энэ үнэ өсөөд явбал яах вэ л гэдэг эрсдэлийг маш их ярьж байгаа юм. Тэгээд таны энэ саяын үгэн дээр болохоор яах вэ? Энэ жилдээ үнэ нэмэгдэхгүй байх нөхцөл байгаа л гэж байгаа юм. Энэ жилдээ гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ үнэ нь цаашаагаа нэмэгдэх нөхцөл рүү орвол яах вэ. Түүнээс өмнө ямар зохицуулалт хийх вэ гэж.

Би тэгээд Ц.Болорчулуун даргаас асууя гэж бодож байгаа юм. 60 мянган тонн гурил өнгөрсөн жилээс хойш импортоор орж иржээ гэсэн дүн танилцуулсан. Хэд хэдэн сард хэд хэдэн тонноор хамгийн том худалдан авагч нар нь ямар компаниуд энэ гурилын импортыг хийсэн бэ?

Энэ гаалийн албан татварыг чөлөөлөхтэй холбоотой асуудал хэлэлцэж эхэлсэнтэй холбогдуулаад зарим иргэдээс бас мэдээлэл ирж байна лээ. Засгийн газраас гаалийн албан татварыг тэглэсэн хуулийг хүчингүй болгоё гээд хуулийн төсөл өргөн барьсантай холбогдуулаад зарим хэсэг нь татвар тавигдах гэж байна гээд урьдчилаад их хэмжээгээр гурил оруулж ирсэн тохиолдол байна шүү. Тэр дунд зарим нэг гурилын үйлдвэрүүд ч байх шиг байна гэдэг ийм мэдээлэл өгөөд байгаа юм. Тэгэхдээ энэ эргэлзээг тайлж өгөх үүднээс тодорхой хариулт, тоо мэдээтэй хариулт өгөх нь зүйтэй байна. Бас хоёр, гурван Улсын Их Хурлын гишүүн орж ирж асуусан байгаа юм.

Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт өгчих. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

**Ц.Болорчулуун:** Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун. Улсын Их Хурлын даргын асуултад хариулт өгье.

2024 оны 05 сарын 01-нээс хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 6, 7 сард рублийн ханш 32 хүртлээ буурсан байгаа.

Тэгэхээр хойноос гурил мэдээж хямд үнээр орж ирсэн. Нийт орж ирсэн гурилын 34 хувь нь 35.9 мянган тонн нь Сүхбаатар боомтоор орж ирсэн. Цагааннуур боомтоор 14 мянган тонн, Увсын Боршоо боомтоор 10 мянган тонн, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Завханы Арцуур боомтоор 3.9 мянган тонн гурил орж ирсэн байгаа.

Нийтдээ оруулж ирсэн аж ахуйн нэгжүүд 60 гаруй аж ахуйн нэгж оруулж ирсэн байгаа.

Ер нь бид баруун аймгаар нэлээд үнэ тогтвортой байлгах үүднээс баруун талын аймгууд дээр тухайн үед нь бас аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг авсан. Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж болгон нь энд оролцох нээлттэй боломж нь бүрдсэн учраас нийтдээ 60 гаруй аж ахуйн нэгжүүд орж ирсэн.

Гурилын үйлдвэрүүд, ганц нэг гурилын үйлдвэрүүд оруулж ирсэн нь импортоор өөрснөө гурил оруулж ирж байна гэдэг асуудал яригдаж байгаа. Үүнийг бид тэр нарийн мэдээллийг нь танд бас жич хүргүүлье.

Ер нь гурилын үйлдвэрүүд дээр очоод ажиллаад явж байхад хэрвээ бид үйлдвэрлэлээ хийж чадахгүй бол ажлын байраа хадгалах, ажилчдаа авч үлдэх энэ үүднээсээ болохгүй бол бид гурил оруулж ирээд савалдахад үйл ажиллагаа нь хэвийн явагдах ийм нөхцөлийг ч хангаж болох юм гэдэг асуудлуудыг бас хэд хэдэн гурилын үйлдвэрүүд ажлын хэсэг очиж ажиллаж байхад асуудал дэвшүүлж байсан.

**Д.Амарбаясгалан:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Төрөөс энэ эдийн засгийн гэх юм уу, бизнесийн зарим үнэ тогтоож байгаа харилцаанууд нэлээн оролцдог. Тэгээд яг энэ салбар, гурил, үр тариа, энэ газар тариалантай холбоотой нэлээн үнийн зохицуулалтуудаар оролцдог ийм төвөгтэй салбар байгаа юм.

Тэгэхээр яах вэ, үнийн энэ харилцаанд орж байгаа нь өөрөө хүнсний аюулгүй байдал, хангамжтай холбоотой үүднээс энэ л о зохицуулалтад орж байгаа гэж бодож байгаа.

Тэгэхээр яах вэ, энэ нь өөрөөр хэлбэл зах зээлийн зарчмаараа аж ахуйн нэгжид үйл ажиллагаа явуулна гэхээсээ илүү үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт хийсэн энэ компаниудын хэмжээнд харилцаанууд явагддаг.

Тэгэхээр илүү төвлөрөл явагдах. Өөрөөр хэлбэл ашиггүй учраас, зохицуулалттай учраас зарим ихэнх тоглогч нар энэ салбараас гарах магадлал өндөртэй байдаг.

Тэгэхээр төвлөрлийн үйл ажиллагаа тэртээ тэргүй газар тариалан дээр ч, гурил үйлдвэр дээр ч бас яг энэ чиглэл рүүгээ явах ийм хандлагатай байгаа.

Тэгэхээр би зүгээр энэ төвлөрөл дээр одоо жишээлбэл яг үүнийг яаж хүлээн зөвшөөрч байгаа юм гэдэг талаар бас нэгдүгээрт Ж.Энхбаяр сайдаас асууя. Энэ газар тариалангийн топ 3, одоо хамгийн том 3 тоглогч нь нийт салбарынхаа хэдэн хувийг эзэлж байна? Гурил үйлдвэрлэгчдийн эхний 3 одоо тоглогч нь салбарынхаа хэдэн хувийг бүрдүүлж байна. Тэгээд цаашдаа нэгдэж нийлэх процессууд хэр явах хандлагатай байна. Энэ талаар асууя.

Хоёрдугаарт нь, энэ төслийг Засгийн газраас өргөн барьж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд ер нь яг энэ үнийн харилцаанд орж байгаа асуудал дээр жишээлбэл стратегийн хувьд улсад хэрэгтэй учраас гээд олон шалтгаануудын үндсээр зах зээлийн биш зарчмаар энэ төслүүдийг хэрэгжүүлэх, 14 мега төсөл дотор ийм төслүүд бас явж байгаа.

Тэгэхээр эд нар дээр ер нь цаашдаа ямар байдал байх юм. Эцсийн хэрэглэгчээ бодох юм уу, стратеги, тэр улсын аюулгүй байдал гэдэг юм уу, стратеги тэр чиг баримжаагаа барих юм уу гэдэг талаар болон Засгийн газраас төлөөлөөд асуумаар байгаа юм. Тухайлбал, одоо жишээлбэл гангийн үйлдвэр дээр хувийн хэвшил хийх сонирхолгүй байгаа учраас төр хийе гэсэн байдлаар ярьж байсан.

Тэгэхээр одоо жишээлбэл эцсийн хэрэглэгч дээр очиж байгаа үнийн хувьд ч гэсэн үнэтэй байлгах юм уу, дотоодын үйлдвэрлэлээ хамгаалж үнэтэй байлгах юм уу, эсвэл эцсийн хэрэглэгчдийнхээ үнийг бас хамгаалж өрсөлдөөнөө нээх юм уу?

Тэгэхээр тэр хөрөнгө оруулалтууд чинь бас утгагүй болно. Тэгэхээр яг энэ зарчим одоо энэ гурил дээр яригдаж байгаа асуудал бас энэ 14 мега төсөл дээр яригдаж байгаа учраас Засгийн газраас энэ тал дээр хариулт байвал сонсъё гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Ажлын хэсэг дээр монопол 3 гол гол тоглогч гэснийг нэрээр нь хэлж өгөөрэй. Ямаршуу юм байдаг юм уу тийм гэж.

Үнэ зохицуулалттай асуудал байна. Энэ өөрөө их онцгой бүтээгдэхүүн. Хүнсний тухай хуулиар. Нөгөө талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл

баримтлал гээд бүх бодлогын бичиг баримт энэ стратегийн хүнс гэж томьёолсон байгаа. Цөөхөн бараа байгаа. Энэ дотор улаан буудай ороод байгаа юм.

Улаан буудай гурил бол Монгол Улсын стратеги, аюулгүй байдалд шууд нөлөөлөх, ард иргэдийн амьдрал амьжиргаа, улс төр, нийгмийн тогтвортой байдлыг гол нөхцөлдүүнэ гэж үзэж байгаа юм. Тийм болохоор Монгол Улс улаан буудайн тариалалтыг үе үеийн Засгийн газар, Их Хурал дэмжиж тогтвортой байдлаа хангахын тулд бодлогын арга хэмжээ авч ирсэн.

Тэгэхээр ийм үүднээс л тэр тариалалтыг урамшуулах, хөнгөлөлттэй зээл олгох, улаан буудай тариад хүнсний үйлдвэрүүдэд тушаасан тонн тутамд урамшуулал олгох гэсэн ийм бодлогууд яваад байгаа юм.

Үүнийг чөлөөт зах зээлд хаяж болох уу. Болно. 1990-ээд оны сүүлээр хаясан. М.Энхсайханы Засгийн газрын үед хаясан. Үндсэндээ Монгол Улсын газар тариалангийн салбар нурсан. Бүх талбай зэрлэгтээ баригдсан. Өр ширний гинжин хэлхээ үүссэн. Бүх аж ахуйн нэгжүүд, тэнд ажиллаж байсан аж ахуй, сангийн аж ахуйнууд бүгд татан буугдсан буюу дампуурсан.

Ингээд 10 хэдэн жил болсон. Үндсэндээ гаднаас гурилын хамаарал, улаан буудайн хамаарал, олон улсын зээл, тусламжийн хүрээнд л дотоод асуудлаа шийддэг байсан.

Энэ асуудлаас гаргах нь онцгой чухал гэж 2008 онд анх “Атрын-III” аян гэсэн бодлогыг Санжийн Баярын Засгийн газрын үед энэ бодлогыг хэрэгжүүлээд өдий зэрэгт нэг хүргээд ирж байгаа юм.

Газар тариалан буюу улаан буудайн үйлдвэрлэл босоод ирэхээр дагаад энэ эрчимжсэн аж ахуйнууд, гахай, тахиа, сүү, өндөгний аж ахуй чинь босож ирээд сүүлийн үед идэвхжээд байгаа нь энэ. Ерөөсөө л бүхий л хүнс бол газраас хамааралтай. Газарт юу тарьж ургуулж байна тэр маань хүний хүнсний гол нийлүүлэлт л тэндээс үүсэж байгаа юм.

Тэгэхээр энэ газар тариалангийн боломж маань манайд туйлын хязгаарлагдмал. Газар нутгийнхаа 0.1, 6-хан хувь буюу 900 гаруй мянган га-д л юм тарьж ургадаг ийм бололцоотой.

Тэгэхээр энэ салбараа тогтвортой авч явах нь л үнэхээр гол асуудал байдаг.

Тэгэхээр одоо тариалалт эхэлж байна. Тариаланчид хүлээж байна. Гинжин өрийн сүлжээ үүссэн байна. Өнөөдрийн Их Хурлын шийдвэрээс энэ салбар унах уу, босох уу, Монголын хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэр өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн энэ атрын бодлогууд, Хүнсний хувьсгал, Ерөнхийлөгчийн санаачилсан энэ бүх бодлого үр дүн яах вэ гэдэг шийдэгдэнэ.

Эхний сөрөг нөлөөлөл бодитой болоод эхэллээ. Хэрвээ энэ асуудал дэмжигдэхгүй бол энэ жил улаан буудайн тариалалт эрс унана. Хавар гэхэд бид гурилын дутагдалд орно. Харин эсрэгээрээ бид гаднын хамаарал эрс нэмэгдсэн, гаднын зах зээлийн хараат байдалд орох ийм байдал үүснэ.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгээс хариулт өгье. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

**Ц.Болорчулуун:** Д.Энхтүвшин гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Тэгэхээр ер нь гурилын үйлдвэрүүд яг тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 9 үйлдвэр л байна. Хүчин чадлын үед аваад үзэх юм бол жилдээ 25 мянгаас 150 мянган тонн буудай, гурил үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүд байгаа.

Яг сүүлийн дотоодоосоо тогтвортой хангаж байсан энэ үед дээд талын компани жилдээ 100 мянган тонн, 95 мянган тонн буудай тээрэмдэж нийт үйлдвэрлэлийн 30 орчим хувийг хангаж байсан. Тэрний дараачийн үйлдвэр нь гэх юм бол 50 мянган тонн буудай тээрэмдэж, нийт үйлдвэрлэлийг нь 16 хувийг хангаж байсан. Бусад нь 10 хувьтай гээд энэ үйлдвэрлэлд жигд байдлаар ордог. Энд бол яг үйлдвэрлэл... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**Ц.Болорчулуун:** Хүчин чадлын хувьд ялгаатайгаас биш яг энд бас тийм гол монопол маягаар оролцох үйлдвэрлэлүүд байхгүй. Жигдхэн үйлдвэрлэл явуулдаг гэж хэлэхээр байгаа.

Тариалангийн талбайн хэмжээгээр хамгийн дээд талын аж ахуйн нэгжүүд нийт талбай эзэмшиж байгаа компанийн байдлаар нийт тариалангийн талбайн 7 орчим хувийг буюу нийт 40 орчим мянган га талбайтай хамгийн том компани байгаа.

Тэгээд га-гаас авч байгаа ургацын хэмжээ их талбайгаас их хэмжээгээр авахгүй. Дээрээс нь мянган га-гаас 5 мянган га-гийн ургацыг авч байгаа ийм компаниуд байгаа учраас энэ газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд бас энэ дээр тийм монопол байдлаар оролцох боломж байхгүй л гэсэн ийм хариултыг танд хэлье.

**Д.Амарбаясгалан:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Тэгээд энэ төрийн оролцоо тодорхой хэмжээнд байгаа учраас бүтээмж сайжруулах үүднээс аж ахуйн нэгжүүд нэгдэж нийлэх процессууд явагдах байх гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл бүтээмжээ сайжруулах, тэр хүчин чадлын ашиглалт нь бага байгаагаа сайжруулж байж

илүү өрсөлдөх хэмжээний, илүү хямдхан бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоо боломжууд гарна.

Тэгэхээр яг энэ мөн чанарынхаа эсрэг бас аж ахуйн нэгжүүд рүүгээ үгсэж байна, тохирч байна гэдэг байдлаар нэлээн дайрч байгаа ийм хандлагууд харагдаж байсан. Тэгээд тэд нар өөрсдөө цөөхөн тоглогч нар тэд нар өөрсдөө хоорондоо ч хүртэл уулзаж чадахгүй айж нуугдаж явдаг. Тохирлоо гэхдээ. Яг бодит байдлаар ийм юм байхгүй харагдаж байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр яах вэ аж ахуйн нэгжүүдээ бас дэмжээд. Бэртээ тэргүй хөрөнгө оруулалт хийсэн энэ аж ахуйн нэгжүүдийн яг энэ мөн чанарт нь илүү нийцсэн байдлаар харьцах нь зүйтэй юм болов уу гэж бодож байна.

Тэгэхээр энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Тилеуханы Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Баярлалаа. Уг нь өнөөдөр их чухал асуудлууд л хэлэлцэж байгаа л даа.

Ер нь Улсын Их Хурлаар чухалгүй асуудал хэлэлцдэггүй. Энэ үед энэ хаврын тариалалт хаяанд ирчихлээ. Хаврын нэг өдөр намрын 10 өдөртэй тэнцдэг гэдэг. Яг ийм үед манай Ардчилсан намынхан маань буруу улс төр хийгээд. Сайд, дарга томилогдох болохоор өдөр шөнөгүй сууж байгаад л би сайд болно, чи сайд болно гээд л энэ танхимыг дүүргээд л сууж байсан. Одоо Б.Бейсен гишүүнээс өөр нэг ч Ардчилсан намын гишүүн алга. Харамсалтай л байна.

Улсын Их Хурлын чуулганд идэвхтэй суугаад энэ ард иргэдийн ахуй амьдрал, улс эх орны өмнө тулгамдсан эдийн засгийн ийм ээдрээтэй үед жижиг улс төр хийгээд хуралдаа суухгүй байгаа нь бас эвгүй харагдаж байна л даа. Одоо тэгээд сонгосон тойргийнх нь гишүүд маань Ардчилсан намынхаа гишүүддээ бас нэг анхааруулах нь зөв байлгүй дээ.

Нэг л асуулт байгаа юм. Дотоодынхоо хүнсний үйлдвэрийг бид тууштай дэмжиж байх ёстой. Үүний цаана үндэсний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал гээд чухал зүйлүүд дагаж явж байдаг. Аливаа нэг хүнсээрээ өөр нэг улсаас хараат байна гэдэг маань өөрөө төсөөлшгүй хүнд байдалд оруулдаг л даа. Одоо сая ковидын үед дэлхийн улс эх орнууд бүгдээрээ л дотооддоо хүнсээ хангах нь, дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжих нь ямар чухал юм бэ гэдгийг ковид сая сануулсан. Бид ой санамж богинотой хүмүүс л дээ. Мартчихдаг юм.

Тийм учраас энэ гурилын үйлдвэрийн салбар яах арга байхгүй гурилын үйлдвэрүүддээ асуудал байсан л байх. Гэхдээ нэг шанага будааг хөрш айлаасаа царай алдахгүйгээр бид ямар ч үед бэлэн байх ёстой. Тэр улаан



буудайгаар хангая, гурилаар хангая гээд байгаа улсуудад маань дайны байдалтай болчихвол яах юм. Давагдашгүй хүчин зүйл бий яах юм. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болоод ургац алдах байдаг юм уу, тариалалтаа хийх боломжгүй болсон үед бид эргээд харахад дотоодынхоо үйлдвэрлэлийг алдчихаад амаа бариад ч эргэж авчрахааргүй ийм алдагдал хүлээнэ шүү дээ.

Тийм учраас бид ямар ч нөхцөлд энэ үйлдвэрлэлдээ чирээд явах ёстой.

Тийм учраас нэг л санал байна. Асуулт байна. Энэ цемент, гурил мэтийн бүтээгдэхүүнүүдийнхээ татварын зохицуулалтын дээд, доод интервалыг нь Улсын Их Хурал тогтоож өгөөд түүнийхээ хүрээнд Засгийн газар шуурхай арга хэмжээ авдаг энэ механизмыг бид бий болгох шаардлагатай юм байна.

Одоо 126 гишүүнтэй болсон. Гишүүн бүр өөр өөрийн гэсэн үзэл бодолтой, өөр өөрийн гэсэн улс төр хийдэг арга барилтай ийм болсон үед энэ галтай сэдвийг энэ Улсын Их Хурал дээр байн байн авчраад байх нь зохимжгүй юм байна гэдгийг харуулж байна шүү дээ.

Дотооддоо үнэхээр гурилын үнээ нэмээд байгаа бол Засгийн газар яаралтай хуралдаад хилийн цаана хямдхан байгаа гурилыг татварын зохицуулалт хийгээд оруулъя гэдэг энэ механизмыг бид бий болгох шаардлагатай юм байна.

Саяхан хэдэн жилийн өмнө бид цементийн үйлдвэрүүдээ дэмжээд босгосон. Хувийн хэвшууд маань маань зүтгэж байж том том цементийн үйлдвэртэй болсон. Яг энэ зохицуулалтыг хийгээгүй байсны улмаас одоо нөгөө цементийн үйлдвэрүүд маань ч гэсэн эвгүй байдалд орсон байна шүү дээ. Одоо гурилын үйлдвэрүүд маань энэ чинь 20, 30 жилийн хугацаанд босгож ирсэн гурилын үйлдвэр. Дээрээс нь улсаас татаас өгч байж гурилын үйлдвэрүүдийг өнөөдрийн түвшинд хүргэсэн. Хайран 250 тэрбум төгрөг.

Тийм учраас үүнийг бид одоо энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд маань яг энэ хаврын тариалалт эхэлж байгаа энэ үед цаашдаа бид Монгол Улс дотооддоо хүнсээ хангадаг энэ чадавхыг бид тууштай хамгаалж явах ёстой. Улсын Их Хурал

Тийм учраас энэ татварын хуулийг одоо яг тэр дээд, доод интервалыг нь Улсын Их Хурал тогтоож өгөөд тэрийг нь Засгийн газар тухайн үед нь одоо тэр цаг үедээ тохируулаад шуурхай хөдөлгөөн хийдэг ийм боломжийг бий болох боломж бий юу? Ж.Энхбаяр сайд аа. Энэ асуудлыг бид эргээд ярихгүй бол дотооддоо нэг ч үйлдвэргүй болох нь. Цементийн үйлдвэрүүд чинь бас амаргүй байгаа. Гурилын үйлдвэрүүд чинь тэд нарын араас орох гэж байна гэсэн нэг асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр сайдын харин анхны санаа яг л ийм л байсан юм л даа. Тэгээд нөгөө хууль тогтоомжийн хуулиараа бас жоохон зарим хязгаарлалтууд ороод оруулж чадахгүй байгаад байх шиг байгаа юм. Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Хэрвээ энэ асуудал дэмжигдвэл Хүнсний тухай хуульд заасны дагуу хүнсний стратегийн гол нэрийн бараан дээр Хүнсний аюулгүй байдлын зөвлөл гээд Ерөнхий сайд ахалдаг ийм бүтэц байгаа. Энэ дээрээ нөгөө боомтуудынхаа квот, боомтуудын ялгамжтай татварын асуудал, тэгээд нөөцийн асуудал, баталгаат байдлын асуудал гээд олон асуудлаа тэр Хүнсний аюулгүй байдлын зөвлөл дээр яриад шийдэх бололцоо байдаг юм.

Тэгэхээр тэр зохицуулалтаараа л явна. Ер нь Засгийн газрын хурдтай шийдвэр гаргах тухайн цаг үед яаралтай хариу арга хэмжээ авах энэ чадавхыг л нээгээд өгмөөр байгаа юм. Энэ яг хууль болгоод ингээд түгжчихээр зайлшгүй хуулийн процедур, дамжих хугацаа алдах болоод нөгөө хурдтай маневрын арга хэмжээ дутаад байна.

Одоо гишүүд жишээлбэл шатахуун байна шүү дээ. Шатах, тослох материал. Энэ дээр чинь засаг бас их хурдтай шийддэг байхгүй юу. Үнэ унангуут татвараа бид яаралтай буулгаад, үнэ тэндээ унавал татвараа тогтворжуулаад, ингээд нөөцөө бүрдүүлээд, шаардлагатай бол валют буюу худалдан авахад нь валютын дэмжлэгийг нөгөө нийлүүлэгч компаниуд үзүүлэх мэтийн ийм зохион байгуулалтыг хийгээд явчихдаг юм. Гурил бас яг ингэж явж байсан. Улаан буудайн.

Тэгэхээр тэр боломжийг нь бид буцаагаад л нээгээд л авчих энэ хуулийн дараагийн үр дагавар нь тэр юм. Тэгэх юм бол илүү хурдтай, шуурхай буюу ийм асуудал үүсгээд цаг алдаад байх зүйл байхгүй болох юм.

**Д.Амарбаясгалан:** Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууна. Алга байна.

Энэ орон нутгаас сонгогдсон гишүүд орж ирж энэ ард иргэдийн амин чухал хэрэгцээ гурилын асуудал дээр асуултаа асууж, саналаа хэлбэл уг нь зохистой.

Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна. Алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Газар тариалангийн салбарынхан маань нэлээн хүлээлтийн байдалтай сар гаруй энэ асуудлыг хүлээгээд байж байгаа. Юугаа тарих вэ гэдгийг хараад байж байгаа. Тэгээд энэ цаг үед бас уг нь өнөөдрийн чуулганаар тал талынхаа

байр суурийг илэрхийлээд, заавал нэг туйлын зөв гэдэг энэ агуулга биш дундын шийдлүүдээ гаргаад, юугаа тариалах вэ гэдэг дээр нэг тодорхой болгоод өгчихвөл их чухал ийм байгаа юм.

Гэтэл яг энэ цаг үеийн хувьд хувийн хэвшлийг дэмждэг Ардчилсан намынхан маань орж ирээд байр сууриа хэлээд жоохон хамгаалаад энэ асуудлыг аваад гарах байх л ёстой байлаа л даа.

Тэгээд бидний нэгэндээ туньж гомдох бол нэг хэрэг асуудал. Яг үндсэн иргэдээс олгосон энэ ажлаа хийх асуудал иймэрхүү асуудлаас болоод хойш сууж болохгүй юм. Тэгээд үүнийг цаашдаа зарчмын хувьд бид бүхэн их анхаараад явахгүй бол. Маш чухал асуудал.

Одоо хэрвээ буцаад хэвээрээ үргэлжилбэл дахиад энэ жил газар тариалангийн салбар 30 хувиа алдах энэ эрсдэл рүү орно. Өмнөх жилийнхтэй харьцуулахад.

Тэгэхээр энэ асуудлыг бас ойлгож. Нэг бол хугацаагаа сунгаад хэлэлцэхгүй байх ёстой байлаа. Нэг бол орж ирээд саналаа өгөөд энэ дээр байр сууриа илэрхийлээд явах байлаа.

Маш том хариуцлагын асуудал үүний цаана гарч ирэх гэж байна гэдгийг би бас цохож хэлье.

Тухайн асуудалтай холбогдолтой, ер нь сүүлийн үед хөдөө аж ахуйн салбартай холбогдолтой асуудал дээр харахад хоёр зүйл дээр анхаармаар санагдаж байгаа энэ саналыг манай салбарынхан маань цаашдаа анхаарах нь зөв өө гэж бодож байгаа.

Хамгийн эхнийх нь бол ер нь салбарын бодлого, үйл ажиллагаа тогтвортой байхыг л шаардаад байгаа. Тэгээд сүүлийн үед орж ирж байгаа бүх томоохон төсөл, хөтөлбөрүүд дандаа улс төрч нарын манлайлал доор өрнөж байгаа нь зөв үү, буруу юу гэдэг дээр бид бүхэн бас дүгнэлт гаргах ёстой байна.

Салбарын суурь хуультай холбогдолтой асуудал, тодорхой зохицуулалтын асуудал ойлгомжгүй байгаатай холбогдолтойгоор ер нь үндсэндээ салбарын асуудлуудыг улс төрч нар маань өөрсдөө барьж санаачилж явж байгаа асуудлууд нэлээн сүүлийн үед ажиглагдаж байна.

Тэгэхээр хүнс, хөдөө аж ахуйн салбар өөрөө тодорхой салбарын бодлогоо нэг талд нь гаргаад явах зайлшгүй шаардлага, орон зай байгаагүй л энэ нөхцөл байдал харагдаж байна

Хоёр дахь нь, бодлогын хэрэгжилтийг бид бүхэн бас анхаарахгүй бол хоцрох байдлууд ажиглагдаж байна. Өнөөдрийн асуудал бас л хоцорч байгаа юм.

Ноолуурын асуудал 4 сар гарсан байхад бид эргэлтийн хөрөнгийнхөө зээлийг бүрэн дүүрэн олгож чадаагүй л байж байгаа. ЖДҮ-ээс хүлэмжийн чиглэлээр зээл авч байгаа иргэд маань хүсэлтээ өгч явсаар байгаад 6, 7 сард зээл нь бүтээд хүлэмжээ аваад яах вэ дээ.

Тэгээд улирлын чанартай явж байгаа энэ салбарын онцлогийг бид бүхэн урьдчилан харж хагас жилээр, жилээр энэ ажлуудыг хийх журмын болон бусад суурь асуудлуудыг зайлшгүй ярьж тодорхой болгох ийм шаардлага ерөнхий агуулгаараа байна гэдгийг хэлье.

Өнөөдрийн асуудалтай холбогдолтой тодруулах олон зүйлүүд байгаа. Хувийн хэвшлийн тариалалттай холбогдолтой асуудал дээр бид бүхэн энэ хуулийн төслийг би дэмжих ёстой гэсэн байр суурьтай байгаа. Ардчилсан намын гишүүд маань ч гэсэн орж ирээд энэ дээр байр сууриа илэрхийлээд ингээд яваасай. Энэ асуудал битгий унаасай гэсэн ийм байр суурьтай байгаа.

Үүнтэй хамт үндсэндээ яригддаг байсан тариаланчид гурилын үйлдвэрүүдийн хоорондын маргаан хөдөө аж ахуйн корпорац дээр хяналт шалгалт явуулдаг тэр лабораторийн асуудлаа бид бүхэн яах вэ гэдгийг үүнтэйгээ хамт уг нь ярих ёстой, шийдлээ бас ярих ёстой.

Өрсөлдөөнийг дэмжих чиглэл дээр, монопол байгаа, үгүйтэй холбогдолтой маргаантай асуудал бас л яригдаад өнгөрч байна. НӨАТ-тай холбогдолтой асуудал. Зарим хэсэг дээр нь НӨАТ-аас чөлөөлөөд, зарим хэсэг дээр нь давхар НӨАТ олгогдоод эцсийн дүндээ илүү өндөр бүтээгдэхүүн очиж байгаа.

Үнэ тогтворжуулах чиглэлээр авч байгаа энэ арга хэмжээ цаашдаа үргэлжлэх үү, үгүй юу гээд... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Үнэхээр хөдөө аж ахуйн салбар бол яг цаг хугацааны их айхтар мэдрэг. Хэрвээ тарилтын хавар нэг долоо хоног алдахад тэр нь намрын нэг сар болж хувирдаг. Тарьдаг юмаа тарьдаг цагт нь л тарина. Энэ хууль шийдсэний дараа ч юм уу, дараа нь тэгээд долоо хоногийн дараа тарина гэж байдаггүй.

Тэгэхээр тарих хугацаандаа л тарьж амжихгүй бол тэгээд л тэр жилийн ургац, тариалалт өөрчлөгддөг.

Одоо бид яг ийм зүйлийг яг одоо яриад сууж байна гэдэг бол маш хариуцлагагүй л байдал. Маш яаралтай шийдвэр гаргахгүй бол ажил эхэлсэн. Улаан буудайн тариалалт эрс унана. Бодитой. Намар гурил дутна. Энэ дээр үнийн өсөлтийн асуудал яригдана. Үүнийг хангахын тулд гаднаас нөгөө

хомсдоод байгаа валютаа авч очиж, гаднаас гурил гуйх, улаан буудай гуйх асуудал орно. Ерөөсөө тодорхой.

Өнөөдрийн асуудлаас л шийдэгдэж байна. Энэ ганцхан салбарын асуудал биш. Монгол Улсын эрх ашгийн асуудал. Гадаад орчин чинь маш хүнд байна шүү дээ. Гадаад орчин хүндрээд байна. Улс орон болгон тарифын бодлогоор аюулгүй байдлаа хангаж эхэлж байна. Нөөц бүрдүүлж байна.

Бид яаралтай хөдлөх хэрэгтэй байна. Тийм. Одоо жишээлбэл Бүгд Найрамдах Хятад Ард Улс гэхэд улаан буудайн дээр 65 хувийн босготой, хамгаалалттай. Солонгос Улс цагаан буудайн дээр 513 хувийн хамгаалалттай. Япон Улс цагаан буудайн дээр 340 хувийн хамгаалалттай гэх мэтийн дотоод зах зээл, дотоод үйлдвэрлэлийг дэмжсэн ийм бодлогууд яваад байна. Бид нөөц бэлдэх ёстой. Цаг үе тэгж шаардаж байна.

Тэгэхээр 26 төсөв дээр нөөц бүрдүүлэх санал оруулна. Дээрээс нь худалдаан дээр ингээд 30-аас 40 хувийн нэмэгдэл буюу алслагдсан бүсийн нэмэгдэл, тээврийн нэмэгдэл өндөр гарна. Гурил өөрөө хямд бараа тул тээврийн зардал өндөр тусаад байгаа. Үүнийг нөхөх бодлогыг бид оруулж ирнэ. Ялангуяа баруун бүсэд шаардагдаж байгаа 25-аас 30 мянган тонны үнийг тогтворжуулахын тулд тээврийн бодлогыг ингэж явуулъя гэдгээ бодлого бид оруулж ирнэ.

Ер нь энэ хэлэлцүүлгийн үр дүнд үнийн тогтвортой, хямд, баталгаат байдал их чухал гэдэг нь одоо хаа хаанаа ойлгож байна.

Тэгэхээр бид бодлого оруулна. Энэ жилийн ургац хураалт хүртэл нөөц хангалттай тул ямар нэгэн үнийн өсөлт гарахгүй. Хангалттай нөөц байгаа. Тэгээд жил жилийн ургацын байдлаас шалтгаалан үнийн хөдөлгөөн гарна. Үнийн өсөлтийг тогтворжуулахын тулд улс зайлшгүй улаан буудайн болон бусад бэлэн бүтээгдэхүүн нөөц барьж байх ёстой. Тэр бодлогоо л бид хэрэгжүүлэх учиртай.

Уг нь бодлого нь Их Хурлаас гарсан боловч төсөв дээрээ хасагдсан байгаа юм. Бид санал оруулсан. Нөөц бүрдүүлэх. Улаан буудайн болон бэлэн нөөц бүрдүүлэх бодлого оруулсан боловч бүгд хасагдсан. Боломжгүй байгаа.

Тэгэхээр ирэх 2026 оныхоо бодлого дээрээ гишүүд маань сайн дэмжиж өгөөрэй. Тэгвэл гурил дээр ахиж ийм үнийн асуудал гарах, ийм юм үүсэх шаардлага байхгүй болно.

**Д.Амарбаясгалан:** М.Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

**М.Ганхүлэг:** Байнгын хороон дээр яригдсан хуулийн төсөлтэй холбогдолтой дагаж гарах тодорхой чиглэлийг Засгийн газарт өгье гэдэг саналыг би бас хувьдаа дэмжиж байсан юм.

Тэгээд үүний цаана үлдэж байгаа байнга л яригддаг энэ асуудлуудаа ер нь яаж шийдэх вэ гэдэг дээрээ тодорхой шийдэлгүй үлдэж байгаа нь л гол асуудал болоод байх шиг байна гэж бодож байна. Миний хэлээд байгаа тэр лабораторийн асуудал. Дандаа байнгын маргаан гарч байдаг. Бусад тэр НӨАТ-тэй холбогдолтойн асуудал дээр зарим хэсэг дээр нь одоо үндсэндээ хөнгөлөөд, зарим хэсэг дээр нь хөнгөлөхгүй байгаа нь НӨАТ-ын давхар ачааллыг бий болгоод байгаа ийм бодитой үнэ дээр шууд нөлөөлж байгаа.

Өрсөлдөөнийг үндсэндээ яг яаж шийдэх вэ гэдэг дээрээ шийдлээ гаргаад явах энэ хувилбаруудыг бид бүхэн бас ярихгүй бол болохгүй байгааг хэлээд байгаа. Энэ дээр бид жаахан тодорхой байр сууриудыг гаргах шаардлагууд бас байлаа.

Тэгээд Их хурлын гишүүддээ хандаж хэлэхэд орж ирсэн төслийг үндсэндээ дэмжиж, тариалалтаа үндсэндээ эрчимжүүлээд... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя.

**З.Мэндсайхан:** Хэлэлцэж байгаа асуудлыг дэмжиж байгаа. Одоо тариалалт өнөө маргаашгүй л эхлэх боллоо.

Тэгэхээр тариаланчид маань ард иргэдийнхээ хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлд үр тариагаа тариалах энэ цаг хугацааны үед нь бид тодорхой байх ёстой.

Тэгэхээр өнөөдөр энэ асуудлыг дэмжиж, цаашдаа Монгол Улсын ард иргэдийн маань хүнсний аюулгүй байдлыг хангахад маш эгзэгтэй үед Ардчилсан намынхан маань орж ирж саналаа өгөх ёстой байх гэж уриалах байна.

Тариаланчдын хувьд гурилын үйлдвэрийн хувьд үүсдэг хамгийн том асуудал бол лабораторийн л асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээрээ яам маань бас цаашдаа үндэсний төв лавлагаа лабораторийнхоо нэгдсэн дүнг бариад явдаг энэ чиглэл рүү нь анхаарвал зөв юм болов уу гэж бодож байна.

Цаашдаа бид энэ хууль гарсан шалтгаан бол ерөөсөө л баруун аймгийнхны хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор л гарсан хууль. Энэ хууль хүчингүй болсноороо бид хүнсний хуулиараа Монгол Улсын Ерөнхий сайдын ахалдаг Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөрөө тарифын зохицуулалт хийгээд, баруун аймгуудын гурилын хэрэгцээг хямд үнээр хангах, Баян-Өлгий, Увсын боомтоор гурил чөлөөтэй импортлох боломжийг нь олгоод явах ийм боломж нь байгаа.

Тэгэхээр энэ дээр иргэд маань, ялангуяа баруун бүс нутгийнхан маань гурилын үнэ өсөх нь ээ гэдэг дээр ийм зохицуулалт цаана байна шүү гэдгийг та бүгддээ хандаж хэлэх байна.

Ж.Энхбаяр сайдаас асуух гээд байгаа нь одоо баруун аймгийнхны маань ноолуур одоо ид гарч байна. Миний хувьд Үндэсний “Цагаан алт” хөтөлбөр буюу хөнгөн үйлдвэрийг дэмжих бодлогыг Их Хурлаар өнгөрсөн жил санаачлан батлуул... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Микрофон.

**З.Мэндсайхан:** Өнгөрсөн жил Хөнгөн үйлдвэрийг дэмжих үндэсний “Цагаан алт” хөтөлбөрийг санаачлан боловсруулсан.

Тэгэхээр энэ бодлогын маань залгамж халаа, асуудал юу болж байна аа? Энэ жил нийтдээ 200 орчим тэрбум төгрөг гарсан. Энэ зээл маань гараад зүүн аймгуудын ноолуурыг авахад аж ахуйн нэгжүүд маань зарцуулаад дууслаа. Гол нь энэ самнасан ноолуур гаргахтай холбоотойгоор дундын зуучлагч буюу ченжүүд маань энэ бодлогыг бас унагаах гэж нэлээн их акц хийх шиг боллоо. Энэ дээр би бас салбарыг тууштай байгаад их талархаж байгаа.

Тэгэхээр цаашдаа баруун аймгийнхны ноолуурыг авах чиглэл дээр тийм ээ, үнэ унагаахгүй, иргэдийн маань гол орлого болсон ноолуурын энэ асуудал. Мөн бүс нутгуудад тэр анхан шатын боловсруулах үйлдвэр, “Цагаан алт” хөтөлбөрийн маань хэрэгжилтийг хангахад яам ямар бодлого барьж байна?

Засгийн газраас баруун аймгийнхны ноолуурыг авахад ямар нэгэн нэмэлт санхүүжилт гаргаж байна уу? Энэ тал дээр та нэг тодорхой хариулт өгөхгүй бол... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гурил ярьж байгаа. Зөвхөн гурилтай холбоотой, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт өгнө. Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** З.Мэндсайхан сайд өөрөө манай салбарын сайд. Энэ “Цагаан алт”, “Атар”, “Хүнсний хувьсгал” гээд олон хөтөлбөрийн гол санаачлагч, авторуудын нэг. Нөхцөл байдлыг сайн мэдэж байгаа.

Гурил дээр үнийн тогтвортой байдлыг Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөрөө зохицуулалт хийгээд квот болон бусад бодлогоор зохион байгуулна. Нөөц хангалттай байна. 2026 онд зайлшгүй төсөв дээр тодорхой зардлууд суулгана. Нөөц 100 мянгаас доошгүй улаан буудайн нөөц бүрдүүлэх. Дээрээс нь гурилын үнийн нэмэгдэл болж байгаа алсын бүсийн нэмэгдэл, тэр тээврийн зардал дээр үйлдвэрүүдтэйгээ хэрхэн тооцоо хийгээд тохирох асуудлаа тохироод бодлого оруулж ирнэ. Түүгээр бид зохицуулах бүрэн бололцоотой.



Бас бололцоо болсных ноолуурын худалдан авалт, зохион байгуулалт идэвхтэй явагдаж байна. Их Хурлын даргын дэмжлэгтэйгээр Монголбанк 500 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргах энэ хувилбараа үндсэндээ эцэслээд ойрын үед бидэнд шийдлээ өгнө гэсэн.

Засгийн газар асуудлаа шийдсэн. Байнгын хороодод бас дэмжсэн асуудлуудаа шийдсэн байгаа.

Бид дотоод нөөцөө шахаад нийт яг өнөөдрийн байдлаар 330 тэрбум төгрөгийн эх үүсвэр ноолуурын худалдан авалтад гаргасан. Үндэсний үйлдвэрүүд маань үндсэндээ зүүн бүсийн болон төвийн бүсийн ноолуурын худалдан авалтыг амжилттай хийгээд бараг дуусах шатдаа орж байна.

Одоо баруун бүсийн буюу гол цөм ноолуур байдаг баруун бүсийн ямаа самналт одоо ид эрчимжинэ. Энэ 5 сарын 10-аар нэлээн жигдрэх байх. Тэгээд энэ үед бид 500 тэрбумын Монголбанкны энэ асуудал ойрын үед шийдэгдэнэ гэж хүлээлттэй байна. Ингээд зохион байгуулалтаа хангаад явчихвал бид дотооддоо ноолуураа 100 хувь аваад, үндэсний үйлдвэрээ дэмжээд явчихна.

Хэрвээ бид энэ бодлого хийгээгүй, үндэсний үйлдвэр буюу “Цагаан алт”-аар самнах үйлдвэрүүдээ хүчин чадлаа өргөтгөөгүй байсан бол энэ жилийн манай ноолуурын зах зээлийн үнэ 50 мянгаас 70 мянгаар тогтох ийм тооцоотой байсан.

Бид урд хөршийнхөө үйлдвэрт өгөхөөс аргагүй ийм байдалтай л байсан. Урд хөрш маань худалдааны татвартаа орчихсон. Тэр татварын зөрүү, уналт манай малчид дээр ирэх байсан. Харин үндэсний үйлдвэртэй байхын давуу тал бол ноолуураа бид сая зүүн бүсэд 150-иас 165 мянгаар, төвийн бүсүүд өнөөдөр 120-иос 140 мянгаар худалдан авалт амжилттай яваад өндөрлөж байна. Одоо ингээд баруун бүс рүү долларын худалдан авалт явна.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

**Х.Булгантуяа:** Бид мэдээж гурилаа гаднаас гуйж идэхгүй юмсан, манай дотоодын үйлдвэрлэл хөгжөөсэй гэж бодож байгаа. Аж ахуйн нэгжүүдээ дэмжинэ гэдэг нь бас ард иргэдийн амьжиргааг бууруулна гэсэн үг ерөөсөө биш. Салбарын том бодлого явалгүй яах вэ. Тэгэхдээ нөгөө талдаа яг одоо бид нарын гол яриад байгаа зүйл нь үндэслэлгүй үнэ нь нэмэгдээд байгаа юм биш үү. Үүн дээр салбарын яам хяналт тавьж бодлогоо барьж чадаж байгаа юу гэдэг асуудал.

Өнгөрсөн жил энэ хууль батлагдахад яг үнэнийг хэлэхэд бүр аргаа бараад ингэсэн. Бараг 2 жил засгийн хурал дээр ярьсан юм. Үгүй ээ, энэ гурилын үнэ бүр огцом нэмэгдээд байна. Энэ яг салбарын яам энэ дээр ямар бодлого барьж байна вэ? Хянаж чадаж байгаа юу? Дээрээс нь нэмээд ялангуяа

энэ алслагдсан аймаг орон нутгийн иргэдийн угаасаа орлого муу, дээрээс нь нэмээд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ нь өндөр байх юм бол энэ ядуурлын түвшин өндөр байгаад байна гээд. Одоо хамгийн сүүлийн ядуурлын түвшний судалгаагаар манай баруун аймаг бол их хүнд гарсан байна лээ.

Тэгэхээр ийм байгаа цагт бид 2022 оны жишээлбэл 8 дугаар сард 1 дүгээр гурил 1770 орчим байж байгаад, 2023 оны 5 сард 2700. Мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Тэгээд ингээд сүүлдээ салбарын яам 2 жил хүлээгээд яасан нь дээр вэ, салбарын яам бодлогоо хэлээч. Бид яавал энэ гурилын үнийг ингэж огцом нэмэгдэж иргэдийн амьжиргаанд нөлөөлөхгүй байлгах вэ гээд аргаа бараад сүүлдээ иргэдийн амьжиргаагаа дэмжье. Цар тахал, ковидын дараа эдийн засаг бас хүнд байна. Дөнгөж хүмүүсийн цалин орлогыг бид дөнгөж сая нэмж байна. Гэтэл үүнийгээ дагаад хэрвээ гурилын үнэ нэмэгдээд байх юм бол монгол хүн нэг хүн дунджаар 100 килограмм гурил, гурилан бүтээгдэхүүн хэрэглэдэг.

Тэгэхээр энэ бол иргэдийн амьжиргаанд нөлөөлнө гээд өөрийн эрхгүй энэ арга хэмжээг авсан юм.

Тэгэхээр одоо яах вэ, би энэ хуулиар нэлээн уян хатан зохицуулалтыг Засгийн газар өөрөө хийх юм байна. Ялангуяа манай баруун аймгийнхны хувьд хүсэх юм бол. Эсвэл одоо тэнд үйлдвэрлэлийг нь дэмж, эсвэл цаанаас нь арай хямдхан гурил идэхийг нь энэ зохицуулалтыг нь хийж өгөх хэрэгтэй. Нэг талдаа бид дотоодын үйлдвэрлэл, аюулгүй байдал гэж ярьж байгаа ч гэсэндээ хүн амьжиргаа байх чинь бас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлого шүү дээ.

Хүн нэгд амьжиргааныхаа наад захын хэрэглээнүүдийг аятайхан хангах чинь бас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлого байх гэж бодож байна.

Нийтдээ ер нь 2010-2024 оны хооронд хүнс, хөдөө аж ахуйн салбарт нийтдээ 1.1 их наядын татаас, дэмжлэг үзүүлсэн байна. Зөвхөн 2023 онд гэхэд нийтдээ 110 орчим тэрбум төгрөгийн дэмжлэг гурилын үйлдвэрүүдэд үзүүлсэн байна лээ.

Тэгэхээр нэг талдаа бид дэмжүүлээд байгаа мөртлөө нөгөө талдаа яг үнэнийг хэлэхэд нэг их гадаадаас дутахааргүй хамаагүй өндөр цалинтай, орлоготой хүмүүсээс дутахааргүй бид хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэтэй байгаа шүү.

Тэгэхээр үүнийг бас нөгөө талдаа бодож авч үзэх хэрэгтэй. Тэгээд Ж.Энхбаяр сайд аа, та ингээд юу яахаар бид нэг ийм үндэсний аюулгүй байдлын эсрэг юм яриад байгаа юм шиг яриад байх юм. Уг нь бид. Яг эсрэг ярьж байна гэдэг чинь яах вэ, ард түмний амьжиргааг ярьсан нь үндэсний

аюулгүй байдлын эсрэг юм яриад байх шиг байна. Би одоо бас иргэдийн амьжиргаа, цалин тэтгэврийн асуудал хариуцдаг сайд байсан.

2023 оны 7 сард бид төрийн албан хаагчдын цалинг 30-аас 50 хувь нэмэхэд яг дагаад л гурилын үнэ нэмэгдсэн. 2024 оны 4 сард цалин тэтгэвэр нэмэхэд яг дагаад л нэмэгдсэн. Тэтгэвэр нэмэгдэхэд яагаад гурилын үнэ давхар нэмэгдээд байгаа юм. Энэ хоёрын логик ойлголтыг би сайн ойлгохгүй байгаа юм.

Тэгэхээр ийм байгаа цагт бид үнэнийг хэлэхэд яах вэ 5 аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг ярихаас илүүтэйгээр 3.5 сая хүний амьжиргааны асуудлыг ярих нь энэ Улсын Их Хурлын бас нөгөө талдаа эрх ашиг байх гэж бодож байна.

Тэгээд үүнийгээ одоо Улсын Их Хурал дээр Засгийн газар зохицуулалтаа хийгээд, иргэдийн амьжиргааг дэмжих нэг бодлогыг бас та бүхэн маань авч үзээрэй. Энэ салбарыг тасралтгүй дэмжихгүй биш дэмжиж байгаа. Дэмжих нь зүйтэй гэж бодож байгаа. Гэхдээ нөгөө талдаа алдаа бас их байгаа гэдгийг та ч гэсэн өөрөө мэдэж байгаа байх гэж бодож байна.

Өмнөх олон сангийн асуудлууд, тариалангийн... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ж.Энхбаяр сайд хариулах юм уу? Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Тэр үнэ яагаад өссөн гээд. Энэ 2023-аас 2024 оны ургацтай холбоотой байхгүй юу.

Оросын Холбооны Улс дайны байдалд орсон. Дизель түлш 47 хувь өссөн. Монгол төгрөг рубльтэй харьцах харьцаан дээр маш том ханшны зөрүү гарсан. Газар тариалангийн үнэ бий болж байгаа гол өртөг бордоо, шатахуун, ургамал хамгааллын бодис, техник, сэлбэг бүгд Оросын Холбооны Улсаас импортолж байгаа.

Нөгөө талаар эргээд санавал 2023 оны намар маш их нөгөө хур тасралтгүй үргэлжилсэн бороо их орсон. Улаан буудайн өрөө түрүүн дээрээ соёолоод буюу хураагаагүй байхад соёолоод улаан буудайн гурилын үйлдвэрлэлийн чанарт байдал их унасан юм.

Иймэрхүү нэг ийм нөхцөл байдлууд ингээд үүссэн. Тэр бол саяын үнэ өсөлт дээр буюу нөхцөл байдал үүсэхэд их нөлөөлсөн л дөө. Яагаад ингэсэн юм бэ гэдгийг би их бас эргээд ингээд нэлээн нөхцөл байдлыг хараад нэг судлаад үзэхэд.

Ажил авснаас хойш тогтвортой байдлыг хангахын төлөө бүх зохион байгуулалтыг хийсэн. Мах ч тэр, гурил ч тэр тогтвортой, хүрэлцээтэй нөөцтэй байгаа шүү.

Мэдээж урьд өмнөх бид нөхцөл байдал чинь ялангуяа хөдөө аж ахуйн юм чинь тухайн жилийн өвөлжилтөөс их шалтгаалж байна. Тухайн жилийн ургацаас их шалтгаалж байна. Их л хурдтай, маневртай Засгийн газар богино хугацааны хариу арга хэмжээ авахаас их шалтгаалдаг зүйл шүү дээ.

Тэгээд манайх чинь өөрөө байгаль цаг уурын эрс тэс, бас нэг газар тариалан эрхлэх тийм таатай бүс нутаг бас биш ээ. Чөлөөт зах зээлд нь орхиод явах юм бол бид энэ Оросын Холбооны Улсын манайхаас 2-оос 3 дахин өндөр ургац авдаг. Харьцангуй өндөр чийгтэй, бүх түүхий эд, шатахуун, сэлбэг техникээ өөрсдөө үйлдвэрлээд, дээрээс нь бодлогын бүх талын дэмжлэг татаас өгдөг. Оросын газар тариалан улаан буудайн үйлдвэрлэлтэй бид өрсөлдөх бололцоо байхгүй шүү дээ.

Энэ стратегийн бараа гээд байгааг л та нар ойлгоод үз. Цөөхөн бараа байгаа юм. Бусад бараа бол хамаагүй. Зөвхөн стратеги буюу ямар ч онц байдлын үед онцгой байдал үед, дайн бүхий байдал үед хүн амын тогтвортой хэрэгцээг хангах улаан буудайн гурилыг улс дотооддоо зайлшгүй бий болгож бүрдүүлэх нь энэ бол Монгол Улсын стратеги юм. Стратегитайгаа юу гэсэн үг юм бэ гэвэл аюулгүй байдал юм. Зайлшгүй байх ёстой нөөц юм. Зайлшгүй дэмжих ёстой салбар юм гэж л яриад байгаа юм л даа.

Эдийн засаг талаас нь харвал дандаа эсрэг гарна. Тэгээд бид 90-ээд оны сүүлээр нэг туршаад үзсэн. Арай гэж сэргээх том бодлого явсаар байгаад өдийд нэг хөл, гар нь олоод тэнцээд эхэлж байна. Тэгээд үүний л хоёр шийдэл байхгүй юу даа. Стратеги мөн үү, биш үү гэж. Хэрвээ стратеги гэж үзвэл дэмжих ёстой. Цаашдаа ч дэмжих ёстой.

Дэлхийн гол гол улс орнууд бүгд дотоодын стратегийнхаа гол гол хүнсийг. Одоо би түрүүн хэллээ. Япон гэхэд л 340 хувь, Солонгос гэхэд 500 хувийн ийм татварын бодлогоор цагаан будаагаа дэмжиж хаадаг шиг бид бас ингэж явах л учиртай юм байхгүй юу даа.

**Д.Амарбаясгалан:** Х.Булгантуяа гишүүн тодруулж асууя.

**Х.Булгантуяа:** Тэгвэл энэ зохицуулалтуудаа Та бүхэн маань арай эрт авч болохгүй байсан юм уу? Би одоо нэг хэдэн тоог хэлье.

Баруун аймгуудын ядуурлын түвшин. Говь-Алтай аймаг 42.4 хувь. Улсын дундаж 27.8 хувь байгаа. Аймаар сонсогдож байгаа биз. 42.4 хувь. Ховд аймаг 39.7 хувь.

Тэгээд ийм аймаар үнийн өсөлт яваад байхад яасан нь дээр вэ гээд Ц.Болорчулуун дарга аа, Засгийн газрын хурал дээр үгүй ээ мөн олон удаа асуусан даа. Ямар арга хэмжээ авбал энэ ядуурлын түвшнийг бууруулах вэ? Ямар арга хэмжээ авбал энэ гурилын гол бүтээгдэхүүний үнийн өсөлтийг барих вэ? Хэн ч дотоодын үйлдвэрлэлийг унагая гэж бодоогүй. Тэгтэл та нар ямар ч арга сэдээгүй. Одоо баруун аймгийнхныг тэгвэл ядаж цаанаасаа арай хямдхан гурил идэх үүд хаалгыг нь нээе гэдэг асуудлыг Та бүхэн яриагүй шүү дээ. Аргаа бараад үүнийг өөр газраас энэ хуулийг чинь оруулж ирж тухайн үед батлуулж байсан.

Тэгэхээр энэ арга хэмжээнүүдийг авч чадаагүй чинь үр дүнд ингээд ядуурал өсөөд байгаа юм. Төрийн албан... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Яах вэ, би энэ дээр бас нэг тодруулаад хоёр зүйл хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна л даа.

Тэгэхдээ энэ гурилын үнийн өсөлттэй холбоотой асуудал бол ерөөсөө Ж.Энхбаяр сайдтай огт холбоотой асуудал биш. Ж.Энхбаяр сайд сайд болсноос хойш гурилын үнэ харин бууралттай байгаа нь үнэн. Өнгөрсөн жил ийм арга хэмжээ авсанаас хойш 1 дүгээр гурилын үнэ 9 хувиар буурсан байна, 2 дугаар зэргийн гурилын үнэ 15 хувиар буурсан байна.

Асуудлууд тодорхой түвшинд зорилгоо хангаад явчихсан байна уу гэвэл явсан байгаа юм.

Тэгэхдээ Ц.Болорчулуун дарга аа, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас мэдээллийг их зөв өгч байхгүй бол одоо сая З.Мэндсайхан гишүүн бас л буруу мэдээлэл өгчхөөд л гарч байна шүү дээ.

2021 оноос эхэлж гурилын үнэ нэмэгдэж эхэлсэн байхгүй юу. 2021 оноос. Тийм ээ. 2021 оноос эхлээд гурилын үнэ жил болгон огцом нэмэгдсэн. 2022 онд гурилын үнэ 60 орчим, 57 хувиар нэмэгдсэн. 2022 онд шүү.

Ингээд иргэдийн зүгээс гомдол гаргаад 2022 оны 9 дүгээр сард Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас гурилын үйлдвэрүүдэд шалгалт оруулсан. Үнийн өсөлттэй холбоотойгоор.

Ингээд гурилын үйлдвэрүүд дээр очоод хамаарал бүхий этгээдүүдийн эзэмшдэг гурилын үйлдвэрүүд нь нэг цаг хугацаанд ижил дүнгээр гурилын үнийг нэмэгдүүлсэн байна гэдэг дүгнэлтийг гаргасан.

Тэгээд нөгөө дүгнэлт гарсантай холбогдуулаад нөгөө гурилын үйлдвэрүүд гарсан шийдвэрийг нь шүүхэд өгсөн. Тэр хоорондоо хувь хувьцаа эзэмшлийнхээ асуудлуудыг зохицуулаад нэг жилийн хугацаанд шүүхээ хойшлуулж байгаад зохицуулсаны дараа шүүх дээр яваад очихоор өө энэ чинь бас шууд

хамааралтай биш юм байна. Тийм учраас гэдэг байдлаар шийдвэр гаргасан байгаа юм. Ингээд яах вэ шүүхийн шийдвэр гарсан.

Үр дүнгээр нь 2021-2024 оны хоорондох 3 жилийн хугацаанд гурилын үнэ 78 хувиар өссөн. Гэхдээ би З.Мэндсайхан гишүүний саяын хэлсэн дээр хэлж байгаа юм.

Одоо татвар чөлөөлснийг буцаачхаад яг өмнө нь байсан нөхцөл дээр буцааж очих гэж байна шүү дээ. Өмнө нь байсан нөхцөл дээр. Тэгэхдээ бид ингээд зохицуулж болох байсан юм гэдэг асуудлыг хөндөөд байгаа юм.

3-ын 3 жил гурилын үнэ тасралтгүй өсөж байхад юу ч хийгээгүй байхгүй юу. Тэгчхээд одоо болохоор энэ татвар тэглэснийг нь болиулчихаад бид ахиад зохицуулалт хийчихье гэдэг тайлбарыг хэлж байгаа нь өөрөө шударга биш байна. Иргэдийн амьдралын амьжиргаатай холбоотой асуудал гурилаас шууд хамаарна. Хөдөө орон нутагт ялангуяа. Улаанбаатар хотод энэ захын гэр хорооллууд, тэгээд л ер нь л амьдралын баталгаажих түвшнээс дундаж, түүнээс доош орлоготой иргэдийн хувьд гурил гол л хэрэглээ байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ерөөсөө эсэргүүцэж байгаадаа гол нь биш, зохицуулалтаа зөв хийж авч явах гарцаа нээж аваарай. Энэ дээрээс татвар тавьж болно. Гэхдээ цааш нь яаж зохицуулж иргэдэд хямд өртөгтэй, чанартай гурилаар үйлчилдэг болох вэ л гэдэг сонголт руу яваарай гэдэг асуудлыг хөндөж байгаа юм.

Мэдээж энэ тариалангийн салбараа хамгаалах гээд энэ салбарын сайд зүтгээд зориод явж байгааг ерөөсөө үгүйсгэж байгаа юм байхгүй. Энэ салбар хөл дээрээ босож байгаа. Зөв. Энэ салбарт тэгэхдээ шударгаар бизнес хийдэг шударга өрсөлдөөнтэй байх ёстой гэдэг шаардлагыг бас л тавьж байгаа юм.

Тэгэхээр энэ мэдээллүүдээ хэдүүлээ ядаж 2 жилийн өмнөх нөхцөлөө санаж, бодож ямар хэмжээнд энэ гурилын үнэ өссөн бэ, яагаад арга хэмжээ авч чадаагүй байж байж ийм эцсийн арга хэмжээ авах түвшинд хүрсэн бэ гэдгээ их сайн бодож ярих нь зөв шүү.

Түүнээс өнгөрсөн хугацаанд авсан арга хэмжээгээ өө энэ ер нь буруу байсан, эсвэл зөв байсан гэдгээр мэтгэлцэж, маргалдах асуудал тусдаа асуудал шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

**М.Бадамсүрэн:** Миний хувьд Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрүүтэй санал гаргаж, энэ хуулийн төслийг дагалдуулж тогтоолын төсөл гаргах нь зүйтэй юм уу гэж үзэж Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан дээр санал хураалгасан боловч дэмжигдээгүй.



Гэхдээ би бас яагаад энэ зүйлийг гаргасан юм бэ гэдгээ нийт Их Хурлын гишүүдэд, иргэдэд хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ер нь ард иргэдээ ч бодсон, аж ахуйн нэгжээ ч бодсон хамгийн боломжит ийм шийдлийг бид гаргах ёстой шүү дээ. Тэгээд энэ санаачилсан тогтоолын төсөл хэрвээ энэ импортын татварыг эргэн сэргээж тогтоосноор дотооддоо магадгүй өмнө үүсэж байсан ийм үгсэн хуйвалдаж монопол байдлаар үнэ нэмсэн тохиолдол үүсэх юм бол Үндэсний статистикийн хорооны гаргаж байгаа 3-аас 6 сарын дундаж дүнгээр үнэ нэмэгдэх юм бол дахин Засгийн газраас энэ гаалийн импортын гурилын тэжээлийн албан татвар 15 хувь, 5 хувийг эргэж тэглэх энэ асуудлыг оруулж ирэх болзолтойгоор энэ үндэсний үйлдвэрлэлүүдээ, тариаланчдаа дэмжиж байгаа энэ бодлогыг дэмжих нь зүйтэй юм уу гэдэг ийм дундын хувилбарыг л үндсэндээ санал болгож оруулсан юм л даа.

Тэгээд ингэж тэр үнэхээр монопол байдалтай байгаа гэж үзээд байгаа, үгсэн хуйвалдаад байгаа гэж үзээд байгаа гурилын үйлдвэрүүд байгаа бол энэ дээр Монгол төрийн гаргаж байгаа энэ шийдвэр бас нэгийг бодож, хоёрыг тунгаах энэ зүйл рүү чиглүүлэх ёстой гэж бодож л би энэ төслийг санаачилсан юм.

Тэгээд үүнийг бас уг үндсийг нь зөв ойлгуулахгүй бол. Энэ хүрээндээ ямар ач холбогдол гарах вэ гэхээр сая салбарын сайдын хэлээд байгаа тэр зохицуулалтуудыг ингэж оруулж ирье. Хүнсний тухай хуулиараа Засгийн газарт ер нь эрхийг нь өгөөд тэгээд маневр хийдэг, уян хатан ийм шийдвэр гаргадаг энэ боломжийг нь шийдэж өгөхгүй Улсын Их Хурал дээр эцсийн байдлаар хаагаад, эсвэл нээгээд байгаа учраас болохгүй байна гэж байвал энэ хүрээндээ энэ саналуудаа оруулж ирээд тэгээд дахин парламентын түвшинд иргэдийн дунд ийм маргаан үүсгэхгүйгээр Монголын төр юм бол энэ стратегийн гэж нэрлэж байгаа энэ гурилынхаа үнийг зохицуулаад явах боломж туурга тусгаар Монгол Улсын хувьд, Монголын төрд бол байх ёстой шүү дээ.

Тэгээд энэ үүднээсээ энэ саналыг хэлж байгаа юм. Тэгээд яагаад гурилын үнэ үндсэндээ нэмэгдээд байна гэхээр ингээд өнгөрсөн 2021 оноос нэмэгдсэн гээд сая Их Хурлын дарга танилцууллаа.

Энэ эрэлт нийлүүлэлтийн хуулиараа зах зээл маань өөрөө зохицуулагдаж байгаа шүү дээ. Эрэлт нийлүүлэлтийн хуулиараа. Эрэлт нь нэмэгдээд тэгээд нийлүүлэлт нь тодорхой хэмжээнд тодорхой гурилын үйлдвэрүүд байгаад байвал үүнийг чинь хувийн хэвшил чинь ашгийн төлөө явж байгаа юм чинь ашгийнхаа хэмжээг нэмэгдүүлсэн гэдэг нь тэгээд энэ хяналт шалгалтаар тогтоогдсон юм шиг байна лээ гэж би ойлгож байгаа юм.

Хэрвээ тийм биш үүнийг Ц.Идэрбат гишүүний хэлдгээр тэрийг нь нэр төрийг нь сэргээх хэрэгтэй. Гурилын үйлдвэрүүдийн. Үнэхээр тэгж тогтоогдож байгаа үүнийг одоо үнэхээр ийм байсан юм байна гэдгийг нь тогтоогоод



Монголын төр, төр шүү дээ. Энэ чинь ард түмнээс байгуулагдсан парламент. Тэгээд төр нь ард түмнийхээ өмнөөс шийдвэрээ гаргаад ингээд тогтоол ер нь баталж гаргаад ингээд хугацаатай даалгавар өгөөд үнэ нэмэгдүүлэхгүй байх боломжийг Засгийн газарт нь өөрт нь даалгахад юу нь болохгүй байгаад байгаа юм бэ гэж би бол үзэж байгаа юм.

Хоёр дахь миний зарчмын асуудал нь Засгийн газар энэ хавараас эхлээд шийдвэр гаргаад аливаа төрлийн татвар, төлбөрийг нэмэгдүүлэхгүй гэж шийдвэр гаргасан гэж би ойлгож байгаа. Гэтэл өнөөдөр парламент татвар нэмэх асуудлыг, өнөөдөр энэ гаалийн татварыг нэмэх асуудлыг ярьж байгаа шүү дээ.

Тийм учраас үндэсний үйлдвэрлэлээ тариаланчдаа миний хувьд тариалан бүхий бүс нутгийн сонгогдсон гишүүний хувьд 100 хувь дэмжиж байгаа. Гэхдээ нөгөө талдаа ард иргэдээ бодсон ийм хамгийн боломжит дундын шийдвэрийг гаргаж өгөх талаар энэ дээр ямар саналтай байгаа вэ? Засгийн газар. Энэ ер нь болох уу, эсвэл ямар нэгэн өөр хүндрэл байна уу, эсвэл өөр гарц гаргалгаа байна уу гэдгийг л би асууя гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Засгийн газар Улсын Их Хурлын баталсан төсвийн хүрээнд л хэрэгжүүлж байгаа.

Үнэхээр гурил өөрөө нийгмийн маш тогтвортой байдлыг хангах гол стратегийн бараа, хүнс гэдэг нь тодорхой. Энэ хэлэлцүүлгээр улам л тодорхой болж байна. Иймд бид 2026 оныхоо төсөв дээр энэ бодлогыг оруулж ирнэ. 2025 оны түвшинд үнийг тогтвортой барих нөөц хангалттай бүрдсэн, бүрдүүлж чадсан.

Тэгэхээр 2026 онд төсөв дээрээ бид улаан буудайн нөөц болон гурилын үнийн тогтвортой байдлыг хангах энэ бодлогыг бид оруулж ирнэ. Тэгж байж энэ асуудал цаашдаа явах ёстой юм байна гэдгийг.

Одоо нэгдүгээрт эн тэргүүнд бид улаан буудайн тариалалтыг идэвхжүүлэх, эхлүүлэх, сэдэлжүүлэх ийм зайлшгүй шаардлага байна. Нэгэнт улаан буудайн тариалалт өөрөө өөр таримал руу шилжчихвэл технологийн, техникийн их айхтар том өөрчлөлтүүд явдаг. Үүнийг эргүүлэх гэдэг өөрөө 4, 5 жилийн нөр их цаг хугацаа шаардсан ийм ажил болж хувирдаг.

Тэгэхээр яг эргэлтийн цэг дээр ирчхээд байгаа. Энэ байдлыг л их онцгой анхаарах нь чухал байна даа.

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Батбаатар:** Өнөөдөр ингээд гаалийн албан татвартай холбоотой хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Энэ импортоор

орж ирж байгаа гурилыг гаалийн татвартай болгох асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байна гэж хэлэхэд их хэцүү нөхцөл байдалтай санал хураалт хийх гэж байна шүү дээ.

Яагаад вэ гэхээр Улсын Их Хурлын нэг бүтцийн намын бүлэг нь 118 дотроо багтдаг намын бүлэг нь огт суугаагүй байж байна.

Хоёрдугаарт, Засгийн газраас оруулж ирж байгаа гэж байгаа. Засгийн газраас оруулж ирж байгаа хэрнээ санал хураалтын Их Хурлын чуулганы ирцэд орсон Засгийн газрын сайдууд одоо энэ хуралд орж ирэхгүйгээр эсрэг санал өгөх гэж байна.

Тэгэхээр энэ Засгийн газраас оруулж ирж байна гэж бас бодож болохгүй болчихоод байгаа юм. Энэ бол одоо гурилын үнэ ханш ямар байх вэ, газар тариалан ямар байх вэ. Хүмүүсийн энэ хуулийг өөрчилсөнтэй хамааралтайгаараа ядуурал, амьдралын түвшинд яаж өөрчлөлт оруулах вэ. Энэ дээр Ардын нам шийдвэр гаргах гэж байна. Санал хураалтад гишүүд нь оролцох гээд сууж байна.

Энэ намар, өвөл ирэх жилийн төсөв хэлэлцэж байх үед иргэдийн амьдрал ахуй, гурил, газар тариалан, амьжиргаа, инфляц гээд ярих үед Ардын намын бүлэг өнөөдөр өгсөн санал хураалтынхаа улс төрийн хариуцлагаа үүрэх болно. Зөв байсан юм уу, буруу байсан юм уу гэдгийг.

Засгийн газарт хамтарч байгаа сайдууд нь эсрэг санал өгч байгаа ийм тохиолдолд үүнийг Засгийн газрын бодлого гэж хэлэх арга алга. Тийм болохоор та бүхэн санал хураалт дээрээ бодно биз дээ. Энэ бол эрх барьж байгаа намын асуудал.

Гэхдээ Ж.Энхбаяр сайд яриад байна. Засгийн газар үнийн зохицуулалтуудыг хийнэ. Баруун бүсэд ч байдаг юм уу, тухайн бүс нутгаар боомтоор орж ирэх татвар дээр маневр хийгээд тухай тухай үнийн зохицуулалтуудыг нь хийнэ. Тээврийн зардал дээр нь анхаарна гээд. Энэ зүйлүүдээ хийж чадах боломж нь байгаа юм уу гээд.

Дээрээс нь Их Хурлын даргын ч байдаг юм уу, Байнгын хорооны ч байдаг юм уу энэ ажлын хэсгүүд байгуулагддаг. Ажлын хэсгүүд болон ер нь яам, Тамгууд дээр явж байгаа энэ төсөв төлөвлөгөө, хуулийн өөрчлөлтүүдтэй явж байгаа зүйлүүдийн мэдээллийг урьдчилан Их Хурлын гишүүдэд болох чинээгээр нь анхаарал тавьсан үед нь өгч байвал их сайн байна.

Явсаар байгаад Их Хурал дээр орж ирээд Үндэсний аюулгүй байдал, геополитик гэдэг ийм зүйлийг тулгаж оруулж ирж гарцаагүй кноп дарах ёстой гэдэг ийм зүйл рүү тулгалт орж ирдэг ийм байдалтай болж эхэлж байна.

Их Хурлын гишүүдийн бүрэн эрх бол аливаа мэдээллийг төр, Засгийн газрын бүх байгууллагаас чөлөөтэй авах эрх байдаг. Энэ эрхийг нь хангах тал дээр анхаарч байхгүй бол манай сайд нар болон магадгүй Их Хурлын ажлын хэсгийнхэн болон энэ дээрээ их учир дутагдалтай явж байна шүү гэдгийг яримаар байгаа юм. Энэ дээрээ анхаарал тавьж байх нь бас бид нарын хувьд зүйтэй байх.

Тэгээд баруун бүсийн тухай хүмүүс их асууж байна. Тэр үнийн зохицуулалтыг татварын бодлогоороо Засгийн газар өөр дээрээ шийдэж чадах юм уу? Их Хурлаар оруулахгүйгээр.

Ер нь цааш цаашдаа энэ бодлогын асуудлаа нэг мөр зарлаад үйлдвэрлэл эрхлэгч болон хэрэглэгчдэдээ нэг нэгдсэн сигналаа байнга өгдөг... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Баруун бүс дээр хүн амын тоо жигнэсэн дундаж, одоо нөгөө хэрэглээний хэмжээ тогтоогдчихсон байгаа. Энэ хэмжээгээр квотыг нь олгоод нэгдүгээрт тээвэр дээр нь дэмжлэг үзүүлж болно.

Хоёрдугаарт, яг тэр квотоор баруун бүс тодорхой яг нэрд заасан тэр аймгуудад нийлүүлэх импортлох аж ахуйн нэгжүүд дээр хөнгөлөлттэй зээл олгох маягаар тэр татварынх нь зөрүүг нь дотоод тарифын бус, татварын бус дэмжлэгээр үзүүлээд явчхаар үнийн тэгш байдлыг хангах ийм арга замууд байна.

Нөгөө талаас баруун бүсийн тариалан гэж их чухал зүйл байгаа юм. Гол хуучин тулгуур нь энэ Баруунтурууны сангийн аж ахуй. Үүнийг яаралтай сэргээх, босгох том бодлогыг оруулж ирнэ.

Баруунтурууны сангийн аж ахуй баруун бүсийн газар тариаланг сэргээх бодлогыг 2026 оны төсөвт оруулна. Энэ хүрээнд техникийн болон урт хугацааны дэмжлэгийн бодлогыг хамт оруулж ирнэ. Ингээд нэг дэмжигдээд нэг талдаа тарифаараа тариалангаа хамгаалаад, дотооддоо үйлдвэрлэлээ дэмжих бодлогыг оруулаад ирэхээр хаана хаанаа эвтэйхэн болох болов уу.

Энэ бололцоог ашиглаад Баруунтурууны сангийн аж ахуй тариаланчдын тавьсан асуудал шийдэгдсэн шүү. Сангийн яамтайгаа, Б.Жавхлан сайдтайгаа бид зөвшилцөөд байгаа нөөцийн хүрээнд тэр ургацын үзүүлсэн тэр зээлийн хүүгийн алдагдлын тодорхой хэмжээн дээр шийдвэрлэх юм тариаланчдынхаа тавьсан хүсэлтийн дагуу шийдэгдэж байгаа гэдгийг бас мэдэгдээдэхье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

**Б.Батбаатар:** “Атрын-III” аяныг Иргэний зориг ногоон намаас төлөөлөл орж Засгийн газар тэргүүлж байх үедээ анх эхлүүлсэн байдаг.

Тийм учраас энэ хуулийн өөрчлөлтийг дэмжиж байгаа. Тэрийгээ дахин илэрхийлье.

Энэ хууль зөвхөн газар тариалан, гурилын асуудал байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ бүсчилсэн хөгжлийн Засгийн газрын зорилгын хүрээнд бүсчилсэн хөгжил чиглэлээр тэр газар тариалан эрхлэх боломжгүй аймгуудад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тэр чиглэлийн үйлдвэрүүд, мал аж ахуй, энэ чиглэлийн хөтөлбөр бэлдэж байгаа зүйл байна уу гэдгийг бас давхар тодруулчихмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен гишүүн нэмж хариулъя.

**Б.Бейсен:** Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Өнөөдөр Ардчилсан намын гишүүд яагаад ирэхгүй байна гээд сая манай Т.Аубакир гишүүн бас намайг магтаад байх шиг байна. Гишүүд нэг юм ойлгочих хэрэгтэй байна. Гүйцэтгэх засаглалын тэргүүн нь парламентын дээгүүр гарчхаад гишүүдийн үг хэлэх эрхэд халдаад ингээд байхаар нь бас гомдсон тал бий.

Тэгээд үүнийг одоо Ерөнхий сайд гишүүдтэй хэнийг дуудаад уулзаад учир олчихмоор юм. Үнэхээр та бүгд мэдэж байгаа биз дээ. Гишүүдийн бүрэн эрхэд халдаж байгаа.

Гурилын асуудлаар ийм асуудал байгаа. Өнгөрсөн 4 жилд сая Их Хурлын дарга ярилаа. Яг тэгж нэмэгдсэн. Гурилын үнэ. Тэгэхдээ гурилын үйлдвэрүүд бас монополын эрх эдлээд тухайн үедээ Монгол Улсын Засгийн газраас Б.Жавхлан сайд мэдэж байгаа. 13 төрлийн хөнгөлөлт үзүүлсэн. Халаалт, цахилгаан, НӨАТ, тэгээд импортын татвар, хөнгөлөлттэй зээл, ажил олгогч. Бүгдээс нь чөлөөлсөн шүү дээ. Тэгсэн мөртлөө нэм... /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Б.Бейсен гишүүн 1 минут.

**Б.Бейсен:** Тэгэхээр Монгол Улсын гурилын хэрэгцээ 232 мянган тонн юм байна. Улаан буудайн хэрэгцээ 323 мянган тонн.

Алслагдсан бүс нутагт яах аргагүй нэмэгдээд байгаа. Булган сум гэхэд 150-иас 200 мянган төгрөгөөр очиж байна шүү дээ. 50 килийн гурил. Нүүрс гэхэд сая 500 мянган төгрөгөөр очиж байна.

Тэгэхээр энэ дээр гаалийн татвар дээр анхаараад Б.Жавхлан сайд хөнгөлөлт үзүүлэхгүй бол үнэхээр хүнд байдалд тусах юм. Баруун 5 аймгийн хувьд.

Нөгөө талаар сая сайд ярилаа. Баруунтурууны сангийн аж ахуйгаа сэргээхгүй бол энэ асуудал цаашдаа номоор нь явахгүй байх гэсэн асуудал байна. Тариалалт 57 хувиар буурч байхдаа ер нь энэ дээр анхаарахгүй бол одоо тариалалт нэмэгдсэнээр дотоодын гурил, тэжээл үйлдвэрийн ашиг тус нэмэгдэнэ шүү дээ. Энэ дээр бас анхаарч ажиллах нь зөв байх гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Б.Бейсен гишүүн үг хэллээ.

Б.Бейсен гишүүн ээ, над дээр өнөөдрийг хүртэл ямар нэгэн байдлаар хэн нэгэн хүнээс юм уу, аль нэг намын бүлгээс бичиг ирээгүй. Шаардлага тавиагүй. Тэр асуудлыг тэгж шийдээч ээ, энд ийм асуудал боллоо, үүнийг ингэж анхаараач ээ гэдэг байдлаар ерөөсөө хэн ч хандаагүй байгаа.

Би өөрөө хэвлэлээс олж хараад л хүмүүсийн хооронд ийм асуудал үүсжээ л гэдэг байдлаар л хандаад л явж байна.

Тэгэхээр энэ дээр та хэд маань бас их зөв ойлгох хэрэгтэй. Миний хувьд, Их Хурлын даргын хувьд парламентын дотоод эв нэгдлийг хангах, Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хангаж өгөх, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд хоорондоо харилцан хүндэтгэлтэй асуудлыг мэргэжлийн түвшинд авч явдаг байх гэх мэт олон зарчмуудыг барьж ажиллаж байгаа.

Эрх нь зөрчигдсөн юм уу, ямар нэгэн байдлаар асуудал, гомдол санал байгаа бол албан ёсоор. Та сая бас хэллээ. Ёс зүй дэгийн байнгын хороо гэж албан ёсоор асуудал хариуцаж байж байдаг Байнгын хороо байна. Улсын Их Хурлын дарга, даргын дэргэдэх зөвлөлд бас асуудал хандах боломж нөхцөлүүд байгаа. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл хандаагүй байна л даа.

Тэгэхээр үүнийгээ хэдүүлээ их тийм ялгаж салгахгүй бол бас болохгүй шүү. Улсын Их Хурлынхаа дотоод үйл ажиллагааг олон нийтдээ бас зөв харагдуулах ёстой. Олон нийтээс сонгогдсон. Бүгдээрээ үүрэг, хариуцлага хүлээж байгаа гишүүд маань бүх талдаа ухамсартай хандах ёстой гэдэг дээр л байр суурь байгаа.

Үүнийг бас хэлэх нь зүйтэй байх. Асуудал хөндөгдсөн учраас.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хороодоос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “04 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “05 дугаар сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн.

Энэ саналтай холбоотой үг хэлэх гишүүд байгаа юу? С.Бямбацогт сайд.

**С.Бямбацогт:** Энэ санал дээр Төсвийн байнгын хороон дээр би уг нь энэ баруун бүсийг, баруун аймгуудыг гурилын татвараас чөлөөлчихье. Төвийн бүс нутагтаа гурил, гурилын үйлдвэрүүдээ газар тариаланчдаа дэмжээд татвартай болдог юм байгаа биз.

Төвийн бүсээс баруун аймгууд руу гурил тээвэрлэхэд маш өндөр зардалтай байна. Тийм болохоор түүнтэй холбоотойгоор чөлөөлье гэсэн санал гаргасан боловч, зарчмын зөрүүтэй санал гаргасан. Байнгын хорооны дарга хураалгаагүй.

Сая манай Б.Батбаатар гишүүн, Х.Булгантуяа гишүүд баруун бүсийн алслагдсан аймгуудын зовлонг бас ярьж байна. Т.Аубакир гишүүн, Б.Бейсен гишүүн гээд.

Яах аргагүй Улаанбаатараас холдох тусмаа бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр болдог. Гурил будаа, бензин шатахуун, тог цахилгаан, даавуу даалин, хувцас хунар гээд бүгд өндөр үнэтэй болдог. Нүүрс.

Нөгөө талдаа холдох тусмаа орлого нь бага болдог. Нөгөө зарж борлуулж байгаа мал нь хямдхан, мах нь хямдхан, арьс шир нь хямдхан, төмс, хүнсний ногоо, тариалан нь хямдхан. Ингээд орлого багатай, зардал өндөртэй байдаг болохоороо үүнээсээ болоод сая Х.Булгантуяа гишүүний ярьж байгаа баруун аймгуудын иргэдийн амьдрал ядуу байгаа юм.

Улсын дунджаар ядуурал 27 хувьтай байхад Говь-Алтай аймаг 42 хувьтай, Ховд аймаг 39 хувьтай байгаа нь тэр ард иргэд нь залхуу, ажил хийдгүйнх биш ээ. Хийгээд хийгээд, зүтгээд зүтгээд яалт ч үгүй тэр алслагдсан аймгийн зовлон, алслагдсан бүс нутгийн зовлон бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр, орлого багатай зардал өндөртэй. Үүнтэй л холбоотой юм.

Үүнийг л төр зохицуулах ёстой. Үүнийг төр зохицуулахдаа татварын болон бусад зохицуулалтаар зохицуулах ёстой.

Энэ үүднээсээ бид гурилын татварыг ялгавартай болгочхоо. Төвийн бүсдээ татвартай байж болно. Баруун бүсдээ татваргүй болъё гэдэг асуудлыг 2023 оны 12 сард ярьсан юм. Харамсалтай нь тухайн үед сайд нь хийхгүй байсаар байгаад өнөөдөр нийтдээ татваргүй болчихоод одоо буцаагаад татвартай болгох асуудал ярьж байгаа.

Тэр үед гурилын үнэ баруун бүсэд 120 мянга, 140 мянга хүрч байсан. Алтан тариан гурил 150 мянга. Тэгвэл татваргүй болсноороо 80 мянга болж буурсан юм. 80 мянга болж. Баруун бүс нутагт. Одоо ингээд татвартай болохоор буцаагаад 140 мянга, 150 мянга болох вий. Тийм болохоор бид юу гэдэг юм нуухыг нь авах гээд нүдийг нь сохолно гэдэгтэй адилхан нэг болохоор болно гээд, нэг болохоор болохгүй гэж туйлширмааргүй байгаа юм.

Сая Ж.Энхбаяр сайд ярьж байна. Баруун бүс нутагт бид зохицуулалт хийнэ ээ гэж.

Тэгэхээр Ж.Энхбаяр сайд үнэхээр энэ зохицуулалтыг хийж болно. Хийх ёстой. Бусдаар тээврийн зардал дээр нь татаас өгөх байдлаар биш татварыг нь л чөлөөлмөөр байгаа юм. Баруун бүсийн. Үүнийг л анхаараад өгөөч ээ гэж хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт нь, баруун бүс нутагт газар тариалан эрхлэх боломжийг нь дэмжиж өгөөч ээ. Эрдэнэбүрэнгийн услалтын систем байгуулна гээд 2 мянган га услалтын систем та алга болгосон. Баруунтурууны услалтын систем, элеваторын асуудал. Баруунтуруунд сая та хэллээ. Газар тариалах бололцоотой гээд. Тэгвэл тэр элеватор барих тийм тодорхой хөнгөлөлттэй зээл байсан. Тэр бас алга болсон. Бас л та хураагаад авсан.

Тэр Баруунтурууны газар тариалан эрхлэх гэж байгаа хамгаалах хашаа саравч. Тэр бас алга болсон. Ийм байж байхад яаж тэр Баруунтуруунд газар тариалан эрхлэх юм бэ? Тийм болохоор та сая хэлж байна. Баруун бүс нутагтаа газар тариалан эрхлэхийг дэмжинэ гэж байгаа бол тэр хэрэгжиж байсан төслүүдийг хэрэгжүүлээд өгөөч ээ. Эрдэнэбүрэнгийн услалтын систем. Дээрээс нь Баруунтурууны тэр элеватор, Баруунтурууны газар тариаланг хашсан хамгаалсан газар тариалангийн эрхлэгчдийн тэр хашаа. Энэ бүгдийг нь буцаагаад шийдээд өгөх юм бол тэнд газар тариалан эрхлээд, түүнийг дагаад гурилын үйлдвэр дэмжээд өгвөл баруун бүсэд гурил хямдрах бололцоо байгаа.

Тэгээд аль алиныг нь л хийчихмээр байна. Үүнийг л одоо бас нэг анхааралдаа аваад явчихвал бас зөв байгаа юм. Тэгээд Байнгын хороон дээр уг нь бас баруун бүс нутгийг татвараас нь хөнгөлж чөлөөлье гэсэн санал гаргасан боловч харамсалтай нь санал хураагдаагүй юм. Тийм болохоор цаашдаа хуулийг хэрэгжүүлэх явцдаа үүнийг бүгдээрээ анхааръя л гэдгийг хэлье.



**Д.Амарбаясгалан:** С.Бямбацогт сайд зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж үг хэллээ.

Л.Соронзонболд гишүүн нэр ирсэн байна. Энэ асуудал дээр хэлэх билүү? Дараачийнх нь уу?

Тэгвэл төслийн 2 дугаар зүйлийн “04 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “05 дугаар сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх.

Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

51.6 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Энэ хууль эцэслэн батлагдсан тохиолдолд хэрэгжиж эхлэх хугацаа учраас бас чухал л даа.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй санал. М.Бадамсүрэн гишүүний гаргасан санал байгаа.

1.Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээллийн 6 сарын дунджаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын үнэ өссөн тохиолдолд гурилын импортын албан татварыг чөлөөлөх хуулийн төслийг нэн даруй өргөн мэдүүлэх болон малын тэжээлийг импортын барааны гаалийн албан татвараас 5 хувь чөлөөлсөн харилцааг хэвээр үлдээх асуудлыг тусгасан Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн боловсруулж, хэлэлцүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

Санал гаргасан гишүүн М.Бадамсүрэнд үг өгье.

**М.Бадамсүрэн:** Ард иргэддээ хямд гурилын хэрэгцээг нь хангах нэг талдаа, нөгөө талдаа аж ахуйн нэгжүүд үндэсний үйлдвэрлэл тариаланчдаа дэмжих гэдэг энэ хоёр бодлогын хамгийн дундын зөв хувилбар бол энэ болов уу гэж би бодож санал дэвшүүлсэн юм.

Яагаад гэхээр үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нь зөв өө, тариаланчдаа дэмжих нь зөв. Цаг хугацаа тулчхаад байгаа. Тэгвэл үүнийг Улсын Их Хурал баталсан тохиолдолд дахиад болзолтойгоор буюу 6 сарын дунджаар үнэ өсвөл дахиад тэглэх асуудлаа оруулаад ирэх энэ зохицуулалтыг л Их Хурал үүнийг дэмжсэн тохиолдолд дагалдуулж гаргаж өгөөч ээ л гэдэг хүсэлт байгаа юм.

Яагаад гэхээр аж ахуйн нэгжүүд үнэхээр монопол байдлаар үнээ нэмээд байгаа бол, үгсэн хуйвалдаад байгаа бол энэ дахиад 6 сарын дараа энэ чинь дахиад тэглэгдэнэ шүү гэдэг болгоомжлол тэд нарт бас байх ёстой шүү дээ. Төр юм бол ийм механизмаа бүрдүүлж өгөхөд энэ юу нь болохгүй байгаад байгаа юм болоо л гэж би бодоод байгаа юм.

Тэгээд яах вэ, хоёр хамтарсан Байнгын хороо дэмжээгүй. Тэнд тэгэхдээ олон гишүүд бүртгүүлчхээд гараад явсан болохоор дэмжигдээгүй ээ гэж би ойлгож байгаа.

Ер нь энэ бол үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж байгаа. Нөгөө талдаа ард иргэдээ хамгаалж байгаа ийм дундын хувилбар шүү гэдгийг л дахин хэлье. Үүнийг хэрвээ тогтоолын төслийг гаргахыг дэмжсэн тохиолдолд би хувь гишүүнийхээ хувьд гаалийн албан татвартай холбоотой энэ орж ирж байгаа хуулийн төслийг дэмжинэ.

Үүнийг дэмждэггүй тохиолдолд дэмжих боломжгүй ээ гэдгээ бас илэрхийлье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хороон дарга нар үг хэлэх боломжтой. Нөгөө Байнгын хорооноос оруулж ирсэн учраас. Тэгээд Байнгын хорооны дарга байхгүй байна.

Б.Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** М.Бадамсүрэн гишүүний тавьж байгаа санал нь зөв өө. Тэгэхдээ нэг асуудал байна.

Жишээлбэл, дотоодын тариалалт байхгүй болчихоод, дэлхийн аюулгүй байдалтай холбоотой дайн байдал ихэсчхээд гаднаас гурил орж ирэхгүй бол яах юм. Асуудал. Дотоодын үйлдвэрлэлээ бид тариаланчдадаа ингээд хязгаарлацихвал бас хүндрэл асуудал үүсэх гээд байгаа байхгүй юу.

Бид Хүнс, хөдөө аж ахуйн яамныхантай бас ярьж байж энэ асуудлыг хэлсэн. Тэгэхдээ баруун аймгийн тэр гурилын асуудлыг сая С.Бямбацогт даргын ярьдгаар чөлөөлөх асуудал, аль эсвэл наашаа тэр оруулж байгаа компани нь яг баруун аймгийн хэрэгцээг нь гаргаад импортыг нь тогтоогоод. Хэрэгцээг нь. Квот тогтоогоод. Наашаа оруулж ирсэн компани байвал хар дансанд оруулаад цаашдаа тийм квот зөвшөөрөл өгөхгүй талын асуудлыг бас Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам барих нь зөв байх гэсэн саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Санал хураалт. Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

41.1 хувиар дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Энэ чинь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хамт хэлэлцэх ёстой. Тийм ээ. Хоёр байнгын хороонд шилжүүлнэ. /алх цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

**Хуралдаан 3 цаг 35 минут үргэлжилж, 13 цаг 35 минутад өндөрлөв.**

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**